

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 06 дугаар сарын 23-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-22
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	23-110
1.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж нарын 36 гишүүн 2026.06.09 -ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	25-34
2.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 71 гишүүн 2025.09.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг , үргэлжилнэ/	34-68
3.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/	68-91
4.Эрүүл мэндийн салбарын санхүүжилт, эмийн үнэ, хүний нөөц, цалин хөлсний талаарх Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсох	91-101
5.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны 2025 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Боловсролын сайдын мэдээллийг сонсох	101-110

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
06 дугаар сарын 23-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Ганзориг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 33 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: О.Батнайрамдал, Д.Бум-Очир, Ш.Бямбасүрэн, Ж.Галбадрах, А.Ганбаатар, Д.Ганмаа, М.Ганхүлэг, Б.Хэрлэн, С.Эрдэнэбат;
Чөлөөтэй: Ц.Баатархүү, Ж.Баясгалан, Б.Түвшин, Л.Энхнасан.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа хэлэлцэх асуудлын дарааллын 1 дүгээрт орсон “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл, 4 дүгээрт орсон Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатаас Боловсролын сайдад хандаж тавьсан Боловсролын салбарын багш, ажилчдын нийгмийн баталгааны талаарх асуултын хариуг хэлэлцэх асуудлуудыг тус тус хэлэлцэх асуудлаас хасах горимын санал гаргав.

П.Ганзориг: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	5
Бүгд:	16

68.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Мөн Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа хэлэлцэх асуудлыг дарааллын 7 дугаарт орсон Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг 1 дүгээрт, 6 дугаарт орсон Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг 2 дугаарт хэлэлцэх горимын санал гаргав.

П.Ганзориг: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	5
Бүгд:	16

68.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж нарын 36 гишүүн 2026.06.09 -ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Боловсролын сайдын зөвлөх П.Оюунаа, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, мөн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав, Боловсролын эдийн засаг, санхүүгийн бодлогын газрын дарга А.Мөнх-Оргил, Дээд боловсролын бодлогын газрын дарга Б.Түмэндэлгэр, Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга Л.Ганбат, Боловсролын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Тамир, Боловсролын зээлийн сангийн Дотоод зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламжийн хэлтсийн дарга Ц.Доржсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, Б.Мажигсүрэн, референт Ц.Долгормаа, Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Д.Рэгдэл, П.Ганзориг нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Боловсролын сайд Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан, О.Саранчулуун, Д.Рэгдэл нар үг хэлэв.

П.Ганзориг: 1.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Сарнай Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 71 гишүүн 2025.09.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг , үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, Эрүүл мэндийн инновац, технологи, цахим хөгжлийн хэлтсийн шинжээч Д.Ганзориг, Тусламж үйлчилгээний багц, зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Янжиндолгор, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Анар, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Санхүү, төсвийн судалгааны газрын мэргэжилтэн Д.Долгорсүрэн, Татварын бодлогын газрын мэргэжилтэн Ж.Төрболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Бизнесийн орчны бодлогын газрын дарга Л.Балчинлуvsан, Боловсролын яамны Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга М.Цогзолмаа, мөн яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Э.Чойсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Х.Майцэцэг, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Урьдчилан сэргийлэх албаны хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Д.Будзаан, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, мөн газрын улсын байцаагч Б.Отгонбаяр, Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл, мөн газрын Хяналт хорио цээрийн газрын гаалийн улсын байцаагч Л.Амартүвшин, Стандарт, хэмжилзүйн газрын тамхины асуудал хариуцсан мэргэжилтэн Ч.Пүрэвдулам, Гаалийн ерөнхий газрын төв лабораторийн дарга С.Цэрэнчимэд, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Суурин төлөөлөгчийн газрын Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэн С.Болормаа, судлаач Н.Ганбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, Б.Мажигсүрэн, референт Ц.Долгормаа, Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

Хуулийн төслийн талаарх тусгайлсан ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан, О.Саранчулуун, М.Нарантуяа-Нара, А.Ариунзаяа, О.Номинчимэг нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Э.Чойсүрэн, Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл нар хариулж, тайлбар хийв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

П.Ганзориг: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Б.Баярбаатар, Х.Баасанжаргал, Д.Бум-Очир, А.Ганбаатар, Б.Жаргалан, М.Нарантуяа-Нара, П.Сайнзориг, А.Ундраа, С.Цэнгүүн, Л.Энхнасан /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 3.1.12 дахь заалтын “тоног” гэснийг хасаж, мөн заалтын 3.1.13, 3.1.14 дэх заалтыг нэгтгэн “3.1.13” дахь заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.13.”татах төхөөрөмжийн эд анги” гэж татах төхөөрөмжид дагнан хэрэглэдэг хэсгийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 3
Бүгд: 17
82.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.7.16 дахь заалтын, мөн зүйлийн 5 дахь заалтын 7^{2.3} дахь хэсгийн “дагалдах хэрэгсэл, татах төхөөрөмжийн” гэснийг “түүний” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 6.8.3 дахь заалтын “байрлуулж” гэснийг “байрлуулах бөгөөд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын “6.8¹” гэснийг “6.10” гэж өөрчилж, мөн хэсгийн “Үндэсний зөвлөл” гэснийг “төв байгууллага” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 11^{1.6} дахь хэсгийн “үйлдвэр, худалдааны асуудал” гэснийг “хүнсний асуудал” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан, Төслийн 6.7.16.электрон никотин дамжуулах систем, тамхи болон гаанаас өөр төрлийн үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 17
Бүгд: 17
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан, Төслийн 6.7.16.тамхин бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд орц, найрлагад хэрэглэхийг хориглосон бодисыг холбогдох техникийн зохицуулалтын шаардлагаар тодорхойлно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 13
Бүгд: 17
23.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн гаргасан, Төслийн “6.7.16.тамхи, татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, татах төхөөрөмжийн эд ангид тамхи болон гаанаас өөр төрлийн үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 14
Бүгд: 17
17.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

9.Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижирийн гаргасан, Төслийн 6.7.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.7.16.тамхи, татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, татах төхөөрөмжийн эд анги нь тамхинаас өөр төрлийн үнэр, амт оруулагч бодис, бэлдмэл нэмсэн байх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы гаргасан, Төслийн холбогдох зүйлд дараах агуулгатай хэсэг нэмсүгэй:

“6.7.17.2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэнд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүнийг худалдахыг хориглоно. Энэ хэсэгт заасан этгээдэд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүн худалдсан, нийлүүлсэн, үнэ төлбөргүй олгосон этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 10
Бүгд: 17
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

11.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 7².3 дахь хэсгийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 16
Бүгд: 17
5.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн “дэмжээгүй” санал “дэмжсэн” гарсан тул санал хураалтыг дэмжээгүйгээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3.1.1 дэх заалтыг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.1.“тамхин бүтээгдэхүүн” /цаашид “тамхи” гэх/ гэж тамхины навч, ургамлыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түүхий эд болгон үйлдвэрлэсэн, никотин, бохь, эсхүл химийн бусад бодис агуулсан татах төхөөрөмж ашиглаж, эсхүл

ашиглахгүйгээр хэрэглэх зориулалттай, эмийн бүртгэлд бүртгэгдсэн тамхинаас гаргах эмээс бусад дараах бүтээгдэхүүнийг:

3.1.1.а.тамхины түүхий эд, задгай тамхи, татаж хэрэглэх зориулалттай навчин, сигар, дүнсэн, янжуур тамхи болон тэдгээртэй адилтгах бусад тамхи;

3.1.1.б.цахилгаан халаагч болон бусад төхөөрөмжөөр шатаахгүйгээр сорж татах зориулалттай халаадаг тамхи;

3.1.1.в.никотин, амт, үнэр оруулагч болон химийн бусад бодис агуулсан, эсхүл агуулаагүй шингэнийг цахилгаан хэрэгслээр ууршуулан татах, эсхүл түүнтэй адилтгах аргаар хэрэглэх зориулалттай электрон тамхи;

3.1.1.г.усан хоолойгоор татах зориулалттай тамхи;

3.1.1.д.үнэрлэх, сорох, зажлах, аманд уусгах, биед наах болон татахаас бусад аргаар хэрэглэх зориулалттай, никотин агуулсан, эсхүл агуулаагүй тамхин бүтээгдэхүүн.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20-д заасны дагуу дээрх заалтаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Л.Энхнасан нарын гаргасан саналыг хуралдаан даргалагч танилцуулж, ажлын хэсгийн гаргасан санал дэмжигдсэн тул бусад санал дэмжигдээгүйд тооцож, тэдгээр саналаар санал хураалт явуулахгүй болно.

Дээрх заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нар үг хэлэв.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 3.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.11.“тамхи татах зөвшөөрөгдсөн цэг” гэж энэ хуулийн 3.1.1.а-д заасан бүтээгдэхүүн хэрэглэх цэг болон энэ хуулийн 3.1.1.б болон 3.1.1.в-д заасан бүтээгдэхүүнийг хэрэглэх цэгээс бүрдэх бөгөөд эдгээрийг тусад нь, эсхүл хооронд нь тусгаарлан зохион байгуулсан, тамхи хэрэглэх зориулалтаар тусгайлан бэлтгэсэн талбай, агааржуулалтын тоног төхөөрөмжөөр тоногдосон өрөөг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 9
Бүгд: 17
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.1.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 16
Бүгд: 17

5.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.2.Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

5.2.1.тамхины хэрэглээ болон түүнээс шалтгаалах өвчлөл, нас баралтыг бууруулах чиглэлээр үндэсний бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг хангах;

5.2.2.тамхины хяналтын бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн болон орон нутгийн байгууллага, эрүүл мэндийн байгууллага, бусад холбогдох байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

5.2.3.тамхин бүтээгдэхүүний хэрэглээ, тархалт, эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, өвчлөл, нас баралтын талаарх мэдээлэл, статистикийг цуглуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх, тайлагнах;

5.2.4.тамхины хамаарлаас гарах зөвлөгөө, эмчилгээ, сэтгэлзүйн дэмжлэг, никотин орлуулах эмчилгээ болон бусад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандартыг батлах, хэрэгжилтийг зохион байгуулах;

5.2.5.тамхины хамаарлаас гарах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

5.2.6.тамхины хэрэглээ болон тамхины хяналтын талаар хүн амд чиглэсэн сургалт, сурталчилгаа, эрүүл мэндийн боловсролын үйл ажиллагааг зохион байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.3.1 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8

Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.3.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.3.2.бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын орчин дахь тамхины хяналтыг боловсролын салбарын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээд хэрэгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.3.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.3.3.мэргэжлийн байгууллагын судалгаанд үндэслэн бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын орчин дахь тамхидалтыг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.3.4 дэх заалтын “бүх шатны боловсролын” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлд заасан боловсролын байгууллага болон бүх түвшний боловсролын сургалтын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.4.3 дахь заалтын “үр дүнтэй” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.5.1 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 13
Бүгд: 17
23.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.6 дахь хэсгийн “хүнс, хөдөө аж ахуйн” гэснийг “хүнсний” гэж, мөн заалтын 5.5.3, 5.6.2 дахь заалтын “заасныг хэрэгжүүлэх” гэснийг “заасан зарчмыг баримтлах” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.8.4 дэх заалтын “барилга байгууламжид” гэсний дараа “тус бүр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 9
Бүгд: 17
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 6.4.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.4.1.зурагт анхааруулга нь тамхи, тамхин бүтээгдэхүүний техникийн зохицуулалтад нийцсэн байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 10
Бүгд: 17
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

25.Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан, Төслийн 6.4.1.тамхин бүтээгдэхүүний хэрэглэгчийн савлагаа, хайрцгийн нүүрэн талын доод хэсгийн үндсэн гадаргуугийн дор хаяж 70 хувийг, мөн ар талын доод хэсгийн үндсэн гадаргуугийн дор хаяж 70 хувийг эзэлсэн тамхин бүтээгдэхүүн хэрэглэхээс үүдэлтэй өвчлөлийн үр дагаврыг дүрсэлсэн зураг болон эрүүл мэндийн анхааруулга бүхий бичвэр байршуулсан байх ёстой. Тамхин бүтээгдэхүүний савлагаан дээрх анхааруулгын бичвэр дүрслэлийг байршуулах шаардлагыг холбогдох техникийн зохицуулалтаар тодорхойлно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 15
Бүгд: 17

11.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалтын 6.7.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.7.2.энэ хуулийн 3.1.1.а-д заасан янжуур тамхи болон түүнтэй адилтгах бусад тамхи, 3.1.1.б-д заасан тамхийг нэг хайрцагт 20 ширхгээс цөөн тоогоор, эсхүл дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг 200 граммаас багаар савлах, энэ хуулийн 3.1.1.в-д заасан электрон тамхины шингэний хэмжээг 10 миллилитрээс ихээр савлах, тамхины шингэнийг дахин цэнэглэх боломжтой байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	6
Бүгд:	17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20-д заасны дагуу дээрх заалтаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан саналыг хуралдаан даргалагч танилцуулж, ажлын хэсгийн гаргасан санал дэмжигдсэн тул бусад санал дэмжигдээгүйд тооцож, уг саналаар санал хураалт явуулахгүй болно.

27.Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн заалтыг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн:	1
Татгалзсан:	16
Бүгд:	17

5.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн “2026 оны 01 дүгээр сарын 01-ний” гэснийг “2027 оны 01 дүгээр сарын 01-ний” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	8
Бүгд:	17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20-д заасны дагуу дээрх заалтаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан саналыг хуралдаан даргалагч танилцуулж, ажлын хэсгийн гаргасан санал дэмжигдсэн тул бусад санал дэмжигдээгүйд тооцож, уг саналаар санал хураалт явуулахгүй болно.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дараалал болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томьёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

П.Ганзориг: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

П.Ганзориг: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нар хариулж, тайлбар хийв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсэг, гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

П.Ганзориг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Онцгой албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 8, 9 дэх заалт:

8	Электрон тамхины шингэн	1 миллилитр
9	Аманд уусгах, зажлах зориулалттай тамхи	1 грамм

2/6.1².энэ хуулийн 4.1.2-т заасан барааны тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет нэгж	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/					
			2026 он	2027 он	2028 он	2029 он	2030 он	2031 он
1	Татаж хэрэглэх зориулалттай навчин, сигар, янжуур тамхи, тэдгээртэй адилтгах бусад тамхи	20 ширхэг	836	2,000	3,500	5,000	6,000	8,000

2	Халаадаг тамхи	20 ширхэг	836	1500	2625	3750	4875	6000
3	Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи, усан хоолойгоор татах зориулалттай тамхи	200 грамм	626	1500	2625	3750	4875	6000
4	Электрон тамхины шингэн	1 миллилитр	0	750	1312.5	1875	2437.5	3000
5	Аманд уусгах, зажлах зориулалттай тамхи	1 грамм	0	125	220	315	410	500

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20-д заасны дагуу дээрх заалтаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Л.Энхнасан нарын гаргасан саналыг хуралдаан даргалагч танилцуулж, ажлын хэсгийн гаргасан санал дэмжигдсэн тул бусад санал дэмжигдээгүйд тооцож, тэдгээр саналаар санал хураалт явуулахгүй болно.

Дээрх заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нар үг хэлэв.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “, халаадаг, шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи” гэснийг “болон янжуур тамхи, тэдгээртэй адилтгах бусад тамхи, халаадаг тамхи” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20-д заасны дагуу дээрх заалтаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Л.Энхнасан нарын гаргасан саналыг хуралдаан даргалагч танилцуулж, ажлын хэсгийн гаргасан

санал дэмжигдсэн тул бусад санал дэмжигдээгүйд тооцож, тэдгээр саналаар санал хураалт явуулахгүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Тав.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

П.Ганзориг: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 6.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтын “хоёр зуун” гэснийг “гурван зуун” гэж, мөн заалтын “хоёр мянган” гэснийг “гурван мянган” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зургаа.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг үг хэлэв.

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

П.Ганзориг: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 15
Бүгд: 17
11.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Долоо.Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Найм.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Төслийн заалтуудтай холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

П.Ганзориг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтыг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтад доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:

1/24 дүгээр бүлгийн 24.04 дүгээр зүйл:

24	24.04		Тамхи, дахин боловсруулсан тамхи, никотин агуулсан эсвэл тамхи, никотин орлуулагч агуулсан, шатаахгүйгээр сорж татах зориулалттай бүтээгдэхүүн, хүний биед никотин өгөх зориулалттай, никотин агуулсан бусад бүтээгдэхүүн.	30
			Шатаахгүйгээр сорж татах зориулалттай бүтээгдэхүүн:	0
		2404.11	Тамхи эсвэл дахин боловсруулсан тамхи агуулсан:	0

2/85 дугаар бүлгийн 85.43 дугаар зүйл:

85	85.43		Энэ бүлгийн бусад газар заагдаагүй ганцаарчилсан зориулалтын цахилгаан машин болон аппарат.	0
		8543.40.10	Олон удаагийн хэрэглээний электрон тамхи	30
		8543.40.20	Цахилгаанаар ажилладаг ууршуулж татах төхөөрөмж	30
			Эд анги:	
		8543.90.10	Электрон тамхи болон түүнтэй төстэй цахилгаанаар ажилладаг ууршуулж татах төхөөрөмжийн	30
		8543.90.90	Бусад	30

3/96 дугаар бүлгийн 96.14 дүгээр зүйл:

96	96.1 4	9614.00.00	Тамхины гаанс (гаансны толгой орно) болон сигар, янжуур тамхины соруул, тэдгээрийн эд анги.	30
----	-----------	------------	---	----

" гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20-д заасны дагуу дээрх заалтаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Х.Ганхуяг нарын гаргасан саналыг хуралдаан даргалагч танилцуулж, ажлын хэсгийн гаргасан санал дэмжигдсэн тул бусад санал дэмжигдээгүйд тооцож, тэдгээр саналаар санал хураалт явуулахгүй болно.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Ес.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

П.Ганзориг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"1 дүгээр зүйл.2026 оны ... дугаар сарын ...-ны өдрийн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд:

1.1.Тамхины хяналтын тухай хуулиар стандарт, хэм хэмжээний акт батлах эрх олгосон Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагууд, Стандартчиллын төв байгууллага тус хуульд нийцүүлэн холбогдох дүрэм, журам, стандарт, загварыг Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө шинэчлэн баталж, мөрдүүлнэ.

1.2.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан тамхин бүтээгдэхүүн, түүний орц найрлагыг таних, шалгах зориулалттай лабораторийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

1.3. Тамхины хамаарлаас гаргах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах төлөвлөгөөг Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө боловсруулж, эмчилгээ үйлчилгээг хэвийн явуулах, хуулийн хэрэгжилтийг хангана.

1.4. Тамхи үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаарх Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан мэдээллийн нэгдсэн санг бий болгох, уг мэдээллийн санг холбогдох бусад мэдээллийн сантай мэдээлэл солилцдог байх чиглэлд төрийн байгууллагууд хамтран ажиллана.

1.5. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө мөн хуулиар тамхин бүтээгдэхүүнд тооцсон шинэ төрлийн тамхийг Тамхины хяналтын тухай хуулиар хориглосон байдлаар сурталчилсан зар сурталчилгааг хуульд нийцүүлэх арга хэмжээ авах, тамхи үйлдвэрлэх, импортлох, худалдаалахад зүй ёсны монопол болон давамгайл байдалтай аж ахуй эрхлэгч байгаа эсэхийг тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд

Э.Батшугар, Сангийн дэд сайд Б.Хулан, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Ч.Цэвэгдорж, Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын ахлах аудитор У.Оюунхүү, Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа, мөн газрын аудитын менежер С.Нацагдорж, А.Цогбаяр, В.Эрдэнэцогт, И.Эрдэнэцэцэг, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Р.Рэнцэнбазар, А.Энхбат, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга А.Мөнх-Оргил, Хоол үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Т.Түмэнжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга А.Даваажаргал, мөн яамны Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, мөн газрын ахлах шинжээч Ц.Эрдэнэтөгс, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ц.Ариунсанаа, Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Урьболд, Соёл, урлагийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Наранцэцэг, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Энх-Амгалан, Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга В.Батчимэг, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Л.Мөнхцэцэг, ерөнхий нягтлан бодогч С.Цогзолмаа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төрийн сангийн газрын дарга О.Хуягцогт, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, мөн хэлтсийн ахлах шинжээч Ч.Цацрал, шинжээч Б.Цагаанцэцэг, ахлах мэргэжилтэн М.Алтанхорол, Б.Баяр-Эрдэнэ, Э.Буянхишиг, А.Дэлгэрмаа, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Гантөмөр, Боловсролын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Тамир, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, мөн газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга Б.Алтанцэцэг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Бауыржан, мөн газрын Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Т.Бадрахбаяр, ахлах мэргэжилтэн Б.Гулзат, Г.Оюун, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Д.Гэрэл, мөн газрын ерөнхий нягтлан бодогч О.Содномпэрэнлэй, Бодлогын хэрэгжилтийн нийгмийн түншлэлийн газрын ахлах мэргэжилтэн С.Нямдорж, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн дарга М.Амаржаргал, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын Хүүхэд, гэр бүлийн хамгааллын бодлогын хэрэгжилтийн газрын дарга Л.Бадамцэцэг, мөн газрын ерөнхий нягтлан бодогч Н.Батбаяр, ахлах мэргэжилтэн Б.Мягмарсүрэн, Ц.Өлзийдүүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны

ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, референт Ц.Долгормаа, Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх илтгэлийг Боловсролын сайд Л.Энх-Амгалан, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, С.Зулпхар нарын тавьсан асуултад Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн дэд сайд Б.Хулан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн А.Энхбат, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга А.Даваажаргал, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёл, урлагийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Наранцэцэг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, С.Зулпхар, Б.Бейсен, Л.Энх-Амгалан, П.Ганзориг нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Эрүүл мэндийн салбарын санхүүжилт, эмийн үнэ, хүний нөөц, цалин хөлсний талаарх Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Туяа, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв, мөн газрын ахлах шинжээч Ш.Энхтуяа, Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Л.Мөнхцэцэг, Эрүүл мэндийн даатгалын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Батбаатар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дарга П.Алтанцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Ц.Долгормаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилт, эмийн үнэ, хүний нөөц, цалин хөлсний талаарх мэдээллийг Эрүүл мэндийн сайд Э.Батшугар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Б.Бейсен нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Батбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Б.Бейсен нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Эрүүл мэндийн салбарын санхүүжилт, эмийн үнэ, хүний нөөц, цалин хөлсний талаарх Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 19 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны 2025 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Боловсролын сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Боловсролын сайдын зөвлөх П.Оюунаа, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, мөн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав, Боловсролын эдийн засаг, санхүүгийн бодлогын газрын дарга А.Мөнх-Оргил, Дээд боловсролын бодлогын газрын дарга Б.Түмэндэлгэр, Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга Л.Ганбат, Боловсролын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Тамир, Боловсролын зээлийн сангийн Дотоод зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламжийн хэлтсийн дарга Ц.Доржсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Ц.Долгормаа, Н.Монголмаа, Б.Энхмаа нар байлцав.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны 2025 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг Боловсролын сайд Л.Энх-Амгалан танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын тавьсан асуултад Боловсролын сайд Л.Энх-Амгалан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Д.Рэгдэл нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны 2025 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Боловсролын сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 20 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 5 цаг 40 минут үргэлжилж, ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр 20 цаг 13 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

П.ГАНЗОРИГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 23-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
14 цаг 33 минут.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

П.Ганзориг: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн ирж, гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 53.3 хувьтай бүрдсэн тул 2026 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн Байнгын хорооны хуралдааныг нээснийг мэдэгдье. Гишүүдийн ирцийг танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай, Аюушийн Ариунзаяа, Буланы Бейсен, Хөххүүгийн Болормаа, Пүрэвжавын Ганзориг, Сархадын Зулпхар, Тогтмолын Мөнхсайхан, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Дүгэрийн Рэгдэл, Отгоны Саранчулуун, Мягмардашийн Сарнай, Ганбатын Хосбаяр, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Доржзовдын Энхтуяа, Мөнхчулууны Энхцэцэг нарын 16 гишүүн Байнгын хорооны хуралдаандаа хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдрийн байнгын хорооны хурлаар 7 асуудал хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя. 1-т Байнгын хорооны тогтоолын төсөл батална. Энэ хуулийн ажлын хэсэг батлах асуудал байж байгаа. 2-т Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, ЗГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурал /УИХ/-ын тогтоолын төслийг сонсох асуудал байж байгаа, Засгийн газар /ЗГ/ 2026 оны 6 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ мөн Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ. 3 дахь асуудал эрүүл мэндийн салбарын санхүүжилт, эмийн үнэ, хүний нөөц, цалин хөлсний талаарх Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсох асуудал байж байгаа. Энэ Бейсен гишүүнээс мэдээлэл хүсэж тавьсны дагуу энэ мэдээллийг Эрүүл мэндийн яам /ЭМЯ/-наас танилцуулж сонсохоор байж байгаа. 4 дэх асуудал УИХ-ын гишүүн С.Эрдэнэбатаас Боловсролын сайдад хандаж тавьсан боловсролын салбарын багш, ажилчдын нийгмийн баталгааны талаарх асуулгын хариуг хэлэлцэх. 5.ЗГ-т чиглэл өгөх тухай Байнгын хорооны 2025 оны 5 дугаар тогтоолын биелэлтийн талаар Боловсролын сайдын мэдээлэл сонсох асуудал байж байгаа. 6.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүд, УИХ-ын гишүүн О.Номинчимэг нарын 71 гишүүнээс 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Байнгын хороогоор явуулна. 7.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, УИХ-ын гишүүн Р.Сэддорж нарын 36 гишүүнээс 2026 оны 6 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх гээд ийм 7 асуудал байна.

Тэгээд хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу?

Ариунзаяа гишүүн. Ариунзаяа гишүүний микрофоныг нээе.

А.Ариунзаяа: Хэлэлцэх асуудалтай холбоотой 4 горимын санал байна. 2 нь хэлэлцэх асуудлаас хасах, 2 нь хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулах. Тэгэхээр тус бүрд нь санал хураалгаж өгөхийг хүсэж байна. Хасах санал 1 дүгээр асуудал буюу Байнгын хорооны тогтоолын төсөл буюу Ажлын хэсэг байгуулах тухай энэ ажлын хэсэг нь Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслөөр ажлын хэсэг байгуулах тухай байгаа. Өнгөрсөн баасан гарагт хэлэлцэх эсэхийг нь УИХ-ын чуулганаар хэлэлцээд санал хураагаагүй байгаа. Тэгэхээр санал хураагдаагүй байгаа учраас ажлын хэсэг байгуулах нь одоогоор боломжгүй байна. Ийм учраас 1 дүгээр асуудлыг хасах.

2-т, бүгдийг нь нэгмөсөн хэлчих үү. 2 дугаар санал нь юу вэ гэвэл Эрдэнэбат гишүүн томилолтоор ажиллаж байгаа. Ийм учраас Эрдэнэбат гишүүний Боловсролын сайдад хандаж тавьсан асуулгын энэ хариулт асуултын хариултыг хэлэлцэхийг хойшлуулах санал ирүүлснийг хүргэж байна Эрдэнэбат гишүүн өөрөө байхгүй байгаа учраас энэ асуудлыг буюу 4 дүгээр асуудлыг хасах ийм санал гаргаж байна.

3 дахь санал маань юу вэ гэхээр санал хураах хуулиудаа хэлэлцэх асуудлуудын эхэнд тавих саналтай байна. Ингэснээр санал хураах энэ хариуцлагатай ажлуудаа эхэнд хийгээд, тэгээд танилцах асуудлуудаа хойно нь танилцаад явъя. 1 дүгээрт хамгийн эхэнд хэлэлцэх санал маань Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эхэнд хэлэлцэх санал гаргаж байна. Энэ хоёрхон санал хураалттай. 1 үндсэн хууль болон 1 дагасан хуулийн төслөөр санал хураахаар байгаа. 2 дахь асуудлаар Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулиудыг 2 дугаар асуудлаар хэлэлцэх ийм санал гаргаж байна. Энэ дээр 24 зарчмын зөрүүтэй саналыг хураах юм. Тэгээд түүний дараагаар бүхий л энэ танилцах, сонсох асуудлуудаа энэ дарааллынх нь дагуу сонсох ийм горимын санал гаргаж байна. Баярлалаа.

П.Ганзориг: Горимын саналтай холбоотой, гаргасантай холбоотойгоор 2 тусад нь санал хураалгая гэсэн. Нэгд энэ 7 асуудлаас 2 асуудал нь холбогдох хуулийн дагуу нэг нь УИХ-аар хэлэлцэх эсэхийг нь шийдээгүй байхад ажлын хэсэг гарах боломжгүй учраас хасах ёстой. 2 дахь нь Боловсролын сайдад энэ боловсролын салбарын багш ажилтнуудын талаар, нийгмийн баталгааны талаар асуулга Эрдэнэбат гишүүнээс ирүүлсэн. Тэгэхдээ өөрөө орон нутагт томилолттой тул энэ 2-ыг хасаад явах нь зөв байх гэж бодож байна. Тэгээд эхний санал хураалтыг явуулъя. УИХ-ын гишүүд санал хураалтдаа бэлдье. Ариунзаяа гишүүний эхний гаргасан горимын саналаар буюу хэлэлцэх 7 асуудлын нэг дэх асуудал, 4 дэх асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллаас хасъя гэдэг саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 16 гишүүн орсноос 11 гишүүн дэмжиж, санал 68.8 хувиар дэмжигдлээ. Ингээд хэлэлцэх асуудлаас нэг болон 4 дүгээр асуудал хасагдлаа.

2 дахь горимын санал болох энэ 2 хуулийнхаа асуудлыг санал хураалтуудыг эхлээд явуулъя гэсэн. Тэгэхээр эхлээд нэгд нь Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг нэгд оруулж хэлэлцье. 2-т Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг оруулж хэлэлцье. Ингээд бусад асуудал энэ дээр тавигдсан дарааллынхаа дагуу гэсэн үг. Өөрөөр хэлбэл 3-д нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг хэлэлцээд эхэлнэ гэсэн үг. Тэгээд энэ төсвийн гүйцэтгэлээ хурдан хэлэлцээд явах нь зөв байх. Энэ ЗГ-ын бүх төлөөллүүд нь ирчихсэн эхний асуудлыг хүлээж байгаа учраас энэ 3-д нь оруулаад ингээд хэлэлцээд явах нь зөв байх. Ингээд хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулахаар Ариунзаяа гишүүний гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад нийт 16 гишүүн оролцсоноос 11 гишүүн дэмжиж, санал 68.8 хувиар дэмжигдлээ. Ингээд хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт орлоо. Ингээд эхний асуудалдаа орьё. Эхнийхээ хэлэлцэх асуудалд орьё.

Нэг.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж нарын 36 гишүүн 2026.06.09 -ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

УИХ-ын гишүүн Сэддорж нарын 36 гишүүнээс 2026 оны 6 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг явуулъя. Хуулийн төслүүдийг үзэл баримтлалыг УИХ-ын гишүүн Сэддорж танилцуулна.

Р.Сэддорж: Эрхэм байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Монгол УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдаж, Хүний хөгжил төвтэй хөгжлийн бодлого хэрэгжиж эхэлсэн. Уг бодлогын үргэлжлэл болох 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролд бүх хүүхэд залуучуудыг тэгш хамруулах зарчмыг баримталж, ялгаатай хэрэгцээтэй хүүхэд залуучуудыг боловсруулсан, тэдний гэр бүл орон нутгийн онцлог байдалд нийцсэн тохируулгат орчин, дэд бүтэцтэй, хувилбартай, гэрийн сургалттай боловсролын үйлчилгээг бүх түвшинд бий болгох зорилтыг дэвшүүлсэн.

Улс орны хөгжил дэвшлийн урт хугацааны эдгээр зорилтыг хангахад тулгуур болох боловсролын салбарын эрх зүйн зохицуулалт, түүнийг хэрэгжүүлж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь энэхүү төслийг боловсруулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Монгол Улсын хүн амын бүтцийн 37.1 хувийг хүүхэд залуучууд эзэлдэг. Харьцангуй залуу иргэдтэй улс орон. Тийм ч учраас хүүхдийн сурах эрх хүүхдийн хамгааллын асуудалд бодлогын түвшинд анхаарч, хууль, эрх зүйн орчныг тогтмол шинэчилж ирсэн хэдий ч бодлого, хөтөлбөр, хууль тогтоомж боловсруулан хэрэгжүүлэхдээ хүүхдийн хөгжих, оролцох эрхийг бүрэн ойлгож хэрэгжүүлдэггүй хүүхдийг хамгаалах субъект гэж харах хандлага давамгайлж гэж судлаачид дүгнэдэг.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах нэг үндсэн шалтгаан нь

манай орны онцлог амьдралын хэв шинж болсон уламжлалт бэлчээрийн мал аж ахуй /МАЗ/-тай холбогдож байгаа юм. Манай улсын малтай өрхийн тоо 2022 онд 248.3 мянга болсон. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж малын ашиг шим тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрхийн тоо 190.8 мянга буюу малтай өрхийн 76.8 хувийг эзэлж байгаа бол малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж байгаа өрх 23.1 хувийг бүрдүүлж байна. Малчин өрхийн тоо 2022 онд өмнөх оноос 2.2 мянга буюу 1.2 хувиар өссөн. Малчин өрхийн малчин тоог дараах хүснэгтээр та бүхэнд харуулж байна. 2022 оны байдлаар малчдын дунд 15-аас 44 хүртэлх насны малчид 26.9 хувь, 35-аас 44 хүртэлх насны малчид 58.5 хувь, 55-аас дээш насны малчид 14.6 хувийг тус тус эзэлж байна.

Гэвч сүүлийн 3 жилд 15-аас 34 насны залуу малчдын тоо 3 хувь буюу 7 мянгаар багассан байна, 35-аас 59 насны малчдын эзлэх жин 0.7 нэгжээр буюу 8.8 хувиар нэмэгдсэн байна. Малчдын үйл ажиллагааны хүрээнд тулгарч байгаа бэрхшээл, хүндрэл, нөхцөл байдал, шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг судалгааны явцад авч үзэхэд малчин өрхийн хүүхдийн сургалтын асуудал чухлаар тавигдаж байна. Одоогийн нөхцөлд дээрх хуулийн зохицуулалтаар малчин өрхийн хүүхэд 6 наснаас сургуульд суралцах нь тэдний хувьд ялангуяа малчдын амьдралд хүндрэл бэрхшээл үүсгэж, нэг гэр бүл 2 талд, тухайлбал эхнэр нь сургуульд орсон 6 настай харж, сумын төвд удаан хугацаагаар сууж тустай, нөхөр нь уулын мухарт ганцаараа архи дарс уух, улмаар гэр бүл салж сарних, өрх толгойлсон эмэгтэй, хүүхэд өнчрөх гээд олон асуудлууд, үр дагаврууд гарч байна.

Энэ асуудлыг цэгцлэх, шийдвэрлэх арга зам тэдний хүсэлтийн дагуу тухайн онд 1, 2 дугаар ангид элсэж байгаа хүүхдүүдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр Боловсролын ерөнхий хуулийн 26.1.11-д заасан журмыг баримтлан зайн болон хувилбарт сургалтад хамруулах явдал юм. Цаашид дэлхийн чиг хандлагатай уялдуулан хүүхдийн сурах эрхийг хүндэтгэж, сургалтын олон хэлбэрийг бий болгон хөгжүүлэх нь хэрэгцээ шаардлага үүсээд байна. Эх оронч үзэлтэй, амьдрах ухаанд суралцсан, авьяас чадвараа нээн хөгжүүлсэн, эрхээ хамгаалж чаддаг хөгжсөн Монгол хүүхдийг төлөвшүүлэхэд төрийн бодлого, дэмжлэг чухал байна. Тиймээс эх орны ирээдүй хойч, хүүхэд багачуудын хөгжил, оролцоог дэмжих хууль, эрх зүйн орчин, сургалтын тогтолцоог олон улсын сайн туршлагад тулгуурлан боловсронгуй болгох хууль зүйн үндэслэл, практик шаардлага бий болжээ.

Малчин өрхийн хүүхдийн 1, 2 дугаар ангийн сургалтыг эцэг, эх, асрамжлан хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр Боловсролын ерөнхий хуулийн 26.1.11-д заасан журмыг баримтлан зайн болон хувилбарт явуулын сургалтад хамруулна. Зайн болон хувилбарт сургалтад хамрагдсан малчин өрхийн хүүхдийг 3 дугаар ангиас эхлэн танхимын сургалтад үргэлжлүүлэн сургана. Малчин өрхийн хүүхдийг ЕБС-д элсүүлэн сургах сургалтын энэ хэлбэрээр зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн батална. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцэж байгаа бөгөөд тухайн хуулийг дагалдан түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл боловсруулах болно. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

П.Ганзориг: Байнгын хорооны хуралдаанд ирсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Бодлогын асуудлуудад хариулт өгөх ёстой учраас

Боловсролын салбараас төлөөлөөд ирсэн байгаа. Л.Энх-Амгалан Боловсролын сайд, Т.Ням-Очир ТНБД, П.Оюунаа Боловсролын сайдын зөвлөх, А.Мөнх-Оргил Боловсролын эдийн засаг, санхүүгийн бодлогын газрын дарга, Б.Түмэндэлгэр Дээд боловсролын газрын дарга, Л.Ганбат Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хийсэн байна Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүн алга байна. Хаана байна. Отгоны Саранчулуун гишүүнээр тасаллаа. Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Сайн байна уу? Маш чухал санаачилгатай ийм хуулийн төсөл байна. 2 асуулт байна. 1 дүгээрт энэ яг энэ чиглэлээр ямар сайн туршлага байгаа вэ? Миний санаж байгаагаар Өмнөговьд билүү нэг Лхагвасүрэн гээд хүн нэг ийм багийн явуулын сургуулийг ингээд нутагшуулж ажиллаж байсан санагдаж байна орон нутагт. Тэгэхээр ер нь манайд энэ чиглэлээр ийм хөрс нь бүрдсэн гэж хэлэх юм уу, урьдач байдлаар туршлагууд ер нь Монголд хэр байдаг талаар мэдээлэл өгөөч?

2-т гэвэл ЗГ-ын байр суурь ямар байгаа юм бол төлөвлөгөөнд нь яаж тусгагдаж уялдаж байгаа юм бэ гэдэг дээр мэдээлэл авъя.

П.Ганзориг: Хууль санаачлагч Сэддорж гишүүн хариулъя.

Р.Сэддорж: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Монгол Улс дээр үеэсээ шавь сургалттай байсан нь үнэн. Тийм. Тэгээд энэ 12 жилийн тогтолцоонд ороод бид 20-оод жилийн нүүр үзэж байна. Тэгээд энэ 20 жилийн хугацаанд энэ сумдууд дээр хөдөө орон нутагт гарч байгаа асуудал яг ийм хүндрэлтэй асуудлууд маш их байгаа. Миний хувьд 47 сумаар уулзалт хийлээ. 47 сумын уулзалт дээр 47 суманд энэ асуудал яригдаж байна. 6 настай хүүхдээ дагаад айлын эмэгтэй хүн нь ингээд явчихдаг, айлын эрэгтэй хүн нь үлдээд малаа хараад ингээд тэгээд 2 тусдаа амьдраад, айлд зардал нэмэгдээд хүүхэд нь бие дааж суралцах дотуур байранд орох хүртлээ ингээд явж байгаа. Энэ явцад тэр айлын амьдралд янз бүрийн асуудал үүсээд, ингээд малаа зараад төв рүү ороод тэр малчин айл, удам залгасан малчин айл огт хот нь малгүй, тэр нутаг орон эзэнгүй болж байгаа ийм юмнууд их байгаа. Тэгээд манай Боловсролын яам их уян хатан ажилладаг юм билээ. Гэрээсээ сурдаг, зуслангийнхаа байрнаас гэрээсээ хүүхдүүдээ онлайнаар сурдаг тийм айлуудыг судаллаа.

Монгол Улсаас гадаадын, жишээ нь Булган аймагт байдаг Канад улсын иргэн бүх хүүхдээ 12 жилийн хугацаанд Канад улсын сургуульд Монгол Улсаас сургасан байна, манай Боловсролын яам яг энүүгээр сурч байгаа, зайнаас сурч байгаа хүүхдүүдээ сертификатыг нь олгоод ингээд дэмжиж явдаг нь сайшаалтай сайн үйл явдал байна. ЗГ-ын байр суурь жишээ нь Алсын хараа энэ бүх зүйлд энэ бүх хүүхдийг сургуульд хамруулна, бүх хувилбарт сургалтуудыг ашиглана гээд зорьсон байгаа. Энд хамрагдаж байгаа манай сайд ирчихсэн байна сайд нэмээд хариулах байх. Тэгээд сайдад баярлалаа. Энэ яг энэ чиглэлээр энэ Монгол орны 330 сумд яг тулгамдаад байгаа малчин өрхийн тоо сүүлийн үед ингээд 8 мянгаараа багассан байна. Сүүлийн 3 жил гэхэд л залуу малчид 8 мянгаараа төв рүү орсон байна. Тэгээд энэнтэй энийг анхаарч, Монгол төр анхаарах ёстой, бид боловсролыг иргэн болгондоо хүргэх ёстой, хүргэхдээ гэр бүлийг нь хайрлаж хамгаалах ёстой. Тэгээд энэ дээр нэмээд асуувал хариулъя, баярлалаа.

П.Ганзориг: Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууя.

Д.Рэгдэл: Ерөнхийдөө их сонирхолтой л хуулийн төсөл орж ирж байгаа. 1 дүгээр асуулт хууль санаачлагчаас асууя, энэ хууль батлагдвал хэдэн оноос хэрэгжүүлбэ гэж ер нь баримжаалж байгаа юм бэ? Тэгэхээр энэ дотор чинь малчин өрх гэж яригдаж байгаа, хөдөө малтай өрх гээд нэлээн том бүлэг хүмүүс байдаг. Тэд маань үүнд хамаарах юм уу, хамаарахгүй юм уу гэдэг нэг асуулт байгаа юм?

Ер нь зүгээр Монголын энэ нүүдлийн соёл иргэншлийн орчинд бид суурин соёл иргэншлийн боловсролын тогтолцоог авчирч тавиад ингээд үзээд байгаа юм. Хуучин 8 настайгаас нь сургадаг байсан тэр тогтолцоо нүүдэлчин арддаа хамгийн тохиромжтой байсан. Яагаад Европын тогтолцоог гэнэт ингэж оруулж ирэв гэдгийг би гайхаад л байгаа юм. Энэний нийгмийн, эдийн засгийн сөрөг нөлөөлөл үнэхээр асар их байсан. Энэ сүүлийн 20 жил лав хурцаар яригдаж байгаа, 6 настай хүүхдийг ах, эгчийг нь бараадуулаад сургуулийн дотуур байранд орчихдог, сургуулийн дотуур байранд орчихсон хүүхэд чинь нүхэн жорлонд бие засах асуудалтай тулдаг, уначихсан тохиолдол ч гарч байсан. Тэгээд ингээд 6 настай хүүхдээ сумын төв дээр авчирч ингэдгээ больё, ээжтэйгээ аав нь хөдөө ганцаараа малтай нэг жалгын мухарт байж байдаг, ээжтэйгээ ингээд сууж байдаг энийгээ больё гэж байгаа энэ санаа зөв санаа юм. Зөв санаа юм. Аюулгүй байдал талаасаа ч гэсэн аваад үзсэн.

Тэгэхдээ бидэнд энэ сургалтад хамрагдах хэчнээн мянган хүүхэд байгаа бол? Эд нарыг зайнаас болон явуулын хувилбарт сургалтаар үйлчилж чадах тэр хүн хүч, техникийн нөхцөл, санхүүгийн боломж энэ ямар хэмжээнд байдаг юм бол? Боловсролын яамны хүмүүсээс асууя. Миний бодоход энэ ер нь шууд хэрэгжүүлэхэд нэлээн асуудалтай юм үүснэ. Тийм учраас энэ хууль үйлчлэх тогтолцоо энэ тэрээс нь болоод би асуух асуултаа тодруулж асуух нөхцөл үүсэж магадгүй. Ер нь бид энэ Оросын ерөнхий боловсролын тогтолцооноос татгалзсаныг гайхаад байдаг байхгүй юу, 2023 онд Англи зарлаж байна шүү дээ, Оросын ерөнхий боловсролын сургалтын агуулгын тогтолцоо руу бүрэн шилжиж дууслаа гээд, тэр зөв чиг тогтолцоо байсан. Бид тэрүүгээр яваад 10 жил сургаад ингээд хүүхдээ төгсгөөд болоод байдаг байсан. Тэрүүгээр төгссөн хүүхдүүд дэлхийн аль ч оронд очоод суралцаад мэргэжил боловсролоо нэлээн гайгүй эзэмшээд ирж болж байсан. Ер нь 7, 8 настайгаас нь сургуульд авдаг тогтолцоо руу оруулах боломж байдаг юм болов уу гээд Энх-Амгалан сайдаас энийг асуумаар байна? Баярлалаа.

П.Ганзориг: Хууль санаачлагч хариулъя. Эхлээд.

Р.Сэддорж: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Энэ чинь хаврын чуулганаар амжихгүй байх. Амжихгүй. Тэгээд намрын чуулганаар хэлэлцээд батлагдлаа гэхэд 2027 оны 9 сарын 1-нээс л болов уу гэсэн бодолтой байна. Тэгээд энийг яаралтай горимоор яаж хэлэлцэж болдог юм бол. Энэ 26 оны 9 сарын 1 гэж амжихгүй байх даа. Энх-Амгалан сайд энэ дээр хариулах байх. Уг нь 2026 оны 9 сарын 1-нээс ингээд эхэлчихвэл олон айлд 160 мянган малчин айл байгаа юм яг мал малладаг, мал бүхий иргэд гэхээрээ 200 гаруй мянга болчихсон байж байгаа. Та бид ч гэсэн 2, 3 адуутай тэрийгээ бүртгүүлчихээр. Тэгэхээр энийг яаралтай л хэлэлцвэл, яаралтай л хэрэгжүүлбэл нэг ч гэсэн айл, нэг ч гэсэн өрх тэр аюулгүй байдлаа хангаж, янз бүрийн бусад хүндрэл бэрхшээлтэй асуудал гарахаас сэргийлэх юм. Хүн хүчний хувьд энэ дээр нэг зардал чирэгдэл, хүн хүч маш бага

зарцуулахаар зохион байгуулах хэрэгтэй. Энэ хууль батлагдвал. Жишээлбэл тэтгэвэртээ гарсан маш олон харахад ийм тэтгэвэртээ гараагүй гэмээр ийм залуу багш сумд их байдаг, аймагт их байдаг. Энэ хүмүүсийг дайчлахад бол дөнгөж сургууль төгссөн залуу багшаас хамаагүй илүү тэр 35 үсгийг заана, тэр нэг тооны хэдэн хичээлийг заана.

Тэгээд Монгол хүүхэд ер нь Рэгдэл гишүүнтэй би санал нэг байна. 12 жил сурах тийм оюуны шаардлагагүй, оюуны өндөр потенциалтай ийм хүмүүс. Тэгэхээр энэ эхний 2 жилийг тоглонгоо сургах, гүйж харайж байхдаа л тэр нэг хэдхэн үсгийг цээжилчих ийм л сургалтын хөтөлбөрийг хэдүүлээ зохицуулж, ирээдүйд төвийнхөн нь ч энэ дээрээ анхаараад, тэр малчин хүүхдүүдийнх ч юуг энэ дээрээ анхаараад явах ёстой гэдэгтэй санал нэг байна.

Дээрээс нь энэ Багшийн их сургууль гэж том сургууль байгаа. Энэ сургуулийн оюутнууд дадлага хийх ёстой дадлагыг жинхэнэ энэ хүүхдүүдийг тэр зуны амралтаар нь жинхэнэ сайн сайжруулж, дадлагажуулж, гар хөлийг нь эвлүүлэх, тэгээд явуулын багш явах нэг жаахан зардал гарах байх. Энэ дээр сум, аймгийн дарга нар онцгой анхаарах ёстой, багийн дарга шууд хариуцах ёстой, Хүүхдийн төлөө зөвлөлийн дарга сумын Засаг дарга, аймгийн Засаг дарга байдаг. Энэ дээр бүр хариуцаж ажиллах хэрэгтэй. Тэгээд ганц нэг сумыг сонирхоход 1 сумд 1 дүгээр ангид орж байгаад малчин айлын 6 хүүхэд л байна лээ, 6 айлын хүүхэд л байна лээ. Тэгээд энэ 6 хүүхдийг нэг сум даяараа хөдөлчихөд гэр орных нь ойролцоо, гэрт нь сургачихна гэсэн бодолтой байна. Баярлалаа.

П.Ганзориг: Сэддорж гишүүний хууль энэ 6 сарын 9-ний өдөр өргөн барьсан, өөрөөр хэлбэл 14 хоногийн өмнө ер нь их яаралтай горимоор явж байгаа шүү. Шуурхай. Энх-Амгалан сайд нэмж хариулах уу Рэгдэл гишүүний асуултад.

Л.Энх-Амгалан: Яах вэ, Сэддорж гишүүний санаачилж байгаа энэ хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ яах вэ зүгээр заавал ч үгүй хуульд ингэж тусдаа хуульд өөрчлөлт оруулах шаардлага байна уу, байхгүй юу гэдгийг та нэг эргэж хараач л гэж би танаас хүсээд байгаа шүү дээ. Боловсролын ерөнхий хууль, энэ Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хуульд энэ зохицуулалтууд нь бүгдээрээ байгаа байхгүй юу. Хувилбарт сургалтууд хийж болно гээд. Энийг ч гэсэн бид цахимын үед ч гэсэн нэлээн энэ үр дүнг нь харсан. Тэгээд яах вэ ерөнхийдөө бид энийг яг малчдын хүүхдэд зориулсан энэ сургалтын хувилбарт сургалтуудыг бид яг орон даяар шууд ингээд хэрэгжүүлэх гэхээсээ илүү энэ намраас, энэ зун, энэ намраас хэрэгжүүлэх гэсэн төрийн бус байгууллагуудын зарим санал санаачилгууд байгаа. Манай Боловсролын хүрээлэн дээр тодорхой хийгдэж байгаа энэ хувилбарт сургалтыг хэрхэн зохион байгуулах вэ гэдэг юунууд байгаа учраас энийг хэрэгжүүлэхэд нэг их тийм.../минут дуусав/

П.Ганзориг: Нэмэлтээр хариулья.

Л.Энх-Амгалан: Тэгээд яах вэ Рэгдэл гишүүн асуулт энэ бид Оросын боловсролын тогтолцоог авчихсан л гэж яриад байгаа юм. Энэ Орос биш Герман тогтолцоо л юм байна лээ л дээ. Энэ явж байгаа Оросууд Германаас авсан манайх Германжсан Орос боловсролын тогтолцоог авсан. Тэртээ тэргүй дэлхийн улс орнууд 12 байтугай 13, 14, 15 жилийн тогтолцоонд шилжиж байгаа учраас дахиж бид хүүхдийн насыг яг 6-г 7 болгох 10 жилийн тогтолцоог юу 12 жилийн тогтолцоог

буцаад 10 жилийн тогтолцоо руу шилжих бол их тийм дэлхийн улс орнуудын чиг хандлагын эсрэг явчих л нэг ийм нөхцөл байгаа л гэж би харж байгаа.

П.Ганзориг: Рэгдэл гишүүн тодруулах уу, үгүй юү. Би 3 зүйл тодруулж асууя. Ерөнхийдөө энэ хуулийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжиж байгаа. Ялангуяа МАА-н уламжлалт энэ амьдралын хэв маягт зохицуулж, 1-ээс 2 дугаар ангийн хүүхдүүдийг зайнаас гэрээр сурах энэ боломжийг зохицуулж өгч байгаа нь чухал. Гэхдээ хэд хэдэн анхаарах асуудлууд байгаа дээр асуулт асууя. 1-ээс 2 дугаар ангиа гэрээсээ зайнаас ингээд суралцаж байх хугацаанд хүүхдүүд суурь унших, бичих, тооцоолох чадвар дутмаг эзэмшинэ. Ингээд 3 дугаар ангид танхимын сургалтад шилжиж орох үедээ бусад суралцагчаасаа мэдлэгээр хоцрох, мэдлэг чадварын хувьд хоцрогдол үүсэх ийм эрсдэл байгаа. Энийг яаж тооцож зохицуулна гэж харж байгаа вэ?

2-т энэ суралцах хоцрогдлынхоо улмаас хүүхдүүд өөртөө итгэх итгэл унадаг, сулардаг. Цаашдаа нөгөө сурах чадвар, суралцах чадварт нь сөрөг нөлөө үзүүлэх ийм эрсдэлүүд харагдаад байгаа. Энийг та юу гэж харж байгаа вэ? Ямар тооцоо судалгаа байгаа вэ гэж асуумаар байна?

3-д ер нь сургуулийн орчинд сурна, анги танхимаар сурна гэдэг хүүхдүүд үе тэнгийнхэнтэйгээ харилцаж нийгэмших, багаар ажиллах, ингээд бусдыг танин мэдэх, сэтгэл хөдлөлөө удирдах гээд олон чадваруудыг сурч байдаг. Тэгэхээр эдгээр асуудал, энэ чухал чадварууд, нийгэмших чадварууд гэсэн үг шүү дээ. Энийг яаж яг энэ чухал хөгждөг нас нь байхгүй 1, 2 дугаар ангийн хүүхдүүд гэдгийг тархины гол хөгжлийн суурь явж байдаг үед яаж тооцож харж байгаа вэ? Тэгээд цаашлаад яг эцэг эхчүүд гэрийнхээ нөхцөлд зайнаас сургаж байгаа тохиолдолд эцэг эхчүүдийг дэмжих, чиглүүлэх сургуулийн боловсролын салбараас ямархуу бодлого чиглэл, ийм бодлого барьж ажиллана гэж харж байгаа вэ гээд ийм 4 асуултад та хууль санаачлагчийн хувьд тодорхой хариулж өгөхийг хүсье. Баярлалаа. Сэддорж гишүүн хариулъя.

Р.Сэддорж: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Хоцрогдол гэдэг ойлголт мэдээж харьцангуй ойлголт. Сонголтыг нь л өгч байгаа юм. Заавал гэж байгаа юм биш, тэр айл өөрийгөө мэднэ. Бүлтэй ч айл байна, бүлгүй ч айл байна, сумын төвд ойрхон ч айл байна, хол ч айл байна, бүр сумын төв дээр ч байдаг айл байна. Энэ хүмүүс танхимаар сурах нь нээлттэй, эцэг эхэд нь сонголтыг нь л өгч байгаа юм. Тэгээд энийг хүний эрхийн ч асуудал байгаа. Тэгээд хүн ямар хэлбэрээр сурах нь хүний эрхтэй холбоотой шүү дээ. Тэгээд Боловсролын хууль дээр ингээд зөвшөөрчихсөн, Монгол Улсын Алсын хараа бүх зүйл дээр зөвшөөрчихсөн бүх аргаар сургаж болно гээд зөвшөөрчихсөн байхад бид энэ хуулийг дэмжихэд болохгүй юм байхгүй байх гэж бодож байна.

Нийгэмших асуудал дээр мэдээж эрсдэл байгаа, эрсдэл гарна. Энэ 2 талтай. Тэгээд тэр янз бүрийн энэ яам их гоё хөтөлбөр гаргаж ирэх байх гэж бодож байна. Ингээд тогтмол хугацаанд төрийн бус байгууллагууд тэр хүүхэдтэй онлайнаар ч юм уу зайнаас харьцах, ингээд аав ээжтэй нь ярилцах, хүүхдийн явуулын багш очих, ингээд номын сан, явуулын номын сангууд очиж ажиллах, ер нь 6, 7 нас гэдэг хамгийн их ертөнцийг таних нас гэж үзэж болох байх. Аав ээжээсээ аав ээж гэдэг хамгийн том багш, эмээ өвөө гэдэг хамгийн сүрхий багш, тэр хүмүүсээс нь ингээд салгаад явуулчихаар болохгүй болчихоод байгаа юм. Тийм учраас таны хэлж байгаа

үнэн, энэ дээр эрсдэл байгаа нь байгаа. Гэхдээ Монгол хүн хүүхдээ хэзээ ч боловсролгүй болгоё гэж бодохгүй, малчин аав ээжид илүү хариуцлагыг нь оногдуулж байгаа. Аав ээж хариуцлагатай байх ёстой, аав ээж нь гэр бүлээрээ байх ёстой, элэг бүтэн байх ёстой, тэгээд энэ хуулийн гол үндсэн санаа энэ дээр байгаа юм.

Эцэг эхийн сургах энэ дээр Боловсролын яам маш гоё сурах бичиг зохиох байх гэж бодож байгаа. Энэ 1, 2 дугаар ангийг хэдүүлээ ингээд зөвшөөрөөд ингээд явуулбал ерөөсөө үндэсний уламжлал, энэ уламжлалт Монгол ёс соёл, суртахууныг энэ боловсролд оруулж ирж байгаа нэг алхам байж магадгүй. Энүүгээрээ дамжуулаад энэ 1, 2 дугаар ангийн хүүхдүүд энэ Монгол уламжлалаа илүү сайн ингээд төвд сурч байгаа ангийн хүүхдүүд нь тэр хүүхэд дээрээ ирнэ, ангийн багш нь 9 дүгээр сарын 1-нд бүртгээд авчихна гэж төсөөлөөд байгаа шүү дээ. Утсаар яриад л манай нэг хүүхэд тэнд сурч байгаа шүү хувилбар сургалтаар сурч байгаа гээд тэрэнтэйгээ байнга холбоотой байна. Ингээд явчих байх. Тэгээд эцэг эхийн сургалт асуудал дээр манай Малчны тухай хууль дээр хэрэгжээгүй маш том заалт байгаа, 6 дугаар зүйл байх. Тэгээд энэ дээр малчдыг сургана, бүр явуулын сургалт хийнэ, аймгуудын МСҮТ дээр аваачиж сургаад мэргэжлийн үнэмлэх, зэрэг олгоно гэсэн энэ заалт хэрэгжихгүй байгаа юм байна лээ. Яг энэ цаг үетэй давхцаад малчны хуулийн сонсгол явагдаж байгаа. Тэгээд энэ дээр энэ Малчны тухай хууль дээр байгаа учраас таны хэлж байгаа санаа маш зөв. Эцэг эх нь дагаад маш сайн суралцах ёстой, тэнд суралцана ч гэж бодож байгаа. Зөвхөн багш.../минут дуусав/

П.Ганзориг: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн асуулт асууя.

Л.Энх-Амгалан: Надад асуугаад байх юм алга. Яаж зохион байгуулах вэ, яаж хүртээмжтэй, чанартай боловсролын хувилбарыг хийх вэ гэдэг л асуудал бидэнд том зорилт болчихоод байгаа юм л даа. Тэгэхээр хот, хөдөөгийн сургуулийн ялгаа нэлээн гарчихсан. Унших, бичих, байгалийн ухаан, математикийн хичээлээр сумын төвд байгаа хүүхдүүд Улаанбаатар хотын хүүхдээс 3.5 жилийн хоцрогдолтой гэдэг нь тодорхой болчихсон байгаа. Тэгэхээр хөдөөд байгаа уг нь боловсролын чанар чинь нэг ангид байгаа хүүхдийн тооноос шууд хамааралтай гэж ярьдаг шүү дээ. Гэтэл харамсалтай нь өнөөдөр юу байна вэ гэхээр хөдөөд хамгийн бага хүүхэдтэй бүлэг байгаа 10 хүүхэдтэй, 12 хүүхэдтэй, 20 хүүхэдтэй бүлэг байгаа. Уг нь логикоор сурлагын чанар хамгийн өндөр байх нь хөдөө байхгүй юу, нэг багшид ноогдож байгаа хүүхдийнхээ тоогоор. Тэгэхээр харамсалтай нь нэг ангид ноогдож байгаа 40 хүүхэдтэй ажиллаж байгаа багш Улаанбаатар хотод ажиллаж байгаа багшийн ур чадвар, багшийн гүйцэтгэл, хөдөө орон нутагт нэг бүлэг дээр 20 хүүхэдтэй ажиллаж байгаа багшийн гүйцэтгэл, ур чадварууд ялгаа гарчихсан, урвуугаараа ялгаа гарчихсан нэг ийм зовлон байгаад байгаа юм.

Тэгэхээр бид хамгийн түрүүнд энэ хөдөөгийн боловсролын чанарыг л сайжруулах зүйл дээр энэ сургуулиудын хэв шинжүүдийг эргэж харах зайлшгүй ийм шаардлага байгаа гэж харж байгаа. 330 сум дээр бид чинь 12 жилийн тогтолцоотой, 200 хүүхдээс доошоо 200 гаруй сургууль байгаа шүү дээ. Сумын сургууль 10 жил, 9 жил сум дундын ахлах сургууль гээд энэ хувилбаруудыг бид судалж байна. Тэгээд энэнтэй уялдуулаад энэ малчин хүүхдэд зориулсан энэ хувилбарт сургалтын аргыг бид зайлшгүй хэрэгжүүлэх ёстой гэж ойлгож байгаа. Тэгэхдээ бид гурилдаж болохгүй. Хүүхдүүдийн сургуулиас завсардах энэ юмыг өдөөж болохгүй. Тэгэхээр энэ дээр би Сэддорж гишүүнийг аймгийн Засаг дарга байсан хүний хувьд цаашдаа

бид энэ сум орон нутагт энэ малчдын хүүхдийн боловсролыг тэгш хүртээмжтэй чанартай боловсрол олгоход энэ хувьсах зардлын тогтолцоог Сэддорж гишүүнээ, энэ дээр энэ аймаг сумдуудыг үүрэгжүүлэх ёстой, үүрэгжүүлэх ёстой. Ингэхгүй бол бид байгаа хувьсах зардлаар нь нэг хүүхдийг тэр тусмаа явуулын багш ингээд гэрийн багшаар ингээд энэ сургалтыг чанартай сургалт өгчихнө гэж бид ингэж бие биеийгээ нүд хуурч болохгүй. Тэгэхээр лоозон байж болохгүй гэж бодож байгаа юм би энэ хууль дээр яг хэрэгжих бололцоотой, яах вэ бид хэд хэдэн хувилбар дээр сууж байгаа гайгүй хувилбарууд гарч ирэх ч болов уу гэж бодож байна.

Сая манай хэсэг бодлогын дарга нар Казахстанд очиж энэ малчин хүүхдүүдийн сургалтын хувилбаруудтай танилцсан. Швейцарын хувилбаруудыг бид судалж байна. Индонезийн хувилбаруудыг судалж байна. Тэгээд яг Монголын онцлогт, Монголын энэ амьдралын онцлогт тохирсон тэгэхдээ чанартай боловсрол үзүүлэх хамгийн гол тогтолцоо санхүүжилт шүү Сэддорж гишүүн. Тийм учраас яг ингээд нөгөө Хөгжим бүжгийн дунд сургуульд онц авьяастай хүүхдүүдийг сургадаг хувьсах зардлаар тусдаа сургадаг сайн тогтолцоо байдаг. Энэ тогтолцоог дэмжсэн санхүүжилтийн тогтолцоог дэмжсэн энэ эрх зүйн заалтуудыг л хийж өгсөөсэй л гэж.../минут дуусав/

П.Ганзориг: Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Рэгдэл гишүүнээр тасаллаа. Отгоны Саранчулуун гишүүн үг хэлье.

О.Саранчулуун: Яах вэ хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа. Тэгэхдээ Боловсролын яамны байр суурь, сайдын тайлбарыг сонсохоор ер нь хийж байгаа, энэ чинь болж байгаа, нэгэнт эхэлчихсэн явж байгаа зүйл гээд байгаа. Тэгэхээр энэ хууль дээр тусгасан зохицуулалт нь тэр Боловсролын ерөнхий хуульд байгаа зохицуулалтаас юуг шинээр нь нэмээд, юуг өөрчилж байгаа вэ гэдэг ялгааг нь тодруулж харах хэрэгтэй юм байна 1 дүгээрт.

2-т гэвэл яах вэ ер нь хүүхэд ээж аав, асран хамгаалагчаасаа холдсон цагаас эхлээд эмзэг нөхцөлд ордог гэсэн үг. Дүрмийн хувьд. Тэгэхээр бага насны хүүхэд хүнд нөхцөлд. Ээж ааваасаа холдонуут тэр хүүхдийн эмзэг байдал руу орж байна гэж ер нь үздэг шүү дээ. Тэгэхээр энэ утгаараа маш чухал энэ явуулын сургууль гэдэг юм уу боловсрол олгох нь. Нөгөө талд энэ ярьж байгаа энэ аргачлалыг бид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээр хийж уул нь болох ёстой байхгүй юу. Явуулын сургууль гэдэг чинь нөгөө очиж чадахгүй байгаа хүүхдүүдэд. Тэгэхээр хэрвээ тийм хүүхдүүдийг хамруулаад ингээд явна гэвэл энэ дээр зохицуулалтын хувьд одоо байгаа нөөц бололцоо нь хэр юм бол доо гэдэг нэг юм бодогдоод байна л даа. Тэгэхээр яах вэ нөгөө үг хэлж байгаа учраас бид жаахан олон талаас нь эргэцүүлж байж нөгөө шийдвэр гаргахгүй бол, заримдаа ингээд хуульд нь байгаа мөртөө яг тэрийг нь хэрэгжүүлэх журам нь ч юм уу дагалдах зохицуулалт нь тусгаагүй олон зүйл заалтууд ингээд байхгүй болохоор гишүүд тэрийг ахиад хууль гэж өргөн бариад, ингээд нэг тэгээд яг тэрийг нь хэрэгжүүлэх гээд ингээд нөгөө тухайн салбарынхаа бүтэц рүү орохоор байж байдаг ч юм уу нэг ийм асуудлууд байгаад байдаг юм ажиглагдсан юм. Тэгэхээр тэрэн шиг ийм давхардал болох вий гэдэг нэг ийм болгоомжлол байгаад байна.

Цахим сургуулийн хичээлийн хөтөлбөрүүдийг харсан, вэбсайт дээр Мэдлээ дээр байгаа хичээлүүдийг харсан, бага ангийн хөтөлбөрүүд ерөнхийдөө нэлээн оруулчихсан доор нь хадмалтай ингээд юм хийгээд явж л байгаа юм байна лээ.

Зүгээр цахим сургууль чинь нөгөө үйлчилгээ хүргэж байгаа хүмүүс өөрсдөө мэдээллээ оруулж байгаагаар ажил гэж тооцоод байгаа болохоос тэр хичээлийг нь яг аваад сурч байгаа хүүхдүүдийнхээ өөрчлөлт, ахицыг нь яг хэмжиж байгаа үгүй нь тайлан дээр харагдахгүй, мэдэгдэхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хууль тэрийг нь сайжруулах юм болов уу гэдэг нэг ийм асуудлыг хармаар байгаа юм, тодруулж ер нь.

Нөгөө талдаа би түрүүн асуусан чинь хариултаа аваагүй. Монголд ер нь яг энэнтэй төстэй ямар шийдэл байсан бэ? Ямар хувилбар байсан бэ? Тэр чинь нэг ийм эхлүүлэх нэг хөрс баймаар байгаа байхгүй юу. Тэгэхээр орон нутагт, хөдөө орон нутагт зарим нэг шийдлүүд байгаад л байгаа юм. Тэр гадаадын сургуульд онлайнаар суралцахаас өгсүүлээд. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн хувьд хүүхдүүдээ гэртээ боломжоороо сургаж байгаа туршлага байгаад байна л даа. Заавал орон нутаг гэхгүйгээр. Тэгэхээр энэ энэ тэрийг нийлүүлж байгаад, тэгээд тэр нь одоогийн байгаа Боловсролын ерөнхий хууль, хууль дагалдах журмуудад тусгагдсанаараа аль хэсэг нь дутуу болчихоод, аль хэсэг дээр яг заавал хууль байж болохгүй болчихоод байгаа юм бол гэдэг ялгааг нөгөө тод томруун харах хэрэгтэй байгаад байгаа байхгүй юу. Тэрийг нь бидэнд сайн ойлгуулах ч юм уу тэгж байж явах хэрэгтэй байх. Хэрвээ үнэхээр нээрээ тийм хоосон зай байна, энэ хуулиар яг энийг нөхнө гэж байгаа бол болж байна. Тэгвэл ажлын хэсэгт нь ороод ажиллахад ч бэлэн байна гэж хэлье.

П.Ганзориг: Дүгэрийн Рэгдэл гишүүн үг хэлье.

Д.Рэгдэл: Хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжиж байгаа юм. Ер нь 6 настай хүүхдийг гэрээс нь, аав ээжээс нь салгаад аваад явчихна гэдэг маш том харгис үйлдэл байгаа юм. Тэгээд энэ 12 жилийн тогтолцоо 6 нас гэдэг энэ юм орж ирээд, энэнээс хойш ялангуяа энэ залуу малчин өсөж хөгжих, залуу гэр бүл бэхжиж төлөвших энэ явдалд энэ маш том хар зам татуулсан л тогтолцоо л доо угаасаа. Нэг хэсэг хөдөө гэр бүл салалтын нэг үндсэн шалтгаан нь ээж нь сумын төв дээр хүүхдээ хараад суучихдаг, аав нь малтайгаа үлддэг, энэ 6 настай хүүхэдтэй холбоотой ийм шалтгаан байсан, одоо чухам юу болж байгааг мэдэхгүй байна. Тэгэхдээ олон хувилбар байгаа байх. Би Сэддорж гишүүний танилцуулгыг сонслоо, Энх-Амгалан сайдын тайлбарыг сонслоо. Энэ дээр энэ Боловсролын хүрээлэнгээс хүн байгаа болов уу, энэ багш дотор юу багш дотор гэххэв үү, аав ээж дотор хүүхдэдээ 1, 2 дугаар ангид нь хичээл заах хэмжээний боловсролтой аав ээж нэлээн байх ёстой.

Тийм учраас тэд нарыг нэг судалж гаргаад, тэд нарт зориулсан гарын авлага энэ тэрээ хурдан хийчихвэл энэ багш явуулж заалгах, тэгээд онлайнаар сургах процессыг нэлээн хөнгөвчлөх хүчин зүйл болж болно. Онлайнаар сургахад хэцүү. Сая Төв аймгийн Сэргэлэн сум дээр очиход сумын төв дээр сүлжээтэй газар байна, сүлжээгүй цэгүүд байна. Нэг газар очоод Мобиком утсаар ярьж болдог өөр газар ярьж болдоггүй. Тэгээд энэ манай энэ сүлжээний нөхцөл байдлаас болоод энэ сургалтад нэлээн хүндрэл үүсэх магадлалтай. Тэгэхээр энэ талыг нь манай Боловсролын яамныхан үзэж харж тооцоогоо зөв гаргаарай. Тэгээд ер нь үндсэн зарчим 6, 7 настай хүүхэд аав ээж хоёртойгоо амьдрах ёстой гэдэг ийм зарчим дээр л цөмөөрөө тулгуурлаад, тусалж дэмжээд хуулиа боловсронгуй болгоод, хуульд хэрэггүй журмаараа зохицуулчих асуудлуудыг нь яг ялгаж гаргаад хэлэлцүүлгийн явцад ингээд явчихъя гэсэн саналтай байна.

П.Ганзориг: Гишүүд үг хэлж дууслаа. Хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл тус бүрээр санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдье. 2 санал хураалт явуулна. Эхний санал хураалтыг явуулъя. 1.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн оролцсоноос 12 гишүүн дэмжиж, санал 70.6 хувиар дэмжигдлээ.

2 дахь санал хураалт. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн оролцсоноос 12 гишүүн дэмжиж, санал 70.6 хувиар дэмжигдлээ.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл болох Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг төсөл тус бүрээр санал хураалт явуулж дууслаа. Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Мягмардашийн Сарнай гишүүн танилцуулна. Ингээд хууль санаачлагч Сэддорж гишүүнд амжилт хүсье.

15.21 цаг

Хоёр.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 71 гишүүн 2025.09.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг , үргэлжилнэ/

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. УИХ-ын гишүүн О.Номинчимэг нарын 71 гишүүнээс 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Байнгын хорооны ажлын хэсгийн ахлагчаар Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ажиллаж байгаа. Тэгье, ажлын хэсгийн ахлагч Чинбүрэн гишүүн танилцуулгаа эхлүүлж байх уу.

Ж.Чинбүрэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол УИХ-ын гишүүн Номинчимэг нарын 71 гишүүнээс 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол УИХ-ын даргын 2025 оны 518 дугаар захирамжаар байгуулсан бөгөөд ажлын хэсэгт УИХ-ын Чинбүрэн, Баярбаатар, Баасанжаргал, Бумба-Очир, Ганбаатар, Жаргалан, Нарантуяа-Нара, Сайнзориг, Ундраа, Цэнгүүн, Энхнасан нарын гишүүд ажиллалаа.

Ажлын хэсгийг 3 дэд хэсэг болгож, эрүүл мэнд, боловсролын асуудал хариуцсан дэд ажлын хэсгийг миний бие ахалж, стандарт, техникийн асуудал хариуцсан чиглэлээр Баярбаатар гишүүн ахалсан. Татварын бодлогоор Жаргалан гишүүн ахалж ажилласан болно. Мөн төрийн байгуулалтын холбогдох албан хаагчид, судлаачдаас бүрдсэн Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий бүрэлдэхүүн байгуулан ажилласан. Ажлын хэсэг хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэхдээ Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэгт заасны дагуу Байнгын хорооны санал, дүгнэлт гарах хүрээ, хязгаарт багтаан төслийн үзэл баримтлалын хүрээнд зүйл, хэсэг, заалт нэг бүрээр ярилцаж дараах агуулга бүхий саналуудыг бэлтгэсэн болно.

Үүнд, 1.тамхи, тамхин бүтээгдэхүүний талаарх нэр томьёо ойлголтыг боловсронгуй болгож, электрон тамхи халаадаг тамхи, усан тамхи болон никотин агуулсан шинэ төрлийн бүтээгдэхүүнийг тамхин бүтээгдэхүүний ангилалд хамруулж, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангасан. 2.Тамхин бүтээгдэхүүнд ноогдох никотины хувь хэмжээ болон зурагт анхааруулгын стандартыг техник зохицуулалтад нийцүүлэн түүнийг баримтлахаар тусгасан. 3.Тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийн зохицуулалтыг тамхины төрлөөс нь хамаарч хооронд нь тусгаарлах асуудлыг тусган өргөжүүлсэн. 4.Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагын үүргийг зохицуулалтыг холбогдох хуульд нийцүүлж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэгт тамхины хамаарлаас гарах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, тамхины хэрэглээ болон тамхины хяналтын талаар хүн амд чиглэсэн сургалт сурталчилгаа эрүүл мэндийн боловсролын үйл ажиллагааг зохион байгуулах үүргүүдийг нэмж тусгасан.

5.Түүнчлэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Цахилгаан халаадаг тамхийг янжуур тамхитай адилтган нэг төрөлд оруулж татвар ноогдуулж байсныг бусад нь ангилсан. Аманд уусах зажлах зориулалттай тамхин бүтээгдэхүүнээс онцгой албан татвар ноогдуулахаар тусгасан. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/ тамхин бүтээгдэхүүний жижиглэнгийн үнийн хамгийн багадаа 75 хувь нь татвар байх зөвлөмжийн дагуу 5 жилийн хугацаанд үе шатаар нэмэгдэх онцгой албан татварын хэмжээг 60 хувьд нийцүүлэн боловсрууллаа. Тамхин бүтээгдэхүүнд онцгой албан татвар ноогдуулахдаа ангилал тус бүрээр тогтоох санал гаргасан. Никотин агуулагдаагүй тамхи татах төхөөрөмж түүний эд ангид онцгой албан татвар ноогдуулахгүйгээр төсөлд тусгалаа.

6.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Импортын гаалийн татварын хувь хэмжээг тогтоох тухай УИХ-ын тогтоолын төслийн бүрэлдэхүүний нэр томьёог нийцүүлж, үндэсний ангиллын кодыг шинэчлэн гаалийн татварын хувь хэмжээг хууль санаачлагчийн өргөн мэдүүлснээр тусгасан. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын саналуудыг та бүхэнд хүргүүлсэн тул хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

П.Ганзориг: Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Б.Цэцэгсайхан ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын

хэрэгжилтийн газрын дарга, С.Болормаа ДЭМБ-ын суурин төлөөлөгчийн газрын Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэн, Н.Ганбат судлаач, энэ байхгүй юм уу? Анар дарга байхгүй байна, Чимэдсүрэн байна уу, тэгээд энэ яагаад нэрийг нь зөвлөчихсөн юм. Ч.Чимгэрэл Гаалийн ерөнхий газар /ГЕГ/-ын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ж.Төрболд Сангийн яамны татварын бодлогын мэргэжилтэн, Д.Долгорсүрэн Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын мэргэжилтэн, Б.Отгонбаяр Татварын ерөнхий газрын Татварын хураалтын удирдлага, арга зүйн газрын татварын улсын байцаагч, тамхины чанар, техник, технологи, стандартын асуудлаар Х.Майцэцэг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /ХХААХҮЯ/-ны Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хүнсний худалдаа, тусгай зохицуулалт хариуцсан ахлах шинжээч, С.Баярдулам шинжээч ийм бүрэлдэхүүнтэй байгаа юм байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулж дууслаа.

Ингээд Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл тус бүрээр хэлэлцэнэ гэж заасан. Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчдоос асуулт асууж болно. Ингээд хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал авах гишүүн байна уу? Нарантуяа-Нараа гишүүнээр, Мөнхсайхан гишүүнээр тасаллаа. Тогтмолын Мөнхсайхан гишүүн.

Т.Мөнхсайхан: Та бүхэнд бүгдээрэнд нь энэ өдрийн мэнд хүргэе. Ингээд Тамхины хяналтын тухай хууль хэлэлцэгдээд Байнгын хороогоор орж ирж байгаад их юуны өмнө баяртай байна. Энэ хууль их олон жил яваад ер нь гацаад байсан. Тэгээд энэ дээр татварууд дээр нэлээн өөрчлөлтүүд орсон байна л даа. Тэгэхээр өмнө нь хууль санаачлагч татварыг хэдэн хувиар нэмээд, никотинд нь агууламжид нь ноогдуулаад, хэдэн төгрөгөөр нэмэгдүүлбэл эргээд энэ тамхины хэрэглээг хэдэн хувиар бууруулах вэ гэдэг маш нарийн тооцооллууд хийсэн байсан. Тэгэхээр та бүхний энэ татварын тооцоололд өөрчилж байгаа зүйл дээр яах вэ тэгээд хариулаад явчих. Энэ өөрчилж байгаа зүйл дээр өөрчлөгдсөнөөрөө энэ хэрэглээ хэрхэн яаж буурахаар байгаа вэ? Энэ тооцооллоо та хэд маань яаж хийчхэв. Тэгээд татвар маань нэмэгдүүлж байгаа татвар маань хаана төвлөрөхөөр болов, эргээд энэ маань эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлдэг зүйлүүдийг багасгахад зарцуулагдана гэсэн энэ зүйл маань ямар санд эргэж төвлөрөхөөр болсон бэ? Эдгээр асуултад нэг хариулт өгөөч.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч хариулъя. Тэгээд цаашдаа гишүүд зүйл тус бүрээр асуулт, зарчмын саналууд авна. Тэгэхээр тухайн зүйлтэйгээ холбогдуулаад асуулт, саналуудаа тавиад байхыг хүсье. Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: Зүйл, заалт бүр дээрээ хариулаад явчихвал зүгээр байх. Энэ тусдаа бүр дагалдан өргөн барьж байгаа онцгой албан татвар ноогдуулах барааны нэр төрөл гэдэг дээр энэ тусдаа бүр том заалт яваа. Тэгэхээр онцгой албан татвартай холбоотой энэ хэсэг дээр хууль санаачлагчаас татварыг, онцгой албан татварыг янжуур тамхи, тамхин бүтээгдэхүүн дээр 31 он гэхэд 10 мянган төгрөгөөр нэмэгдэхээр оруулж өгч ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу татварын ноогдох хэмжээг 75 хувьд хүргэхээр оруулсан. Манай ажлын хэсгийнхэн энийг ярилцаад нийгэм, эдийн

засгийн нөлөөллийн мөн энэ ажлын дэд хэсэгт оролцсон Татварын болон Эдийн засгийн яам, Сангийн яам хамтарч ярилцаад бид энэ таны өмнө энэ таблиц дотор ингээд оруулчихсан байж байна. Ер нь 60 орчим хувьд болгохоор нэг ёсондоо 2031 он гэхэд янжуур тамхин дээр 8 мянган төгрөгөөр нэмэхээр ингэж оруулж ирсэн байгаа. Ингээд яг Жаргалан гишүүн ороод ирвэл энэ тал дээр татварын асуудлаараа илүү дэлгэрэнгүй тайлбар хэлж өгөх байх.

П.Ганзориг: Мөнхсайхан гишүүн тодруулах уу? Мөнхсайхан гишүүн тодруулъя.

Т.Мөнхсайхан: Тийм та хэд маань ингээд таблицлаад ингээд гаргачихсан энэ татварыг нь ингээд харж байгаа юм. Тэгээд яах вэ жилдээ нэг жишээ нь 20 ширхэг янжуур дээр 1500 төгрөг буюу нэг ширхэг янжуур дээр 75 төгрөг нэмэгдэнэ гэж харагдаж байна л даа. Өмнө нь жилдээ нэг төгрөгөөр нэмэгдэж байсан. Гэхдээ энэ бид их давуу тал. Гэхдээ ингэж нэмэгдсэнээрээ яг эргээд ямар үр дүн гарах гээд байна вэ? Бид чинь хамгийн гол нь энэ татвар мөнгөн дүнг нэмэгдүүлснээр эргээд энэ хэрэглээг бууруулах зорилго тавиад байгаа шүүдээ. Тэгэхээр ийм хэмжээний татварын өөрчлөлт гарснаараа хэрэглээн дээр яг ямар хэмжээний өөрчлөлт гарна гэж тооцоолж энэ мөнгөн дүн татварын хэмжээг тогтоосон бэ л гэж асуусан.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Ж.Чинбүрэн: Тамхины хяналтын тухай хуулийн ерөөсөө гол хэрэгсэл энэ тамхинд шинээр орж байгаа болон тамхи татаж байгаа улсуудыг цөөлөх, тамхинд орж байгаа улсуудыг бууруулах ийм зорилготой учраас татварын бодлого хамгийн сайн аргачлал байгаа. Тэр утгаараа 2027 он буюу 2027 оны 1 дүгээр сарын 1-нээс янжуур тамхи 2 мянган төгрөг нэмэхээр байгаа, 2 мянган төгрөг, нэлээн огцом нэмэлт өгч байгаа. Бид ингэж ер нь тамхины хэрэглээг бууруулах энэ татварын бодлогыг хэрэгжүүлэхээр зорьсон. Энэ цочирдож магадгүй. Гэлээ гэхдээ бид хүний халаасны санхүүгээр нь тамхины хэрэглээг бууруулах энэ бодлогоосоо ухраагүй байгаа гэдгийг хэлчихье.

П.Ганзориг: Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Зүйлээр гэсэн болохоор төслийн 1 дүгээр зүйлийн нэг дэх заалтын энэ 3.1.13 буюу татах төхөөрөмжийн эд анги гэж татах төхөөрөмж дагнан хэрэглэдэг хэсгийг гэсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр энд яг ямар, ямар төрлийн төхөөрөмжүүд орж байгаа юм бэ? Хэдэн янзын төрөл байгаа вэ? Тэгээд энэ нь одоо байгаагаас яг хэрхэн шинэчлэгдэж байгаа гэдэг зүйл заалтыг нь, жагсаалтыг нь сонсмоор байгаа. 2 дугаарт энэ ажлын хэсгийн баг дотор зан үйл судлаач байгаа юу? Ер нь энэ донтолтын талаар тайлбарлах тайлбаруудыг нэг жаахан нэммээр байгаа юм. Яагаад гэвэл донтолт чинь өөрөө никотиноосоо гадна донтуулдаг нэмэлт хүчин зүйлүүд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ татах төхөөрөмжүүд дотор донтолтыг дэмжигч хүчин зүйл бий. Тэгээд тэр дээр нэмж тайлбар өгөх хүн байна уу?

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Ж.Чинбүрэн: Татах төхөөрөмжийн эд анги, дагалдах хэрэгслийн ангилал ялгахад хүндрэл үүсэх тул нэр томъёоны тодорхойлолтод татах төхөөрөмжийн эд

анги, дагалдах хэрэгслийг нэгтгэн татах төхөөрөмжийн эд анги болгон томьёолсон. Тэгэхээр энэ чинь дагалдах хэрэгслүүд нь их олон янз байна л даа. Ялангуяа энэ шинэ төрлийн хэрэглэдэг энэ тамхитай холбоотой дагалдах хэрэгслүүд их олон янз байгаа. Тийм учраас энийг нэр томьёог нь татах төхөөрөмжийн эд анги болгож нэгтгээд томьёолсон. Энэ дээр ГЕГ-аас энэ бараа юутай ялангуяа хяналттай холбоотой нэмэлт тайлбар хэлээд өгөх үү?

П.Ганзориг: Ажлын хэсгээс индрийн микрофоноос хариулах уу? Индрийн микрофоныг нээе.

Ч.Чимгэрэл: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Тамхины хяналтын тухай хуульд орсон тамхи татах төхөөрөмж, түүний эд анги гэдэгт одоо бол яг улсын хилээр орж ирж байгаа 2 төрлийн төхөөрөмж орж ирж байна. Нэгэнд нь айкос /IQOS/ буюу халаадаг тамхины төхөөрөмж орж ирж байгаа, нөгөөдөх нь болохоор электрон тамхи буюу шингэнтэйгээ хамт орж ирдэг цэнэглэж хэрэглэдэг ийм 2 төхөөрөмж орж ирж байгаа. Электрон тамхины төхөөрөмжийн хувьд энэ өөрөө шингэнийг халааж ууршуулах зорилгоор энэ дотор нь байдаг халаагч хэрэгсэл байдаг. Цэнэглэгч батарей байгаа, дээрээс нь ийм юу гэдэг юм яг дотор нь тэр халаагч хэрэгсэлд хадгалагдаж байгаа тийм зэс утаснууд байж байдаг. Тэгэхээр энийг бол салгаад ирэх боломжтой, салгаад улсын хилээр оруулж ирэх боломжтой байгаа. Тийм учраас эд анги гэж оруулж өгсөн.

Халаагч тамхины хувьд үндсэн 3 хэсгээс бүрдэж байгаа. Үүн дотор нь та бүхний мэдэж байгаа нөгөө айкос /IQOS/-ны гаанс байгаа, дээр нь нөгөө тэр айкосныхноо гаансыг хийдэг гэр байгаа, гэр нь өөрөө хавтас нь салдаг ийм ийм зүйл байгаа. Тэгэхээр эдгээр хэрэгслүүд маань өөрсдөө дангаараа энэ худалдаанд эд анги болоод орж ирдэг. Тийм учраас Тамхины хяналтын тухай хуульд тамхин бүтээгдэхүүнтэйгээ нийцүүлээд эд анги болон татах төхөөрөмжийг нэр томьёонд оруулж өгсөн байгаа.

П.Ганзориг: Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Гар утасны гоё кэйс байгаа учраас хүмүүс тухайн төрлийн утаснуудыг их хэрэглэдэг. Гоё зүүлт, гэр энэ чинь өөрөө тухайн зүйлийн хэрэглээг дэмждэг ийм зүйл гэдгийг зан үйл судлаач ярьдаг. Тэгэхээр би нөгөө зан үйлийн тайлбар сонсох гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ ажлын баг дотор зан үйл судлаач ийм хүн байна уу? Донтолтыг яг тайлбарлачих хүн байна уу? Донтолт чинь өөрөө дотроо 2, 3 түвшинтэй л дээ. Никотин болон давхар тэр хэрэглээндээ байгаад байгаа байхгүй юу. Англиар usability буюу биед эвтэйхэн, гарт эвтэйхэн зүйлүүдийг бид хэрэглэж дадсан шиг энэ тамхи чинь тэрэндээ байгаад байгаа байхгүй юу. Гоё хэлбэртэй тамхи татдаг шиг асуудлууд л яваад байна шүү дээ. Тэгэхээр тодруулчихъя. Энэ дагалдах тоног төхөөрөмж, эд анги дээр татвар нь яаж нэмэгдэх юм бэ? Энэ дагалдаж ингэж явж байгаа юу?

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Ж.Чинбүрэн: Манай ажлын хэсгийнхэн нэлээдгүй энэ сэдвээр маргалдсан, ярьсан. Энэ дээр гол никотин агуулсан биш, туслах төхөөрөмж гэдэг утгаараа зөвхөн гаалийн татвар тавигдана. Онцгой албан татвар никотин агуулаагүй, яг

тамхин бүтээгдэхүүн биш гэдэг утгаараа татварын онцгой албан татваргүй, гаалийн татвартай байхаар тусгасан байгаа.

П.Ганзориг: Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Хэрэглээг бууруулах гэж байгаа зорилготой хуулийн төслийн өөрчлөлт, хэрэглээ гэдэг чинь тэр кэйс нь байна уу, гадна тал нь дагалдах энэ тоног төхөөрөмж чинь, эд анги чинь бүгд тэр хэрэглээгээ бий болгож байгаа хүчин зүйлс. Тэгэхээр жишээлбэл энэ тамхины хэрэглээг бууруулах ажлын хэсэг байж, тамхиа хэрэглэ гэж байгаа юм шиг тэр дагалдах төхөөрөмжид нь байдаг татварыг үндсэн тамхинаасаа багаар тогтоох эсвэл өөрөөр тогтооно гэдэг чинь юу гэсэн үг вэ? Өөрөөр хэлбэл архинаас нь татвар оногдуулаад байгаа мөртөө архиных нь хундагыг нь болохоор гоё ингээд сурталчлаад байгаатай ялгаагүй байхгүй юу энэ чинь чанарын хувьд. Тэгэхээр ийм санал гаргачхаад энийгээ тамхины хэрэглээг бууруулж байна гэж ярьдаг ямар ажлын хэсэг байдаг юм.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Ж.Чинбүрэн: Дагалдах эд ангийг стандартчилахаар тусгасан стандартчилал гэдэг маань өнгө үзэмжтэй биш. Ялангуяа энэ attractive буюу сонирхол татах хэмжээнд биш байхаар стандартчилалд нь тусгаж байгаа учраас тэр нь тийм хүний харах үзэгдэх байдлаараа сонирхол татах хэмжээнд байхгүй байхаар тусгаж байгаа шүү. Тэгэхээр бид нэгд тамхин дээр онцгой албан татварыг нэмэгдүүлж, татварыг нэмэгдүүлснээрээ хэрэглээг бууруулна. Дээрээс нь гадна үзэгдэх харагдах байдлыг 70 хүртэлх хувийг нь тийм ээ энэ эрүүл мэндэд ноцтой гэдэг ийм тэмдэглэгээнүүд оруулж өгч байгаагаараа үзэгдэх байдал нь тийм аятайхан сонирхол татах хэмжээнд биш байх ёстой тэр заалтууд нь стандарт хэмж юугаар орж байгаа шүү техникийн үзүүлэлтээр орж байгаа.

П.Ганзориг: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууя.

М.Нарантуяа-Нара: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр энэ хууль их удсан хууль гээд хүн бүхэн ярьж байна. Ялангуяа ажлын хэсэг, хууль санаачлагч энийг маш сайн цохож тэмдэглэж байгаа. Тэгэхдээ бид энэ хууль хэдий чинээ удсан байна, төдий чинээ бид дутуу дулимаг түүхийгээр нь олон талын эрх ашгийг хангаж ажиллаагүй, тэгээд олон талын судалгаанд суурилсан нотолгоонд тулгуурласан ийм зүйл байхгүй байдлаар нь бид хуулийг баталж болохгүй гэж би ойлгож байгаа. Нэг талаараа ажлын хэсэг тодорхой тооны хурал хийсэн, 3 ч ахлах ажлын хэсгийн дарга солигдоод, Чинбүрэн даргын ажлын хэсгийн хурал нийтдээ 4 удаа хуралдсаны 3 нь яг асуудлыг хэлэлцэх хурлууд болсон байгаа.

Тэгэхээр 1 зүйлийг хэлэлцэхэд бид ажлын хэсэг дээр маш олон талын маргаан гарч байгаа энэ дээр. Яагаад гэвэл хууль санаачлагчийн олон нийтэд хүргэж байгаа өнцөг болон хууль санаачлагчийн оруулж ирсэн энэ хууль 2 өөрөө дотроо асар том зөрүүтэй байгаа байдлыг бид байнга олон талаас нь мэтгэлцсэн. Ажлын хэсэг дээр нэлээн олон зүйлүүдийг бид сайжруулах бодит нөхцөл байдалтай уях ийм асуудлуудыг тавьж байгаа ч гэсэн эцэслэж дүгнээгүйгээр мэргэжлийн Байнгын хороо руу орж ирж байгаа шүү гэдгийг энд цохон тэмдэглэх нь зүйтэй.

Эндээс би 1 дүгээр зүйлтэй холбоотой нэг асуудлыг асууя. Бид урьд нь ч ярилцсан энэ асуудлыг шийдээгүйгээр орж ирсэн. Тэгэхээр бид энэ юун дээр энэ сэтгэл зүйн эмгэг, эмчилгээ гэдэг асуудлыг бид шийдээгүй шүү дээ. Тэгэхээр яг энэ хуульд ажлын хэсэг дээр ярилцсанаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв /СЭМҮТ/-д тамхинаас гарах энэ ажлыг СЭМҮТ хариуцна гэсэн байдлаар орж ирж байгаа. СЭМҮТ яг бодит байдал дээр ерөөсөө өөрсдийнхөө үндсэн ачааллыг дийлэхгүй ийм нөхцөлтэй байж байхад бид дээрээс нь давхар тамхины энэ хорт зуршилд донтсон хүмүүсийг СЭМҮТ рүү явуулна гэвэл СЭМҮТ-ийн ачаалал хэрээс хэтэрнэ. Дээрээс нь яг үнэндээ СЭМҮТ-ийг зориод тамхинаас гарах гээд хорт зуршлаасаа салах гээд явж байдаг хүмүүс ч гэж байхгүй учраас бид олон талын арга замуудыг ярилцсан ч гэсэн шийдээгүйгээр орж ирсэн. Тэгэхээр энэ асуудлыг яах юм бэ гэдэг асуултыг тавья.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Ж.Чинбүрэн: Хуулийн төсөлд СЭМҮТ дангаараа ороогүй. Сэтгэл зүйн тусламж заавал СЭМҮТ-өөр дамжихгүйгээр тусгаж байгаа, нэг ёсондоо бид хувийн болон төрийн байгууллагууд энэ донтолттой холбоотой эмчилгээ, ялангуяа энэ СЭМҮТ Монгол Улсын тэргүүлэх төв нь. Энэ удирдамж, стандартаа боловсруулах, эмчилгээг нэвтрүүлэх, арга барилыг нэвтрүүлэх энэ тэр гэсэн гол ажил хийнэ. Тийм учраас бид хуулийн юундаа заавал СЭМҮТ бүгдийг хийнэ гэдэг утгаар биш тусгасныг Нарантуяа-Нара гишүүн та санаж байгаа байх. Тэгэхээр бид дэмжих үйлчилгээ, мөн эмийн эмчилгээ гэж заалтууд оруулж өгсөн. Яг тэр хийнэ гэж зааж өгөх нь өөрөө утгагүй. Тийм учраас бид нөгөө төрлөөр нь ялгаад ийм тамхинаас гарах үйл ажиллагааг дэмжих энэ эмчилгээнүүд байна шүү гэдэг л ийм тодорхой заалт оруулж өгсөн байгаа. Мэдээж би ажлын хэсэг бид төгс төгөлдөр бүгдийг хийчихсэн гэж хэлж чадахгүй, харин тийм учраас өнөөдөр мэргэжлийн Байнгын хорооны гишүүд та бүхэн улам сайжруулах тал дээр санал бодлоо хэлж, ярьж, саналаа хурааж, зүйл, заалт бүр дээр ажлын хэсгийн гаргасан санал дээр саналаа нэмэрлээд явах байх гэж найдаж байна.

П.Ганзориг: Нарантуяа-Нара гишүүн тодруулъя.

М.Нарантуяа-Нара: Тийм ээ, ажлын хэсгийн ажил бол төгс битгий хэл дундаж түвшнийг ч гэсэн хангаж ажиллаагүй шахуу байгаа. Дээрээс нь ажлын хэсгийн гишүүд хэт нэг талыг барьсан, багцлагдсан ийм гишүүд байсныг энд дурдъя. Ялангуяа ажлын хэсгийн гишүүдэд мэдээллээр хангаж байгаа энэ талууд нь багцлагдсан ийм тал байсан шүү гэдгийг би цохон тэмдэглэж хэлье.

Түрүүн Саранчулуун гишүүн хэлсэн. Энэ донтолтын суурийг бид энд ерөөсөө судлаагүй. Яагаад донтсон юм, ер нь зан байдал нь юу юм, ийм зүйлийн судалгаануудыг бид энд ерөөсөө авч үндэслээгүй байгаа шүү. Ийм зүйлээс бид хууль батлаад явуулах гэж байгаа шүү гэдгийг энэ ажлын хэсэгт багтаагүй бусад гишүүдээс мэдээсэй гэж хүсэж байна. Баярлалаа.

П.Ганзориг: Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа. Байнгын хорооны гишүүд санал хураалтад бэлдье. Ингээд ажлын хэсгээс гарсан 1 дүгээр зүйлтэй холбоотой 5 санал хураалт явагдана. Тэгээд араас нь УИХ-ын гишүүдээс гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор саналууд хураагдана.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 3.1.12 дахь заалтын “тоног” гэснийг хасаж, мөн заалтын 3.1.13, 3.1.14 дэх заалтыг нэгтгэн “3.1.13” дахь заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.13.”татах төхөөрөмжийн эд анги” гэж татах төхөөрөмжид дагнан хэрэглэдэг хэсгийг.” Санал гаргасан УИХ-ын гишүүн Чинбүрэн, Баярбаатар, Баасанжаргал, Бум-Очир, Ганбаатар, Жаргалан, Нарантуяа-Нара, Сайнзориг, Ундраа, Цэнгүүн, Энхнасан цаашид ажлын хэсэг гэх. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, санал 82.4 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.7.16 дахь заалтын, мөн зүйлийн 5 дахь заалтын 7².3 дахь хэсгийн “дагалдах хэрэгсэл, татах төхөөрөмжийн” гэснийг “түүний” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн оролцсоноос 12 гишүүн дэмжиж, санал 70.6 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 6.8.3 дахь заалтын “байрлуулж” гэснийг “байрлуулах бөгөөд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн оролцсоноос 12 гишүүн дэмжиж, санал 70.6 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын “6.8¹” гэснийг “6.10” гэж өөрчилж, мөн хэсгийн “Үндэсний зөвлөл” гэснийг “төв байгууллага” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн оролцсоноос 13 гишүүн дэмжиж, санал 76.5 хувиар дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 11¹.6 дахь хэсгийн “үйлдвэр, худалдааны асуудал” гэснийг “хүнсний асуудал” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн оролцсоноос 12 гишүүн дэмжиж, санал 70.6 хувиар дэмжигдлээ.

УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.20-ийг та бүхэнд уншиж танилцуулъя. Төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр 2 ба түүнээс дээш зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналыг танилцуулж санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцож, тэдгээр саналаар санал хураалт явуулахгүй. Энэ хуулийн 39 дүгээр зүйлийн 39.9-д заасны дагуу ажлын хэсэг байгуулсан ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураалт явуулна гэсэн ийм хуралдааны хуулийн дэгтэй. Тэгээд хуулийн дэгийг та бүхэнд уншиж танилцууллаа.

УИХ-ын гишүүн Л.Энхнасангаас ирсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя. “6.7.16.электрон никотин дамжуулах систем, тамхи болон гаанаас өөр төрлийн үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байх;” гэсэн ийм саналын зарчмын зөрүүтэй саналын томъёолол ирүүлсэн байна. Батбаатар гишүүнээс ирсэн санал. 6.7.16 дахь заалтад дараах агуулгатай нэмэлт, өөрчлөлт оруулахаар байна. “6.7.16.тамхин бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд орц, найрлагад хэрэглэхийг хориглосон бодисыг холбогдох техникийн зохицуулалтын

шаардлагаар тодорхойлно” гэдэг ийм томьёололтой санал ирүүлсэн байна. Нарантуяа-Нара гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй санал. “6.7.16.тамхи, татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, татах төхөөрөмжийн эд ангид тамхи болон гаанаас өөр төрлийн үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байх.” ийм заалтыг бүхэлд нь хасах гэдгээр санал ирүүлсэн байна. Шижир гишүүнээс ирүүлсэн санал. “6.7.16. тамхи, татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, татах төхөөрөмжийн эд ангид тамхинаас өөр төрлийн үнэр, амт оруулагч бодис, бэлдмэл нэмсэн байх” гэж өөрчлөх. Ингээд гишүүдийн ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулж дууслаа. Нарантуяа-Нара гишүүн гаргасан зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлая.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр УИХ-ын гишүүдээ, энэ заалтыг яагаад хасъя гэсэн саналыг оруулсан бэ гэхээр зэрэг энэ амт, үнэр оруулагчтай энэ тамхины амт, үнэр оруулагчийг нь хассанаар бий болох эрсдэл, үр дүнг бодитоор хэмжээгүй байгаа юм. Яагаад гэвэл амт, үнэрийг хассанаар, жишээлбэл, хүүхдийг хамгаалъя гэж байгаа, хүүхэд гүзээлзгэнийн амтанд болоод энэ тамхинд илүү их донтож байна гэж байгаа юм. Тэгвэл энэ тамхины амт, үнэр, гүзээлзгэнийн амтыг нь хаслаа гэхэд үлдэх гааны амттай болон бусад тэр амтгүй бүтээгдэхүүнийг хүүхэд хэрэглэхгүй гэсэн тэр тооцоолол, эрсдэлийн тооцоолол, судалгаа байхгүй. Мөн энэний хажуугаар албан ёсны зах зээлийг хумихад хүргээд, харин үүсээд нөгөө үнэр, амттай бүтээгдэхүүн нь хууль бусаар орж ирж, нийгэмд хууль бус худалдааг ямар түвшинд хүрэхийг, эрсдэлийг тооцоолсон судалгаа байхгүй.

Өөрөөр хэлбэл энэ үнэр, амтгүй болсон ч гэсэн хүүхдүүдийг өөр бусад төрлийн тамхин бүтээгдэхүүн рүү орохгүй байх эрсдэл, үнэлгээг судлаагүй, хамгаалалтын механизмыг бодитоор тусгаж өгөөгүй байдлаараа энэ зүйл заалт нь энэ үнэр, амтыг хориглосон ч гэсэн хүүхдийг бүрэн тамхинаас хамгаалах бодит үр дүн байхгүй учраас үнэр, амт нь байсан, байгаагүй энэ хуулийн төсөлд энэ ялгаа алга байна гэсэн байдлаар энэ үнэр, амтыг хориглоод ч нэмэргүй байна гэснийг хориглоё гэснийг хасъя гэсэн санал дэвшүүлсэн байгаа шүү. Тэгэхээр та бүхэн дор бүрнээ бодолцож үзээрэй. Баярлалаа.

П.Ганзориг: Ажлын хэсгээс үг хэлсэн нь дээр байх энэ дээр, ажлын хэсгийн ахлагч хариулья.

Ж.Чинбүрэн: Ер нь манай дэд ажлын хэсгээс бидэнд нотолгоо, судалгаа гаргаж өгөхдөө ер нь ийм зарчмын зүйлийг би энэ Байнгын хорооны гишүүддээ нэг хэлье гэж бодож байна. Ер нь бид энэ хяналтын тухай, энэ Тамхины хяналтын тухай хуулийн гол зорилго нь юу вэ? Бид өсвөр үеийнхэн, бага насны хүүхдүүдээ тамхи татдаг болох, никотинд хамааралтай болохоос сэргийлье.

2 дахь нь, 2 дахь чухал зүйл одоо тамхи татаж байгаа хүмүүсийг тамхинаас гаргадаг байх энэ үйл ажиллагааг дэмжье, ингэхийн тулд юу хийх юм бэ гэдэг асуудал байхгүй юу. Тэгэхээр манай ажлын хэсгийн гол ажил ерөөсөө яаж өсвөр үеийнхнээ энэ тамхинаас сэргийлэх вэ, хамгаалах вэ гэдэг. Нарантуяа-Нара гишүүний хэлж байгаа зүйл энэ хяналтын тогтолцоогоо сайжруулаад, энэ хэрэглэгчийн эрхэнд халдахаа боль гэсэн ийм санал хэлж байгаа. Зарим гишүүд, тэр дотроо Төсвийн байнгын хороогоор хүртэл энэ асуудал орсон. Тэнд хэрэглэгчийн сонголтын эрхэнд халдаж байна гэсэн. Үүнтэй холбоотойгоор далд

бизнес хөгжихөд нөлөөлөх вий гэсэн ийм сэрэмжлэг, үр дагаврыг болгоомжлоорой гэж хэлсэн.

Тийм учраас бид олон талаас нь судалж, харж ярьсан. Яах вэ зүгээр олон улсын судалгаа, дээрээс нь энэ олон улсын байгууллагуудын өгч байгаа зөвлөмж эд нарыг харвал ерөөсөө өсвөр үеийнхнийг никотины хамааралтай болохоос сэргийлэх зүйл, ялангуяа энэ вэйп /vape/ буюу цахилгаан тамхин дээр амт, үнэр, ялангуяа энэ шоколадны амттай, жимсний амттай, кока коланы /Coca-Cola/ амттай энэ байдлыг хорьсноороо сэргийлж чадна гэсэн ийм зүйл яриад байгаа. Яг одоогоор Нарантуяа-Нара гишүүний хэлж байгаагаар бид аль чиглэлийг барих вэ гэдгээ бид гишүүд та бүгдийн өмнө сонголт энэ санал хураалт. Одоо энэ хэлээд байгаа зүйл дотор бид амт, үнэрийг хориглосон, тэгсэн хэр нь нөгөө ментолыг үлдээчихсэн байна гэж та бүхэн уншаарай. Тэгж харагдаж байгаа шүү, тийм ээ.

П.Ганзориг: Тэгэхээр гишүүдийн тийм зарчмын зөрүүтэй гаргасан саналын томьёоллоор санал хураана. Би тэгээд энэ Энхнасан гишүүн өөрөө байхгүй байгаа учраас жаахан тодорхой мэдээлэл, ойлголтыг нь сайн өгсөн нь дээр байх гэж бодож байна. Тийм. Энд Энхнасан гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал дээр янжуурынх нь гаанаас гадна үнэр, амтыг нь хорихгүй үлдээгээд, зөвхөн электрон тамхин дээр электрон тамхины никотин дамжуулах систем болон гаанаас өөр төрлийн үнэр, амт оруулах бодисыг, бэлдмэлийг нэмсэн байх гэдэг нь энэ дээрээ үлдээ гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл янжуур тамхийг нь болохоор хориод, зөвшөөрөөд гэсэн үг. Зөвшөөрөөд гэсэн үг, электрон тамхиа хорьё гэж байгаа юм байна нэмж. Тэгэхээр би энийг яагаад тайлбарлаж байна вэ гэхээр гишүүд томьёоллыг нь сайн ойлгож байгаад, ямар агуулгаар нь ингэж байгаад санал хураалтдаа саналаа өгөхгүй бол болохгүй шүү. Тийм учраас би энэ тодорхой энийг нь ингэж болох үүднээс нэмэлт ийм тайлбарыг та бүхэнд хэлье. Ингээд санал хураалтдаа бэлдье.

Дахиад би энэ дэгийн хуультай холбоотой тодорхой тайлбар нэмж өгье. Тэгэхээр яг энэ 6.7.16 дээр ингээд дарааллаар нь ирүүлснээс нь санал хурааж байгаа, эхний гишүүний гаргасан санал дэмжигдэх юм бол дараагийн саналууд нь дэмжигдэхгүйгээр, тэгэхдээ танилцуулагдаад явдаг шүү дээ. Тийм дэгтэй, танилцуулчихсан байгаа. Тэгэхээр энэ хэрвээ дэмжигдэх юм бол дараагийн саналуудаар санал хураахгүй гэсэн үг. Энэ дэмжигдэхгүй тохиолдолд дараагийн санал руугаа ороод явна гэсэн үг. Тэгэхээр би саналын томьёоллоор уншиж танилцуулаад санал хураалтыг явуулъя.

“6.7.16.электрон никотин дамжуулах систем, тамхи болон гаанаас өөр төрлийн үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байх” гэсэн заалт, саналын томьёоллоор санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос нэг ч гишүүн энэ дээр дэмжиж санал өгөөгүй учраас энэ санал уналаа.

Батын Батбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол. “6.7.16.тамхин бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд орц, найрлагад хэрэглэхийг хориглосон бодисыг холбогдох техникийн зохицуулалтын шаардлагаар тодорхойлно.” гэж байгаа юм байна. Өөрөөр хэлбэл хуульд тусгахгүйгээр Стандарт, хэмжил зүйн газар /СХЗГ/-т эрхийг нь өгч байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ хуулийн гол амин сүнс, ач холбогдол тийшээ шилжинэ гэсэн агуулга энэ дээр явж байгаа юм биш үү. Тийм

болохоор гишүүд энэ зарчмын зөрүүтэй санал дээр шаардлагатай ажлын хэсэг нэмэлт хариулт өгч болно. Ажлын хэсгээс нэмж хариулъя.

Ж.Чинбүрэн: Энэ тайлбарлах юм бол нэг ёсондоо СХЗГ-оос тухайлбал нэмж байгаа тэр аюул-тууд нь хүний эрүүл мэндэд хоргүй гэж үзэх юм бол тэрийг СХЗГ-оос зөвшөөрнө л гэсэн санаа. Тэгэхээр тэндээ зөвшөөрнө, зөвшөөрөхгүй гэдгээ шийд, хуулиараа бид энийг хөндөхгүй л гэсэн санаа хэлж байна.

П.Ганзориг: Санал хураалтыг явуулъя. Батын Батбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол. “6.7.16.Тамхин бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд орц, найрлагад хэрэглэхийг хориглосон бодисыг холбогдох техникийн зохицуулалтын шаардлагаар тодорхойлно.”. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн оролцсоноос 4 гишүүн дэмжиж, 23.5 хувиар уг санал дэмжигдсэнгүй уналаа.

Нарантуяа-Нара гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя. “6.7.16.Тамхи, татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, татах төхөөрөмжийн эд ангид тамхи болон гаанаас өөр төрлийн үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байх” гэсэн заалтыг бүхэлд нь хасах гэсэн саналын томъёолол байна. Тэгэхээр ажлын хэсгээс энэ дээр нэмэлт тайлбар өгнө. Ажлын хэсгийн ахлагч, ажлын хэсгийн гишүүн Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн зүгээс ганцхан тайлбар хэлчихье. Нөгөө огт судалгаагүй гээд байгаа учраас тайлбар хэлэх нь зөв байх. Энэ хууль санаачлагчаас өргөн барьсан судалгаануудыг дахиад дэлгэрүүлээд харсан. Дани улс яг энэ үнэр, амтыг хориглосноор Дани улсын залуучуудын тамхины хэрэглээ 15 хувиар, Эстони улсынх 25 хувиар, Финланд улсынх 20 хувиар, Унгар улсынх 80 хувиар, Литва улсынх 18 хувиар буурсан гээд ингээд маш олон судалгаанууд хангалттай байгаа шүү гэдгийг хэлье.

П.Ганзориг: Хууль санаачлагч талаас товч мэдээлэл өгчих, зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүнээс.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр тийм, ийм судалгаанууд байгаа. Тэгэхдээ судалгаанууд нь эргээд дандаа, жишээлбэл АНУ-д ч гэсэн амт, үнэрийг хориглосноороо хууль бус зах зээлийг хянаж чадахгүй, эсрэгээрээ өсвөр насныхан болоод үндсэн тамхины насанд хүрсэн хэрэглэгчид бүгдээрээ буцаад нөгөө илүү хортой тамхи, янжуур тамхи руугаа орсон нь дам тамхидалт, дам эрүүл мэндийн хор уршгийг үүсгэж байгаа учраас 4 дүгээр сард энэ амт, үнэр хориглосон энэ хуулиа цуцалсан ийм мэдээлэл байгаа. Мөн түүнчлэн энэ эш татаад байгаа Канад, Финланд, энэ Нидерланд улсуудад, жишээлбэл Финланд улсад 96 хувийн вэйпний тамхины хэрэглээ буурсан эерэг үзүүлэлттэй юм шиг мөртөө нөгөө талаар нөгөө илүү хор уршигтай тамхи руугаа 93 хувь нь шилжсэн гэсэн энэ судалгаанууд байгаа шүү. Энэ судалгаа олон байгаа. Гэхдээ судалгаа нь дандаа нэг талыг барьсан, дээрээс нь ажлын хэсгийн олонх гишүүд судалгааны нэг талыг барьсан энэ үндэслэлийг, судалгааг үндэслэж байгаа учраас бид юун төлөө 5 намын төлөөлөл энэ УИХ-д орж ирсэн юм. Юун төлөө олон талаас нь, олон талын эрх ашгийг, олон эрсдэл, үр дүнг нь хангаж энэ хуулийг батлах ёстой юм. Энэ хүрээндээ энэ хүмүүсийн дурдахгүй байгаа судалгаануудыг би хэлж байгаа юм шүү гэдгийг ойлгоорой.

П.Ганзориг: Тэгээд энэ Тамхины хяналтын тухай хууль дээр энэ гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй санал дээр би гишүүдийг зарчмын зөрүүтэй санал гаргасан үндэслэл, тайлбарыг нь хангалттай хэлүүлж байгаа, ажлын хэсгийг ч гэсэн тайлбарлуулж байгаа. Ингээд гишүүд маань бие биеийнхээ тайлбар, хариултад хүндэтгэлтэй хандаад л өөрийнхөө хараат бус, бие даасан байдлаар саналаа өгөөд л явна гэсэн үг. Ингээд санал хураалт явуулна. Тайлбар байхгүй. Зөвхөн ажлын хэсгээс. “6.7.16.Тамхи, татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, татах төхөөрөмжийн эд ангид тамхи болон гаанаас өөр төрлийн үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байх” гэсэн заалтыг бүхэлд нь хасах гэж Нарантуяа-Нара гишүүний гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн оролцсоноос 3 гишүүн дэмжиж, санал 17.6 хувиар уналаа.

Шижир гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол. “6.7.16.тамхи, татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, татах төхөөрөмжийн эд анги нь тамхинаас өөр төрлийн үнэр, амт оруулагч бодис, бэлдмэл нэмсэн байх” гэж өөрчлөх гэж байгаа юм. Энэ саналын томьёоллоор санал хураалт явуулна. Үгүй, зөвхөн зарчмын зөрүүтэй санал гаргасан. Ажлын хэсгээс хариулт өгөх үү нэмэлт. Ажлын хэсгээс Баасанжаргал гишүүн тайлбар өгье.

Х.Баасанжаргал: Яах вэ ажлын хэсэг дээр энэ санал гараад хураах гэсэн боловч нөгөө өмнөх өдөр нь ажлын хэсэг үндсэндээ бүхэлдээ эхний 4, 5 зүйл, заалт дээр ажиллалчихсан гээд тэгээд тэгээд энэ санал хураагдаж чадаагүй цаашаа явчихсан юм. Тэгээд Байнгын хороон дээр Шижир гишүүн санал гаргаж байгаа, тэгээд яах вэ зүгээр хууль санаачлагчийн зүгээс мөн адилхан яг энэ гааны амтыг хасах нь зүйтэй гэдэг. Тэгээд бид энэ тайлбарыг тухайн үедээ хууль санаачлагчаас авч байсан. Тэгэхэд яагаад гааны амт яг энэ удаа орж ирэв гэхэд маш олон гишүүд гарын үсэг, 78 гишүүн гарын үсэг зурсан. Тэгээд эдгээр гишүүдээс дэмжсэн гишүүдийн зүгээс гааны амтыг үлдээе гэдэг ийм саналтай гишүүд байсан учраас Их Хурлын түвшиндээ энэ асуудлыг шийдэх нь зөв гэдэг байдлаар хууль санаачлагчаас оруулж ирсэн гэдэг ийм тайлбарыг хэлсэн байгаа. Тэгээд би хувийнхаа зүгээс энэ гааны амтыг адилхан хасах нь зүйтэй гэж үзэж байгаа.

П.Ганзориг: Шижир гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн оролцсоноос 9 гишүүн дэмжиж, санал 52.9 хувиар дэмжигдлээ.

Мөнхсайхан гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал. Би саналын томьёоллыг уншиж танилцуулъя. Төслийн холбогдох зүйлд дараах агуулгатай хэсэг нэмсүгэй: “6.7.17.2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэнд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүнийг худалдахыг хориглоно. Энэ хэсэгт заасан этгээдэд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүн худалдсан, нийлүүлсэн, үнэ төлбөргүй олгосон этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн ийм агуулгатай юм байна. Зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүн Мөнхсайхан гишүүн тайлбар хэлье.

Т.Мөнхсайхан: Бид ер нь нийгмийн эрүүл мэнддээ анхаардаг, ард иргэдийнхээ эрүүл зан үйлтэй байхад анхаардаг ер нь өндөр хөгжилтэй улсууд Тамхины тухай хууль дээрээ энэ хүүхдүүдэд тамхи, тамхин бүтээгдэхүүн насан

туршид нь борлуулах энэ заалтыг оруулж байгаа, ер нь хориглож байгаа гэсэн үг. Нэлээн хэд хэдэн улсууд энэ заалтыг оруулаад өнөөдөр амжилттай явж байгаа. Тэгэхээр манай улсын хувьд ч гэсэн өнөөдөр тамхинаас үүдэлтэй өвчлөл хамгийн ихийг эзэлж байгаа, манай улсад аюул болчихоод байгаа энэ хорт хавдрын чинь хамгийн их шалтгааныг тамхи эзэлж байгаа шүү дээ. Тэгэхээр бид ирээдүй болсон хүүхэд залуучуудаа бүр тамхи хэрэглэдэггүй болгочихъё, тамхи гэж мэддэггүй болгочихъё. Янжуур тамхи ч бай, электрон тамхи ч бай хэрэглэдэггүй болгож ингэж чадах юм бол бид үнэхээр ирээдүйдээ оруулж байгаа том хувь нэмэр, маш том шийдвэр шүү. Тэгэхээр энэ дээр та бүхэн маань нэг зоригтойнхон шиг шийдвэрүүд гаргаад энэ заалтыг дэмжээд, бүр цаашид нь яг энэ хуульд энэ зүйл, заалтаараа ороод батлагдах хүртэл та хэд маань ажиллаасай гэж ингэж хүсэж байна. Баярлалаа.

П.Ганзориг: Ажлын хэсгээс Чинбүрэн гишүүн ажлын хэсгийн ахлагч тайлбар өгье.

Ж.Чинбүрэн: Энэ Их Британийн Smoke-free Generation гэх нөгөө хуулийн үзэл санааг давтагдаж байгаа. Ингээд Их Британи 2009 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш төрсөн хүүхэд тамхи татахааргүй болж байгаа, нэг ёсондоо насан туршдаа тамхи хэрэглэхгүй байна. Сонсоход сайхан. Би өөрөө тамхи татдаггүй. Ялангуяа хавдрын эмч хүний хувьд тамхи татахгүй байхыг үнэхээр 2 гар өргөөд дэмжмээр байна. Зүгээр яг энэ асуудлыг хэлэлцэх үед ажлын хэсэг дээр яригдсан зүйл АНУ-ын гучаад оны нөгөө архины хуурай хууль шиг юм болчих вий гэдэг ийм болгоомжлол яригдсан учраас цаг хугацааны үед өнөөдөр бид энийг ярьж хэлэлцэж шийдэж чадах эсэхээ мэдэхгүй байна. Хангалттай дэмжигдэх эсэхийг мэдэхгүй байгаа учраас бид энийг цааш нь хэлэлцэж чадаагүй гээд хэлчихье.

П.Ганзориг: Тийм. Өөрөөр хэлбэл энэ чинь 2010 гээд он заачихна гэдэг чинь одоо бол 16 настай гэсэн үг, 10 жилийн дараа 26, ингэсээр байгаад магадгүй 30 жилийн дараа, 40 жилийн дараа ихэнх хүмүүсийг нөгөө тамхи татахыг тэр чигээр нь хориглож байгаа байхгүй юу. Тийм л заалт байхгүй юу. Өөрөөр хэлбэл 2 мянга, тэгэхээр ирээдүйд огт тамхи хэрэглэхийг хориглож байгаа гэсэн агуулгатай заалт. Тийм болохоор агуулгынх нь хувьд би тайлбарлаж өгөөд байгаа нь томъёоллыг нь нэлээн сайн ойлгож байгаад саналаа өгөхгүй болохгүй шүү. Тэгээд Мөнхсайхан гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн оролцсоноос 7 гишүүн дэмжиж, санал 41.2 хувиар уналаа.

Хассуурийн Ганхуяг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал. Би саналын томъёоллыг уншиж танилцуулъя. Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 7^{2.3} дахь хэсгийг бүхэлд нь хасах гэж байна. Энийг ажлын хэсгээс тайлбарлалч. Яг энэ 7.2.3 дахь хэсгийг бүхэлд нь хасах гэдэг нь яг ямар агуулгатай заалтыг бүхэлд нь хасахаар зарчмын зөрүүтэй санал гаргаж байгааг нь тайлбарлана уу. Дэгээрээ ажлын хэсгийн ахлагч эсвэл аль нэг гишүүн нь тайлбарлаж болно. Ажлын хэсгийн ахлагч тайлбарлая.

Ж.Чинбүрэн: Энэ Хассуурийн Ганхуяг гишүүн энэ олон зөвшөөрөл нэмэгдэх гээд байна гэсэн ийм байр сууриас хандаж байгаа. Тухайлах юм бол тамхи худалдаалахад хүртэл тусгай зөвшөөрөл авна, дээрээс нь мөн дагалдах хэрэгсэл дээр бүр дээр нь тусгай зөвшөөрөл авах юм байна тэгж уншигдаад байна гээд.

Хууль санаачлагчийн анх бичигдсэн зүйлд нэгдсэн байдлаар ерөөсөө л тамхины зөвшөөрөлтэй бол дагалдах хэрэгслээ өөрөө оруулах гэсэн ийм агуулгатай байсныг би зүгээр найруулаад л яг тэр утгаар л уг нь бичсэн юм. Тэгэхээр тэгж уншигдаад байна гэж байгаа юм. Та бүхэн анхаараарай. Бид ер нь олон зөвшөөрөл хэрэггүй шүү дээ. Нэгэнт л тамхи оруулах зөвшөөрөлтэй бол түүнийхээ дагуу дагалдах хэрэгслүүдээ оруулж ир л гэдэг ийм байр суурьтай байгаа шүү. Тэгэхээр тэгж уншигдаад байна гээд байгаа юм. Та бүхэн нэг анхаараад өгөөч.

П.Ганзориг: Хуулийнхаа төсөл дээр байгаа би заалтыг нь уншаад танилцуулчихъя. 7^{2.3} гэсэн заалт нь “тамхи, тамхи татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, татах төхөөрөмжийн эд анги үйлдвэрлэх, худалдах, импортлоход энэ хуулийн 7, 7¹, 7² дугаар зүйл нэгэн адил үйлчилнэ” гээд нөгөө зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт байгаад байгаа юм. Тэгээд энийг нь хасчихъя гэсэн ийм саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад нийт 17 гишүүн оролцсоноос нэг ч гишүүн дэмжээгүй, энэ санал уналаа. Чинбүрэн гишүүнийг татгалзсанаар авъя. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан УИХ-ын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол санал хурааж дууссан.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Зарчмын зөрүүтэй санал гаргах, асуулт асуух гишүүн алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Ариунзаяа гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Энэ нөгөө дараа нь томъёолоход тэдээс тэд гээд явахгүй л бол нөгөө анхны хууль болон зүйл дугаарууд нь хоорондоо зөрөөд байх шиг байх юм. Энэ 3 дугаар зүйл нь хууль дээрээ 5 дугаар зүйл гэхчхэн байгаад байгаа байхгүй юу. Энэ 5 дугаар бүлэг зүйл 5 дахийнх нь мөн биз дээ, биш үү? Миний асуулт болохоор энэ 11 дүгээр санал, 10 дугаар санал байхгүй юу энэ ажлын хэсгийн. 5.3.1, 5.3.3 би зөв харж байна уу, буруу харж байна уу? Тэгсэн мөртөөсөө энэ төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 5.3.1 гэхчхэн байгаа байхгүй юу та хэдийн тараасан дээр чинь. Тэгэнгүүт би 3 дугаар зүйлтэй саналаа асуугаад байгаа байхгүй юу, мөн биз дээ? 3 дугаар зүйлийн 5 дугаар зүйл, юу гэсэн ч үг юм. 3 дугаар зүйлийн 5 дугаар зүйл гэхээр чинь ингээд энэ чинь чуулган дээр ч гэсэн асуудал үүсэхээр байна шүү. Энийгээ томъёоллуудаа нэг харчхаарай.

Би энэ хуультай холбоотой хассан заалтуудтай холбоотой асуулт асуумаар байна. Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүргийг хүлээнэ гэж оруулсан хэсэг дээр хууль санаачлагчийн ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрт тамхины хор уршиг, насанд хүрээгүй иргэнийг тамхинд орохоос урьдчилан сэргийлэх агуулга энэ хичээлд тусгаж, хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсролын хичээлээр нь дамжуулж заана гэсэн энэ заалтыг хассан байгаа нь ямар утга учиртай хассан юм бэ гэдэг ийм асуултыг ажлын хэсгээс асууя?

Бүх шатны сургуулийн орчинд тамхи худалдах, хэрэглэхийг хориглох, зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэх, хамтран ажиллах үүргийг боловсролын асуудал эрхэлсэн захиргааны төв байгууллага хүлээж байна гэдэг

чинь сургуулиараа дамжуулаад тухайн сургуулийн орчинд энэ хууль зөрчигдөөд тамхи худалдаалагдаж байвал тухайн холбогдох мэргэжлийн хяналт байдаг юм уу, эсвэл ямар байгууллагууд байдаг юм тэдгээрт сургуулийн зүгээс мэдэгдэх энэ зөрчлийг арилгуулах тал дээр хамтран ажиллах үүргийг тусгасан байсан чинь энийг нь болиод өөрчилчихсөн байх юм. Зүгээр хяналт бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын орчин дахь тамхины хяналтыг боловсролын салбарын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээд хэрэгжүүлнэ л гэсэн ийм заалтаар өөрчлөн найруулчихсан байгаа байхгүй юу. Тэгэхээр яг энэ боловсролын байгууллагын хүлээх үүрэгтэй холбоотой ийм саналуудыг яагаад гаргах болсон бэ гэдгийг ажлын хэсгээс асууя.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Ж.Чинбүрэн: Энэ их чухал сэдэв хөндөж байна. Хуулиар энэ Боловсролын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9-д бүх түвшний албан боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах агуулгыг зөвхөн энэ хуулиар зохицуулна гээд заачихсан учраас бид энэ нөгөө Боловсролын ерөнхий хуулиа барихгүй бол тэр Боловсролын ерөнхий хуулиар өгөгдсөн үүргийг бид энд татаж авчраад энд нь өгнө гэхээр энэ нөгөө хууль хоорондын уялдаа зохицуулалт дээр алдаа гараад байгаа гээд, ингээд Боловсролын яамнаас бидэнд ийм санал хэлснийг бид энд тусгасан.

Хариуцлага хүлээх юун дээр ч гэсэн дээ ерөөсөө энэ Боловсролын яамнаас бидэнд энэ саналууд өгөөд, бид хянах ажил биш, гарсан зөрчлүүдийг хэрэгжүүлэх гэхээр нь үүргийг нь гүйцэтгэж, тэр хэрэгжүүлэх гүйцэтгэх үйл ажиллагаа явуулахаас бид хяналтыг зохион байгуулах үүрэг, чиг үүрэг бидэнд алга гэсэн ийм тайлбарууд хэлсэн. Энэ дээр нэмээд хэрвээ болох бол Боловсролын яамнаас байгаа хүмүүс энэ дээр нэмэлт тайлбар хэлээд өгчих үү?

П.Ганзориг: Индрийн микрофоноос хариулъя.

Э.Чойсүрэн: Гишүүний асуултад хариулъя. Боловсролын яам, Бодлогын газар Чойсүрэн. Сая ажлын хэсгийн ахлагчийн хэлснээр Боловсролын ерөнхий хуулийн 14.9-д бүх түвшний албан боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах агуулгыг зөвхөн энэ хуулиар зохицуулна гээд заачихсан байж байгаа. Мөн Боловсролын ерөнхий хуулийн яг энэ зүйлд эрүүл мэндийн боловсрол, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, түүний хор уршиг, дэлгэцээс донтохоос сэргийлэх тухай агуулгыг бүх шатны боловсролын хөтөлбөрт заавал тусгана гээд заагаад өгчихсөн байгаа юм. Тэгэхээр нэг ёсондоо тамхи, тамхин бүтээгдэхүүнтэй холбоотой тэдгээрийн хор уршгийн талаарх агуулгыг бүх шатны сургалтын хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлэхээр Боловсролын ерөнхий хуулиар давхар заагаад өгчихсөн байгаа учраас давхардсан байна гэдэг санаагаар хасъя гэдэг санал орсон байна.

П.Ганзориг: Ариунзаяа гишүүн тодруулах уу? Номинчимэг гишүүн байна уу? Ороогүй байх шиг байх юм ирц чинь энэ дээр нэр алга. Номинчимэг гишүүн тодруулъя, асуулт асууя.

О.Номинчимэг: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Ажлын хэсгийнхээ саналуудыг хүндэтгэж байгаа. Ингээд 3 дугаар зүйл дээр яах вэ 4 асуудал дээр би

нэг тодруулга авъя гэж бодож байна. Та бүхэнд ойлгомжтой үзсэнээс зарчмын зөрүүтэй саналын 8, 15, 18, 19 байгаа юм.

8 дугаар санал энэ 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.1.2 дахь заалтыг хасах гэж байгаа юм. Нөгөө тамхины хууль тогтоомж боловсруулаад явж байхад ашиг сонирхлын зөрчил зөрчилтэй тамхи импортлогч, үйлдвэрлэгчийн саналыг татгалзах үүрэгтэй гэдэг одоогийн манай байгаа хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуульд орсон заалт байгаа. Эрдэнэчимэг гишүүн ч гэсэн 13 онд байж байхдаа энэ үнэхээр хэцүү асуудал байдаг учраас бидний суурь нэгдэж орсон Тамхины суурь конвенцын 5.2-т улс орнуудыг өөрсдийнхөө бодлогоо боловсруулахдаа тамхины компани, импортлогчдын нөлөөнд орохгүйгээр бодлогоо боловсруулах үүрэгтэй, энэ чиглэлийн хууль тогтоомжийг оруулах ёстой гэсэн үүргийн дагуу орсон энэ заалтыг хасчихсан байгаа юм. Тэгэхээр энэ дээр та бүхэн маань одоо байгаа, хэрэгжиж байгаа заалт шүү дээ, энийг дахиж хэвээр үлдээх ёстой гэсэн байр суурь байна.

15 дугаар санал дээр 5.5.1 буюу энэ уг нь энэ хуулийн зорилго нь нэг зорилго нь тамхины татварыг аваад энэ авч байгаа татвараа тамхидалтыг бууруулах эсвэл энэ эрүүл мэндэд хортой юм уу, эрүүл мэндийн асуудлаас болоод жилд бид чинь 800 тэрбум төгрөгийн эдийн засгийн хохирол амсаад байгаа байхгүй юу тамхидалтаас үүдэлтэй. Энийгээ урьдчилан сэргийлэх юмандаа энэ тамхиныхаа татварыг зарцуулаач гэсэн үзэл санаагаар энэ заалтыг оруулж ирсэн юм. Тамхины татварын энэ авч байгаа татвараа эрүүл мэнддээ, урьдчилан сэргийлэхдээ зарцуулаач гээд. Тэгээд тэр заалтыг маань хасчихсан байна. Чинбүрэн гишүүн маань өөрөө эрүүл мэндийн салбарын хүн яагаад хасчхав, энэ уг нь заалт байх ёстой. Би энэ тамхины татвараас татвар аваад хэн нэгэн даргын гадаад томилолтын зардал болчхоосой гэж бодохгүй байна. Хэн нэгэн даргын байшингийн засвар, албан байгууллагын байшингийн засвар болчхоосой гэж бодохгүй байна. Татвараа авч байгаа бол тамхинаас энийгээ эрүүл мэнддээ зарцуулмаар байна, тэгээд энэ заалтыг буцааж үлдээх саналтай байгаад байна. Тэгээд яагаад хассаныг асууя?

Гуравдугаарх 18 дугаар санал байна, 18 дугаар санал дээр уг нь энэ зурагт анхааруулга тамхи, тамхин бүтээгдэхүүний техникийн зохицуулалт нийцсэн байх гээд. Уг нь бид нэлээн нарийвчлаад нөгөө янжуур тамхи дээр чинь 50 хувийн анхааруулгатай байгаа. Цаашид бид нөгөө plain packaging буюу дэвшилтэт улсуудын юм руу орохын тулд энэ анхааруулгыг илүү 70 хувь болгоё, мөн энэ электрон тамхи чинь хортой бүтээгдэхүүн гээд үзчих юм чинь эрүүл мэндэд хортой шүү гэдэг анхааруулгатай больё гэдэг энэ зүйл заалтыг нь уг нь оруулж өгсөн юм. Тэгсэн энэ маань сулраад тэр 70 хувь маань байхгүй болгоод техникийн зохицуулалт руугаа оруулчихсан байх юм. Одоо бол энэ чинь 50 хувь гээд уг нь хууль дээрээ байгаа л санагдах юм. Янжуур тамхин дээрээ 70 хувь болгоё энийгээ анхаараад хортой гэдгээ.../минут дуусав/

П.Ганзориг: Нэмэлт минут өгье.

О.Номинчимэг: 18 дугаар зарчмын зөрүүтэй санал тэр байна. Дараагийнх нь 19 дүгээр зарчмын зөрүүтэй санал дээр савлагааны болон никотины агууламжийн стандарт байсан. Бид Европын холбооны улсаас мөрддөг directive-с гаргасан энэ стандартыг оруулсан. Энэ дээр яах вэ ингээд савлагааны асуудлууд яригдаад байснаас нэг юм нь ингээд хаягдчихсан байгаа нь 1 миллилитрт байх никотины хэмжээний дээд хязгаарыг бид шингэн тамхинд оногдуулж өгсөн, 20 миллиграммаас

ихгүй байна гээд Европын холбооны стандартыг оруулж өгсөн. Тэгж байж бид энэ чинь дүйцүүлэлтээ хийж нөгөө хортой, манай гаалийнхны яриад байгаа 5 хувийн, 3 хувийн процентных буюу бүр илүү нөгөө янжуур тамхинаасаа илүү ноцтой өндөр тунгийн никотинтой бүтээгдэхүүн ороод ирээд байна, энийгээ хязгаарлая гээд, энэний хязгаарлалт энэ стандарт дээр байсан, 1 миллилитрт 20 миллиграмм-аас ихгүй никотин гээд, энэ маань хасагдчихсан байна. Яагаад хасчхав, энийгээ уг нь оруулаад явсан бол илүү дөхөм байх байжээ гэдэг ийм асуултуудыг асууя.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч хариулъя. Чинбүрэн гишүүний микрофоныг нээе.

Ж.Чинбүрэн: 8 дугаар санал дээр 5.1.2 дахь заалтыг хассан. Энэ Сайнзориг гишүүн гаргасан санал байгаа. Энэ дээр санал хураагаад олонхоор дэмжсэн. Ер нь хуулийг боловсруулах явцад аль ашиг сонирхлын зөрчилтэй болгоныг энд оруулна гэхээсээ илүүтэй үйл ажиллагаа явуулдаг, энд үйлдвэрлэл эрхэлдэг улсуудыг оруулах нь зүйтэй гэсэн ийм саналаар санал хураасан юм. Зүгээр бид яах вэ зүгээр энэ олон улсынхаа юун дээрээ конвенцтой ч гэсэн ийм тусгасан зүйл байгаа бол энийг дэмжээд буцаагаад яачихад нэг их тийм маргаантай зүйл байхгүй. Бид энэ дээр хууль боловсруулах явц гэдэг дээр л Сайнзориг гишүүн ингэж гаргаж байсан юм шүү.

15 дахь санал дээр энэ үгүй ээ би ч гэсэн энэ мөнгийг нөгөө эрүүл мэндэд зарцуулах чиглэлд хүсээд байгаа юм л даа. Тэгээд энэ төсвийн хуулиараа манай Сангийн яамныхан энэ дээр чухал зүйл хэлээд байгаа юм. Энэ Төсвийн тухай хуулийн 6.4.6-д хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн орлогыг аль нэг этгээд эсхүл үйл ажиллагаанд тусгайлан оноохгүй байх зарчимд нийцэхгүй байна гээд хэлчихсэн юм. Жишээлбэл энэ заалт дээр энэ орлогыг хүн амын эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд тогтвортой санхүүжүүлэх гээд заачихсан. Одоо хэрэгжиж байгаа хуулиараа тамхины татварыг нөгөө Эрүүл мэндийг дэмжих санд орно гээд угаасаа байж байгаа, Эрүүл мэндийг дэмжих сан гээд байж байгаа юм. Тэгэхээр энэ дээр энэ төсвийн заалтыг зөрчөөд байна гэсэн ийм санал хэлсэн учраас бид хассан шүү.

18 дахь санал дээр энэ зурагт анхааруулгыг техникийн зохицуулалтаар шийдэх зохицуулалт гээд тамхин бүтээгдэхүүний хэлбэр дүрсээс хамаарч гадаргуугийн 70 хувийг тооцоход их бэрхшээлтэй гэсэн ийм зүйлийг манай СХЗГ-оос тайлбар хэлсэн. Их олон төрлийн хэлбэртэй байдаг, тэдгээр болгон дээр нь ингэж оруулахаар ерөөсөө энэ СХЗГ-ын техникийн юугаар нь оруулчихъя, техникийн зохицуулалтаар нь нийцсэн байлгая гэдэг ийм заалт оруулъя гээд ийм санал.../минут дуусав/

П.Ганзориг: Нэмэлтээр хариулъя.

Ж.Чинбүрэн: Дараачийнх нь энэ 19 дүгээр санал дээр жишээлбэл Монгол Улсын стандартаар янжуур тамхи буюу утаа гаргадаг бидний хэвийн татдаг тамхин дотор 1.3-аас илүү 1 миллиграмм-аас никотин агуулахгүй гээд заачихсан байгаа. Яг тэрэн шигээ тэгвэл бүгд дээр нь заах байсан учраас нэг бол бүгдийг нь заая, нэг бол хэдүүлээ энийг аваад хаячихъя яагаад гэвэл дүйцүүлж байгаа учраас. Нэг янжуур тамхитай дүйцэх, нэг хайрцаг тамхитай дүйцнэ гэдэг утгаар нь бид энэ никотины хэмжээг авчихсан юм шүү.

Дээрээс нь энэ дээр нэг та бүхэн анзаараарай, бид нэг чухал заалт оруулж өгсөн нь энэ хэмжээг нь хязгаарлаж өгсөн. Одоо бол бүр 30 миллилитр хүртэл ийм том хэмжээтэй байгааг бид энийг бүр бууруулаад 10 миллилитр хэтрэхгүй байлгана, хэмжээг нь ингэж оруулж өгснөөрөө савлагааг аль болох жижигхэн болгохгүй бол ерөөсөө сороод хөхөөд байнга зуугаастай явж байх ийм эрсдэл байсан учраас энэ дээр бид ийм хязгаарлалт шинээр оруулж өгсөн.

П.Ганзориг: Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Тэгэхээр энэ 18 дугаар зарчмын зөрүүтэй санал дээр одоо ч гэсэн 50 хувь дээр нь анхааруулга наагаад л явдаг юм шүү дээ. Гадаргууг тооцох чинь ерөөсөө тийм хэцүү биш. Стандартаараа хийгээд л явчихдаг, энэ электрон тамхи чинь ч гэсэн хайрцагтай орж ирж байгаа, нэг их элдэв өөр төрлийн юм байхгүй шүү дээ. Бид чинь гаднаас нь харагдахдаа өөр юмтай андуурагдахаар юм хумыг нь бүгдийг нь хорьчихож байгаа тийм үү? Хүүхдийн тоглоом шиг юу шиг. Тэгэхээр гадаргуу дээр нь энийг тооцох тийм хэцүү биш шүү дээ. Яагаад тийм юм харьцаж байгаа юм бэ, тэгээд бид зурагтай хортой гэдгийг нь анхааруулж хүүхдүүд ч гэсэн, залуучууд ч гэсэн, татаж байгаа хүн ч гэсэн энийгээ харж байж л ер нь цаашдаа зан үйлийн хувьд, сэтгэхүйн хувьд энэ чинь хортой юм байна гэдэг байна энийгээ энэ зарчмын зөрүүтэй санал хураалт дээр анхаараасай гэж бодож байна.

2 дахь асуудал энэ никотины хэмжээ байна. Үнэхээр та бүхэн маань тэгж бодож байгаа бол энэ стандарт дээрээ оруулъя гэж байгаа бол энийгээ заавал хуулиараа үүрэг болгоё тэгэх үү? Дагаж гарч байгаа УИХ-ын тогтоол байгаа. Энэ тогтоол дээр СХЗГ энэ стандартыг батлахдаа никотины хэмжээг 20 миллиграммаас ихгүй байх гэсэн энэ стандартыг нь заавал оруулж өгөхгүй бол тэнд очоод юу болохыг үнэндээ мэдэхгүй байна. Тэгээд яах вэ энэ савлагааны стандартыг бид чинь нэг удаагийн хэрэглээ 2 миллилитроос ихгүй, дахин цэнэглэгч 10 миллилитроос ихгүй гээд угаасаа хууль санаачлагчийн зүгээс оруулчихсан байсан, энэний 2 миллилитрийг нь аваад ерөнхийдөө 10 миллилитроор байа гэсэн юмыг нь ажлын хэсгээс оруулж ирж байгаа юм байна. Тэгээд ингээд манай мэдээж гишүүдийн маань санал тусаад олонхоороо шийдээд явж байгаа учраас хүндэтгэж үзэж байна.

Гэхдээ энэ миллиграмм никотины хэмжээ ихгүй байх энэ стандартыг яг тодорхой заагаад, УИХ-ын дагаж гарч байгаа тогтоол дээрээ оруулах хэрэгтэй гээд заавал би энэ протоколд тэмдэглүүлмээр байгаа учраас ингэж хэлж байгаа юм. Тэгээд энэ эрүүл мэнддээ бид, авсан татвараа эрүүл мэнддээ энэнээс өвчилсөн тэр хавдар, урьдчилан сэргийлэх зөндөө л юунууд байгаа шүү дээ ядаж л энэ чинь судалгаа, эрэгтэйчүүдийн маань хавдар үүнээс ихсэж байгаа тэр хавдар дээр, урьдчилсан оношилгоо дээр мөнгө төгрөг хүрэлцдэггүй гээд эрүүл мэндийнхэн маань өчнөөн зовлон хэлдэг.

П.Ганзориг: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууя.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр 5.3.2 дугаар зүйлийг бүх шатны сургуулийн орчинд тамхи худалдах, хэрэглэхийг хориглох, зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэх, хамтран ажиллах гэсэн энэ зүйл заалтыг ажлын хэсэг яагаад хассан бэ гэхээр зэрэг тамхины онцгой зөвшөөрлийг ХХААЯ өгнө гэсэн. ХХААЯ-ны олгосон энэ онцгой зөвшөөрлийг худалдаалах цэгийн зөвшөөрлийг

Нийслэлийн газраас олгоно гэсэн. Ингэсэн худалдаалсан юмыг, жишээлбэл хүүхдэд худалдаалсныг хэн хянах юм бэ гэсэн чинь багш нар гэж хэлээд энэ дээр чинь бөөн маргаан үүсээд, юун өөрийнхөө үндсэн ажил асуудлаа дийлэхгүй ачааллаа дийлэхгүй байгаа багш нар дахиад хүүхдүүдийн тамхидалтыг хянана гэж юу байдаг юм бэ гэсэн асуудлаас энэ зүйлийг бүхэлд нь одоо байхгүй болгосон. Энэ мэт зүйлээс авхуулаад би энэ хуулийг түүхий байна гэж дүгнээд байгаа юм.

Энэ дээр жишээлбэл нэг асуудал байгаа 5.7.4 дээр тамхи худалдаалах зөвшөөрөл олгох цэгийн тоо, байршлыг тогтоохдоо ингээд ийм хязгаарлалтыг хангах, тамхи худалдаалах зөвшөөрлийн цэгүүдтэй үйл ажиллагаанд хяналт тавих гэсэн байгаа мөртөө энэ хяналтыг хэн тавих юм, энэ хяналт тавьж байгаа хүнийг этгээдийг хаанаас дахин шинээр хөндлөнгийн хяналт тавих юм бэ гэдэг юмнуудаа ерөөсөө тодорхой заагаагүй байгаа. Дээрээс нь хар даа, 5.8.2 дээр насанд хүрээгүй хүүхдийг хамгаална гээд байгаа мөртөө насанд хүрээгүй иргэнд тамхи татахыг санал болгох болон тамхи олж авах хүрээгүй иргэнд гэж байгаа шүү дээ хүүхдэд авах, хэрэглэхэд дэмжлэг үзүүлэхгүй байх. Энэ өөрөө хуулийн зүйл заалт нь хүүхдийг тамхи татахгүй байх арга механизм, хяналт, хамгаалалтыг бүрэн тусгаагүй мөртөө ийм сул орж ирж байгаа байхгүй юу. Ердөө ийм зүйлээр бид яаж хүүхдийг үнэр, амттай болон үнэр, амтгүй бусад тамхи, тамхин бүтээгдэхүүнийг хэрэглэхээс хамгаалж урьдчилан сэргийлж чадахгүй байгаа.

Өөрөөр хэлбэл хяналтын механизмыг хатуу чангаар тавьж өгөөгүй, хяналтын систем, нас мөшгөх систем, тэгээд дээрээс нь нөгөө борлуулалтын цэгийг шалгах, зарж худалдаалсан хүнд авах арга хэмжээг торгуулийн болон зөвшөөрлийн зүйлтэй нь ерөөсөө холбож өгсөн ийм зүйл заалтууд байхгүй байгаад байгаа учраас энийг ингэж хэлээд байгаа байхгүй юу. Жишээлбэл яг энэ дээр хар даа, энэ нөгөө хүүхдүүдийг хүүхдийн төлөө энэ тамхины онцгой хяналтын татварын юуг ийшээ чиглүүлнэ гээд ингээд байгаа. Гэтэл Санхүүгийн зохицуулах хороо чинь өөрөө хэлсэн юм шүү дээ. Энэ онцгой татвараас бүрдэж байгаа мөнгийг аль нэгэн чиглэлд тэрэнд зарцуулна гэж тодорхойлохгүй байгаа гэсэн энэ асуудал чинь өөрөө энэ тамхины онцгой хяналтын татвараас орж ирж байгаа мөнгийг хаашаа зохицуулахыг бид шийдэж чадахгүй юмыг тэнд хэлээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ Санхүүгийн зохицуулах хороо энэ дээр асуултыг.../минут дуусав/

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч хариулъя. Чинбүрэн гишүүний микрофоныг нээе.

Ж.Чинбүрэн: Түрүүн Номинчимэг гишүүний хэлсэн зүйл дээр тодруулаад хэлчихье. Тэр никотины хэмжээ тавиагүйн бас нэг шалтгаан дээд хязгаар байгаа. Жишээлбэл нэг янжуур тамхи дотроо 1.3 ч биш, 0.6, 0.5, 0.3 энэ тэр гэж байгаа байхгүй юу. Тийм учраас энэ дээр никотины хэмжээ заах нь өөрөө зохимжгүй байгаад байгаа юм. Дээрээс нь бид энэ цэнэглэх төхөөрөмжүүдийг бүгдийг нь хориглочихсон, нэг ёсондоо задгай системийг энэ электрон тамхиндаа хориглосноороо каннабис болон бусад зүйл нэмэхийг хориглож өгч байгаа.

Хяналтын талаар иргэн, хуулийн этгээдэд үүрэг гэж орсон байгаа. Мөн сургуулийн орчинд энэ сургуулийн орчныг хариуцаж байгаа тухайн байгууллага нь энэ тухайн орчинд тамхи таталтыг дэмжихгүй байх үйл ажиллагаагаа хариуцна гэж орсон. Мэдээж энэ дээр тэрийг хариуцахаар мэдээж багшид үүрэг өгч л таарна. Нийгмийн ажилтнуудын хариуцлага болж л таарна. Сайн дурын ажилтнууд, эцэг

эхчүүдийн оролцоо нэмэгдэж л таарна, сургуулийн сурагчид бие биеэ хүртэл хянах асуудал энд их орох юм гэж харж байгаа.

П.Ганзориг: Санал хураалт, санал хураалтаа явуулъя гишүүдээ. Эхлээд та нөгөө ажлын хэсгийн санал. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3.1.1 дэх заалтыг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.1.“тамхин бүтээгдэхүүн”/цаашид “тамхи” гэх/ гэж тамхины навч, ургамлыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түүхий эд болгон үйлдвэрлэсэн, никотин, бохь, эсхүл химийн бусад бодис агуулсан татах төхөөрөмж ашиглаж, эсхүл ашиглахгүйгээр хэрэглэх зориулалттай, эмийн бүртгэлд бүртгэгдсэн тамхинаас гаргах эмээс бусад дараах бүтээгдэхүүнийг:

3.1.1.а.тамхины түүхий эд, задгай тамхи, татаж хэрэглэх зориулалттай навчин, сигар, дүнсэн, янжуур тамхи болон тэдгээртэй адилтгах бусад тамхи;

3.1.1.б.цахилгаан халаагч болон бусад төхөөрөмжөөр шатаахгүйгээр сорж татах зориулалттай халаадаг тамхи;

3.1.1.в.никотин, амт, үнэр оруулагч болон химийн бусад бодис агуулсан, эсхүл агуулаагүй шингэнийг цахилгаан хэрэгслээр ууршуулан татах, эсхүл түүнтэй адилтгах аргаар хэрэглэх зориулалттай электрон тамхи;

3.1.1.г.усан хоолойгоор татах зориулалттай тамхи;

3.1.1.д.үнэрлэх, сорох, зажлах, аманд уусгах, биед наах болон татахаас бусад аргаар хэрэглэх зориулалттай, никотин агуулсан, эсхүл агуулаагүй тамхин бүтээгдэхүүн.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдээс ирсэн зарчмын зөрүүтэй саналуудыг цуг танилцуулчхаад дараа нь санал хураалт явуулах юм байна. Энхнасан гишүүнээс томьёололтой холбоотой санал ирсэн, уншиж танилцуулъя. 3.1.1 дээр “тамхин болон никотин агуулсан бүтээгдэхүүн гэж тамхины навч, тамхинаас гарган авсан никотин, нийлэг никотин, эсхүл никотин агуулсан бусад бодисыг ашиглан хүний биед никотин хүргэх эсвэл тамхи хэрэглэхгүй адил зориулалтаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг. 3.1.1.а.“утаат тамхи” гэж үйлдвэрлэлийн болон гар аргаар ороож бэлтгэсэн, татах зориулалттай янжуур, навчин тамхи, дүнсэн болон адилтгах задгай тамхийг; 3.1.1.б.“халаадаг тамхи” гэж цахилгаан халаагч болон бусад арга хэрэгслээр асаахгүйгээр сорж татах зориулалттай бүх төрлийн халаадаг тамхи; 3.1.1.в.электрон никотин дамжуулах систем гэж никотин, никотин давс, амт, үнэр оруулагч болон бусад химийн бодис агуулсан эсхүл агуулаагүй шингэнийг цахилгаан хэрэгслээр ууршуулан татах эсхүл түүнтэй адилтгах аргаар хэрэглэх зориулалттай электрон никотин дамжуулах системийг;” гээд энийг ингээд 4 бүлэгт хувааж тодорхойлж байгаа юм байна. Энэ хуулийн төсөл дээр 5-аар тодорхой ингээд заачихсан байж байгаа. Дараагийн санал. Тэгэхээр Нарантуяа-Нара гишүүний гаргасан яг адилхан, яг адилхан агуулгатай гарсан юм байна. Тэгэхээр Нарантуяа-Нара гишүүн гаргасан зарчмын зөрүүтэй саналаараа тайлбар хийнэ.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр ингэсэн юм, энэ тамхин бүтээгдэхүүн гээд бүхэлд нь яг нэг аваад үзчихээр зэрэг учир дутагдалтай асуудал байгаа. Энэ дээр яагаад утаат тамхи, халаадаг тамхи, электрон никотин дамжуулах систем гэж тус тусад нь ангилъя гэсэн ийм санааг гаргасан бэ гэхээр энэ тамхинаас гарч байгаа хорын утааны хор уршиг чинь харилцан адилгүй байгаа учраас утаат тамхи гэж тусад нь нэрлээд, янжуур тамхинаас гарч байгаа хор утаа чинь өөрөө эргэн тойронд байгаа, амьсгалж байгаа нэг агаараар амьсгалж байгаа хүмүүсийн эрүүл мэндэд шууд болон дам ийм хор хохирлыг учруулж байгаа учраас ингэж тусад нь ингэж утаат тамхи болон халаадаг тамхи гэж ангилъя гэсэн энэ санааг гаргаж байгаа юм. Халаадаг тамхи энэ юунаас чинь гарч байгаа утаанууд чинь эргэн тойронд нь байгаа хүмүүст шууд хор нөлөөний судалгаа батлагдаагүй байгаа шүү дээ. Тэгэхээр зэрэг энэ энэ дээр нь бид ингэж ялгамжтай байдлаар нэр томъёоллыг нь хийхгүй бол эндээс цаашаа томъёоллоос үүдэлтэй асуудлыг нь хор уршгийн асуудал үүсээд, татварын асуудлыг энэ дээр хэмжих гэж байгаа учраас ийм саналыг оруулж өгсөн байгаа шүү.

П.Ганзориг: Ажлын хэсгээс яах юм үг хэлэх юм уу? Ажлын хэсгээс тайлбар хэлье.

Ж.Чинбүрэн: Энэ нэр томъёо дээр ДЭМБ, ЭМЯ, Стандарт хамтран ажилласан. Энэ гол нь дэлхийн гаалийн байгууллагын ангиллын зарчимд тулгуурласан шүү, түүнээс бид илүү ялгаж ангилах биш, илүү гаалийн ангиллын зарчимд тулгуурлаж, олон улсын конвенцод утга юу нь ангилал нь зөрөхгүй байхаар тусгаж өгсөн л ийм учиртай юм байгаа юм.

П.Ганзориг: Гишүүд санал хураалтад бэлтгэе. Ажлын хэсгийн түрүүний танилцуулсан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос 9 гишүүн дэмжиж, ажлын хэсгийн санал 52.9 хувиар дэмжигдлээ. Ажлын хэсгийн гаргасан санал дэмжигдсэн учраас УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.20-д заасны дагуу Нарантуяа-Нара гишүүн болон Энхнасан гишүүний гаргасан саналууд дэмжигдээгүйд тооцогдоод явна, танилцуулагдаад явна.

7.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 3.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.11.“тамхи татах зөвшөөрөгдсөн цэг” гэж энэ хуулийн 3.1.1.а-д заасан бүтээгдэхүүн хэрэглэх цэг болон энэ хуулийн 3.1.1.б болон 3.1.1.в-д заасан бүтээгдэхүүнийг хэрэглэх цэгээс бүрдэх бөгөөд эдгээрийг тусад нь, эсхүл хооронд нь тусгаарлан зохион байгуулсан, тамхи хэрэглэх зориулалтаар тусгайлан бэлтгэсэн талбай, агааржуулалтын тоног төхөөрөмжөөр тоноглогсон өрөөг.” Санал гаргасан ажлын хэсэг. Ажлын хэсгийн гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн оролцсоноос 8 гишүүн дэмжиж, санал 47.1 хувиар дэмжигдсэнгүй.

8.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.1.2 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, энэ дээр гишүүдийн санал бий юу? Ажлын хэсгээс гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн оролцсоноос 1 гишүүн дэмжиж, санал 5.9 хувиар уналаа.

9.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.2.Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

5.2.1.тамхины хэрэглээ болон түүнээс шалтгаалах өвчлөл, нас баралтыг бууруулах чиглэлээр үндэсний бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг хангах;

5.2.2.тамхины хяналтын бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн болон орон нутгийн байгууллага, эрүүл мэндийн байгууллага, бусад холбогдох байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

5.2.3.тамхин бүтээгдэхүүний хэрэглээ, тархалт, эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, өвчлөл, нас баралтын талаарх мэдээлэл, статистикийг цуглуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх, тайлагнах;

5.2.4.тамхины хамаарлаас гарах зөвлөгөө, эмчилгээ, сэтгэлзүйн дэмжлэг, никотин орлуулах эмчилгээ болон бусад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандартыг батлах, хэрэгжилтийг зохион байгуулах;

5.2.5.тамхины хамаарлаас гарах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

5.2.6.тамхины хэрэглээ болон тамхины хяналтын талаар хүн амд чиглэсэн сургалт, сурталчилгаа, эрүүл мэндийн боловсролын үйл ажиллагааг зохион байгуулах.” Ажлын хэсгээс гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн оролцсоноос 9 гишүүн дэмжиж, санал 52.9 хувиар дэмжигдлээ.

10.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.3.1 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ тайлбар хийх үү нэмэлт? Ажлын хэсгийн ахлагч.

Ж.Чинбүрэн: Тийм энэ нөгөө түрүүн хариулдаг Боловсролын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9-д бүх түвшний албан боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах агуулгыг зөвхөн энэ хуулиар зохицуулна гэхчхэн юм. Тэгэхээр бид дахиж хууль яахгүй. Түрүүн манай Боловсролын яамнаас хэлсэн. Энэ сэдэв нь өөрөө Боловсролын ерөнхий хуульдаа байгаа. Тийм учраас давтагдаж байгаа гэж ойлгоорой.

П.Ганзориг: Ажлын хэсгийн гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн оролцсоноос 9 гишүүн дэмжиж, санал 52.9 хувиар дэмжигдлээ.

11.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.3.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.3.2.бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын орчин дахь тамхины хяналтыг боловсролын салбарын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээд хэрэгжүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос 10 гишүүн дэмжиж, санал 58.8 хувиар дэмжигдлээ. 13.

12.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.3.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.3.3.мэргэжлийн байгууллагын судалгаанд үндэслэн бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын орчин дахь тамхидалтыг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авах;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 17 гишүүн орсноос 10 гишүүн дэмжиж, санал 58.8 хувиар дэмжигдлээ.

13.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.3.4 дэх заалтын “бүх шатны боловсролын” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлд заасан боловсролын байгууллага болон бүх түвшний боловсролын сургалтын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн оролцсоноос 10 гишүүн дэмжиж, санал 58.8 хувиар дэмжигдлээ.

14.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.4.3 дахь заалтын “үр дүнтэй” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, санал 52.9 хувиар дэмжигдлээ.

15.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.5.1 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Ажлын хэсгээс нэмэлт мэдээлэл өгчих товч.

Ж.Чинбүрэн: Мэдээж хууль санаачлагч энэ эрүүл мэндийн салбарт, тэр дотроо нийгмийн эрүүл мэндийн чиглэлд зарцуулъя гэсэн байсан. Энэ нөгөө Төсвийн тухай хуулийн зураагийн, 4.6-д хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн орлогыг аль нэг этгээд эсхүл үйл ажиллагаанд тусгайлан оноохгүй байх гэдгийг зөрчөөд байгаа юм. Одоо энэ тамхины онцгой татвар бол дэмжих сан руу орж байгаа. Тийм учраас энэ нь зөрчигдөхгүй гэдэг ийм тайлбар Сангийн яамнаас хууль нийцлээ бодооч гэсэн ийм ажлын хэсэгт санал өгсөн шүү.

П.Ганзориг: Төсвийн тухай хуультай уялдуулж ажлын хэсгээс гаргасан санал юм байна. Тэгэхээр ажлын хэсгээс гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 17 гишүүн оролцсоноос 4 гишүүн дэмжиж, санал 23.4 хувиар уналаа.

16.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.6 дахь хэсгийн “хүнс, хөдөө аж ахуйн” гэснийг “хүнсний” гэж, мөн заалтын 5.5.3, 5.6.2 дахь заалтын “заасныг хэрэгжүүлэх” гэснийг “заасан зарчмыг баримтлах” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос 11 гишүүн дэмжиж, санал 64.7 хувиар дэмжигдлээ.

17.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 5.8.4 дэх заалтын “барилга байгууламжид” гэсний дараа “тус бүр” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

18 дахь санал дээр ажлын хэсэг болон гишүүдээс зарчмын зөрүүтэй гаргах саналыг нэгтгэж танилцуулна. 18.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 6.4.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.4.1.зурагт анхааруулга нь тамхи, тамхин бүтээгдэхүүний техникийн зохицуулалтад нийцсэн байх.” Санал гаргасан ажлын хэсэг гэсэн байна. Гишүүдийн зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя. Батын Батбаатар гишүүнээс гаргасан саналын томъёолол. 6.1.4 дээр “тамхин бүтээгдэхүүний хэрэглэгчийн савлагаа, хайрцгийн нүүрэн талын доод хэсгийн үндсэн гадаргуугийн дор хаяж 70 хувийг, мөн ар талын доод хэсгийн үндсэн гадаргуугийн дор хаяж 70 хувийг эзэлсэн, тамхин бүтээгдэхүүн хэрэглэхээс үүдэлтэй өвчлөлийн үр дагаврыг дүрсэлсэн зураг болон эрүүл мэндийн анхааруулга бүхий бичвэр байршуулсан байх ёстой. Тамхин бүтээгдэхүүний савлагаан дээрх анхааруулгын бичвэр дүрслэлийг байршуулах шаардлагыг холбогдох техникийн зохицуулалтаар тодорхойлно.” гэсэн агуулгатай зарчмын зөрүүтэй санал байна, танилцууллаа. Дахиад бий юу? Ингээд ажлын хэсгийн гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос 7 гишүүн дэмжиж, 41.2 хувиар санал уналаа.

Батбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Түрүүн та бүхэнд уншаад танилцуулсан. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос 2 гишүүн дэмжиж, санал 11.8 хувиар уналаа. Дэмжигдсэнгүй. Тэгэхээр хууль санаачлагчийн гаргасан саналын томъёоллоор зохицуулалт нь явна гэсэн үг.

19.Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалтын 6.7.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.7.2.энэ хуулийн 3.1.1.а-д заасан янжуур тамхи болон түүнтэй адилтгах бусад тамхи, 3.1.1.б-д заасан тамхийг нэг хайрцагт 20 ширхгээс цөөн тоогоор, эсхүл дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг 200 граммаас багаар савлах, энэ хуулийн 3.1.1.в-д заасан электрон тамхины шингэний хэмжээг 10 миллилитрээс ихээр савлах, тамхины шингэнийг дахин цэнэглэх боломжтой байх.” гэж ажлын хэсгээс гаргасан санал байж байна. Эхлээд танилцуулчихъя. Дараа нь тайлбаруудаа хийе.

Лундаагийн Энхнасан гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя. “6.7.2.Энэ хуулийн 3.1.1.а, 3.1.1.б-д заасан тамхийг нэг хайрцагт 20 ширхгээс цөөн тоогоор, эсхүл дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг 200 граммаас багаар савлах, энэ хуулийн 3.1.1.в-д заасан электрон никотин дамжуулах системийн шингэний хэмжээг 10 миллилитрээс ихээр савлах, шингэн дэх никотины агууламж 30 миллилитрээс их байх” гэсэн ийм зарчмын зөрүүтэй саналын томъёолол байна. Ингээд ажлын хэсгээс тайлбар хийе.

Ж.Чинбүрэн: Байнгын хорооны гишүүдээ би түрүүн хэлснээ давтаад хэлчихье. Бид энэ дээр нэг дэвшилттэй зүйл хийгээд байгаа нь Монгол Улсад нэг янжуур тамхинд байх никотины хэмжээний дээд хэмжээг хязгаарыг тогтоочихсон байхгүй юу. Тэгэхээр бид энэ дээр тийм ээ нөгөө 2 миллилитр электрон тамхи чинь 20 ширхэг тамхитай дүйцэж байна шүү дээ. Тэрэн дотор байгаа никотин чинь тэртээ

тэргүй дээд хязгаар нь байгаа учраас никотиныг нь зааж өгөөд хэрэггүй, бага байж болно шүү дээ.

2 дахь дараагийн нэг гол үндэслэл 10 миллилитрээс их байх нь байнга сороод явна л гэсэн үг шүү дээ. Бид нөгөө хэмжээг нь багасгаж өгөөд байгаа байхгүй юу. Нэг удаа вэйпийг дотор нь агуулагдаж байгаа хэмжээ чинь одоо бүр 30 миллилитрээр байна, тэр чинь 13 мянган удаа сорох тийм боломж олгоод байгаа юм. Тэгээд ингээд сороод л байх юм бол никотины нөгөө дадал чинь улам нэмэгдэнэ. Никотины хэрэгцээ улам ихсээд байгаа байхгүй юу. Тийм учраас бид аль болохоор ингэж бага болгож, илүү сайжруулсан юм шүү. Тийм учраас ажлын хэсгийн саналыг дэмжиж өгөөрэй гэж хүсье.

П.Ганзориг: Ажлын хэсгийн гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос 11 гишүүн дэмжиж, санал 64.7 хувиар дэмжигдлээ. Энхнасан гишүүний санал санал хураагдахгүй, тэгээд цаашаа танилцуулагдаад явна гэсэн үг. Дэмжигдээгүй. 20.Төслийн 7 дугаар зүйлийн 2026 оны. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан санал хураалтууд явагдаж дууссан.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. 4 дүгээр зүйлтэй холбоотой санал хураалт явуулж дууссан.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгээс санал байхгүй. Энхнасан гишүүнээс зарчмын зөрүүтэй санал ирсэн юм байна. Энхнасан гишүүн 5 дугаар зүйлийн заалтыг бүхэлд нь хасах саналтай гэсэн байна. Ажлын хэсгээс энэ дээр тайлбар өгье. Ажлын хэсгийн ахлагч Чинбүрэн гишүүн тайлбарлая.

Ж.Чинбүрэн: Энэ ажлын хэсгээс дэмжээгүй. Хэрвээ энийг хасчих юм бол утаат тамхи гээд дахиад буцаад ороод ирэх, ганцхан ангилал орж ирэх гээд ийм ноцтой байгаа. Тийм учраас бид энэ ажлын хэсгээс энийг дэмжихгүй гэсэн.

П.Ганзориг: Энхнасан гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос 1 гишүүн дэмжиж, 5.9 хувиар энэ санал дэмжигдсэнгүй. 5 дугаар зүйлийн санал хураалт явагдаж дууслаа.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн санал, гишүүдээс санал байгаа тийм ээ. Ажлын хэсгийн санал болон зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүдийн саналыг нэгтгэж танилцуулъя.

20.Төслийн 7 дугаар зүйлийн “2026 оны 01 дүгээр сарын 01-ний” гэснийг “2027 оны 01 дүгээр сарын 01-ний” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Батын Батбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал. Энэхүү хууль нь 2020 хэдэн оны гэж ... тавиад тэдэн сарын тэдний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ. Өөрөөр

хэлбэл хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг нь энэ дээр хоосон орхичихсон байна. Харин 6.4.1, 6.7.16 дахь заалт нь энэхүү хууль хүчин төгөлдөр болсноос хойш 24 сарын дараа хэрэгжинэ гэсэн ийм санал, зарчмын зөрүүтэй саналын томьёолол оруулж ирсэн байна. Ажлын хэсгээс ажлын хэсгийн ахлагч энэ дээр тайлбар өгье.

Ж.Чинбүрэн: Мэдээж бид энэ хуулийн гол үзэл санаа бол энэ хяналтыг илүү сайн болгох зорилготой учраас аль болох л хурдан хэрэгжвэл бид чухал гэж үзэж байгаа. Гэхдээ мэдээж нөгөө үйлдвэрлэгч, импортлогч ийм байгууллагуудад гэнэтхэн өнөөдөр та бүхэн тамхиа ийм болго гэвэл нэлээн учир дутагдалтай учраас бид зориуд 2027 оны 1 сарын 1 гэж хугацаа өгөөд байгаа. Тийм учраас бид энэ өөрсдийнхөө энэ хууль санаачлагчийн юу бол 2026 оны 1 сарын 1 буюу нөгөө хугацаа нэлээн явчихсан байсан, тийм ээ. Тэгэхээр одоо 2027 оны 1 сарын 1 болгож өөрчилсөн.

П.Ганзориг: Ажлын хэсгийн гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос, 9 гишүүн дэмжиж, санал 52.9 хувиар дэмжигдсэн. Ингээд Батын Батбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдээгүйд тооцогдоод танилцуулагдаад явна.

21.Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дараалал болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томьёог жигдлэх засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ дээр ажлын хэсэг тайлбар өгөх үү? Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос 11 гишүүн дэмжиж, санал 64.7 хувиар дэмжигдлээ.

22.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос 11 гишүүн дэмжиж, санал 64.7 хувиар дэмжигдлээ. 7 дугаар зүйлийн санал хураалт явагдаж дууслаа.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэж эхэлье.

Нэг.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн саналыг танилцуулъя. Ажлын хэсгийн санал. 1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн санал байгаа юм байна. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 17 гишүүн орсноос 11 гишүүн дэмжиж, санал 64.7 хувиар дэмжигдлээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн саналыг танилцуулъя. Ажлын хэсгээс мөн хуулийн Төслийг хууль санаачлагчид нь буцаах ажлын хэсэг гэсэн юм байна. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос 11 гишүүн дэмжиж, санал 64.7 хувиар дэмжигдлээ.

3.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Саранчулуун гишүүнээр тасаллаа. Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Нөгөө татварынхаа асуудал дээр дахиад ярья. Донтолтын асуудлыг тайлбарладаг ийм донтолт гэдэг чинь өөрөө зөвхөн никотиноос гадна донтуулгыг дэмждэг хэрэгслийн тухай ярихгүйгээр тэд нарыг нь энэ онцгой албан татварт ноогдуулахгүйгээр ингээд зөвхөн тамхин дээр нь татвар нэмчхээд, бусад тэр дэмжих хэрэгслийг нь татвар оногдуулахгүй байж ерөөсөө болохгүй шүү дээ. Үгүй ээ, харин тэгээд гаалийн татвар, онцгой албан татвар аль, аль нь л байх ёстой байхгүй юу, би харин хэлээд байгаа шүү дээ. Архинаас битгий уу гэххээд архины хундага, стаканыг нь гоёыг нь ингээд зараад байгаа шиг ийм байж болохгүй гээд байгаа байхгүй юу. Дагалдах хэрэгслийн татварыг өсгөх хэрэгтэй. Энэ дээр ийм харилцан адилгүй 2 өөр юм тавьчихаар чинь энэ чинь зан үйлийг бууруулаад, хэрэглээг нь бууруулж байгаа юм ерөөсөө биш. Би энэ дээр ганцаараа хэлж байгаа юм биш шүү, зөндөө судалгаа байгаа. Би энд хүмүүс рүү явуулсан шүү дээ, та нар битгий ингээд ийм дутуу сонин юм хий л дээ. Нүглийн нүдийг гурилаар хуурч байгаа юм шиг. Онцгой албан татварыг дагалдах хэрэгслээр заавал оруулж энэ дээр заавал нэмж оруулах хэрэгтэй. Энэ мэргэжлийн хүмүүс нь хэл л дээ. Энэ дээр чинь зан үйл, хүний донтолтын талаар ярьдаг хүн байхгүй юм уу энэ ажлын хэсэгт чинь.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Ж.Чинбүрэн: Саранчулуун гишүүнээ, би түрүүн хэлснээ дахиад л давтаад хэлчихье. Ер нь гадаргуу дээр нь бид сая баталлаа, 70 хувиас багагүйгээр энд сануулах, дээрээс нь янз бүрийн гоё өнгө будаг тавихгүй байх энэ тэр гээд орж байгаа учраас энэ маань дагалдах хэрэгсэл дээр никотин агуулаагүй учраас бид онцгой татвар авахгүй. Харин гаалийн татвар 30 хувь байгаа шүү. Татвар байхгүй гэж яривал буруу ойлгочихно. Тийм учраас татвар байгаа, энэ бол гаалийн татвар байгаа. Дараагийн юун дээр санал дээр байж байгаа.

П.Ганзориг: Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Дахиад хэлээдэхье, тамхи хортой гэж бичээд тэр бичгийг уншаад тамхинаас хүн гардаггүй л байхгүй юу. Тамхи хортой гэж бичсэн тэр дүрсийг чинь харснаа “авахаа больё” гэдэггүй шүү дээ. Тэгэхээр тэрүүгээр энийг хааж болохгүй байхгүй юу. Тэгэхээр ийм татварыг нь ийм харилцан адилгүй тогтооно гэдэг чинь та нар энэ хууль чинь тамхины хэрэглээг бууруулах эцсийн зорилго нь шүү дээ. Хэрвээ хэрэглээ гэдэг ойлголтыг ярьж байгаа бол хэрэглээнд автуулаад байгаа бусад хэсгүүдийг адилхан авч үзэх хэрэгтэй. Миний хэлээд байгаа санаа тэр байхгүй юу даа. Тэр бүрдүүлээд байгаа зүйл, гар утсаар жишээ аваад үзье. Яагаад iPhone, Samsung хамгийн их борлуулалттай байдаг вэ? Дагалдах хэрэгсэлтэй байдаг байхгүй юу даа, энэ чинь маркетинг. Тэгэхээр энэ цэнэглээд байгаа тэр дагалдах бүх зүйл, тэр кэйс нь өөрөө хэрэглээг өдөөдөг байхгүй юу. Энэ чинь судалгаатай, нотолгоотой, онолтой юм би яриад байгаа, мэдэхгүй байвал ингэж ярихгүй шүү дээ. Мэдэж байгаа юмаа л ярина шүү дээ. Тэгэхээр би энэ дээр, энэ дээр та ийм дутуу юм оруулж болохгүй л гэж хэлмээр байна. Тэгээд өөрсдөө энэ хариуцлагаа хүлээх юм байгаа биз. Тамхи хортой гэдэг бичгээр тэгээд хүмүүс больчихсон ийм жишээ байгаа юм уу?

П.Ганзориг: Энэ татвартай холбоотой асуудал дээр нэлээн саналууд гарсан. Тэгээд энэ дээр дэд ажлын хэсэг ахалж ажилласан Жаргалан гишүүн нэмэлт тайлбар өгье. Жаргалан гишүүний микрофоныг нээе.

Б.Жаргалан: Архины хэрэглээг бууруулахад татварын бодлого маш хүчтэй эдийн засгийн хөшүүрэг болно гэдэгтэй дэд ажлын хэсэг дээр хийгдсэн судалгаанууд түүнийг илтгэж байгаа. Тэгээд Саранчулуун гишүүний хөндсөн яг тухайлсан асуудал дээр асуудлыг ойлгож байгаа. Гэхдээ гаалийн татвар дээр нөгөө дагалдах хэрэгслүүд дээр татвар ноогдуулж байгаа 30 хувиараа, өөрөөр хэлбэл гаалийн ердийн татвар чинь 5 хувь байгаа шүү дээ. Тэгэхээр гаалийн татвар 30 хувиараа ноогдуулж байгаа, онцгой албан татварыг зөвхөн никотин агуулсан гэдэг агуулгаараа никотин агуулсан бүтээгдэхүүнүүд дээр ноогдуулж байгаа. Гэхдээ таны санаа зовоод байгаа нөгөө цэнэглэдэг, цэнэглэдэг юуг угаасаа бид оруулж ирэхгүй хасчхаж байгаа. Тэгэхээр нөгөө цэнэглэдэг тийм төхөөрөмж угаасаа орж ирэхгүй гэсэн үг. Тэгэхээр нөгөө нэг төхөөрөмжийнх нь тэгээд цэнэглэдэг төхөөрөмжийг нь оруулж ирэхгүй юм чинь таны санаа зовоод байгаа нөгөө аксессуарууд бараг байхгүй гэсэн үг болчхож байгаа байхгүй юу.

Түрүүний Чинбүрэн гишүүний хэлдэг нэг удаагийн төхөөрөмжүүд дээр болохоор анхааруулах, энэ тамхи эрүүл мэндэд хортой гэсэн тэр анхааруулах таних тэмдэг нь нийт гадаргуугийн 70 хувьд нь очиж байгаа байхгүй юу. Тэгэхээр яг нөгөө тэр донтолтыг үүсгээд байгаа таны санаа зовоод байгаа тэр асуудал одоо бараг гарахгүй гэсэн үг. Тэгээд онцгой албан татварыг яг зөвхөн никотин агуулж байгаа гэдэг агуулгаараа бүтээгдэхүүн дээр ноогдуулж байгаа.

П.Ганзориг: Ажлын хэсгийн саналыг танилцуулъя. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Онцгой албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 8, 9 дэх заалт:

8	Электрон тамхины шингэн	1 миллилитр
9	Аманд уусгах, зажлах зориулалттай тамхи	1 грамм

2/6.1².энэ хуулийн 4.1.2-т заасан барааны тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна: Ингээд хүснэгтэлсэн мэдээлэл байна, та бүхэнд уншиж танилцуулъя. Дэс дугаар гээд мөрний мэдээллийг уншъя. Онцгой албан татвар ноогдуулах барааны нэр төрөл, биет нэгж, ногдуулах онцгой албан татварын хэмжээ төгрөгөөр, 2026 он, 2027 он, 2028 он, 2029 он, 2030 он, 2031 он гээд 6 жилээр ялгаатай тогтоосон, өсөхөөр.

1.Татаж хэрэглэх зориулалттай навчин, сигар, янжуур тамхи, тэдгээртэй адилтгах бусад тамхи, тоо ширхэг 20, 2026 оноос 836 төгрөг одоо мөрдөж байгаа гэсэн үг. Тэгээд энийг дараа жилээс 2000, би энийг он оноор нь. 2027 онд 2000 төгрөг, 2028 онд 3500 төгрөг, тэгээд 5000 төгрөг, 6000 төгрөг, 8000 төгрөг болгоод 31 он хүртэл өсгөөд явахаар;

2 дахь мөр. Халаадаг тамхи 20 ширхэг, 836 төгрөг, 1500 төгрөг, 2625 төгрөг, 3750 төгрөг, 4875 төгрөг, 6000 төгрөг.

3 дахь мөр. Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи, усан хоолойгоор татах зориулалттай тамхи, 200 грамм, 626 төгрөг, 1500 төгрөг, 2625 төгрөг, 3750 төгрөг, 4875 төгрөг, 6000 төгрөг.

4 дэх мөр. Электрон тамхины шингэн, нэр төрөл, хэмжих нэгж 1 миллилитр, 2026 онд 0 төгрөг, 2027 оноос 750 төгрөг, 1312.5 төгрөг, 1875 төгрөг, 2437.5 төгрөг, 3000 төгрөг.

5 дахь мөр. Аманд уусгах, зажлах зориулалттай тамхи, 1 грамм, 2026 онд 0 төгрөг, 2027 оноос 125 төгрөг, 220 төгрөг, 315 төгрөг, 410 төгрөг, 450 төгрөг гээд ингээд ажлын хэсгийн гаргасан санал байна.

Гишүүдээс ирсэн зарчмын зөрүүтэй саналуудыг хамтатгаж танилцуулъя. 2 гишүүн байгаа, хоёулаа яг адилхан томьёололтой учраас би Нарантуяа-Нара гишүүн болон Лутаагийн Энхнасан гишүүн байгаа тийм ээ. Гаргасан саналыг танилцуулъя. Саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

1/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг. Дэд дугаар. Онцгой албан татвар ноогдуулах барааны нэр төрөл, онцгой албан татвар ноогдуулах биет нэгж. 1-д, би мөрийн дагуу уншиж танилцуулъя. Бүх төрлийн тамхины шингэн, 10 миллилитр. 2, 2 дахь мөр. татаж хэрэглэх зориулалттай навчин, шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи 100 ширхэг. 3.халаадаг тамхин бүтээгдэхүүн 100 ширхэг. 4.ууталсан никотин. Энэ бол 1 килограмм. Ийм хэмжих нэгжтэй мэдээлэл байна.

2 дугаар хэсгийн 6.1.Энэ хуулийн 4.1.2-т заасан барааны тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ноогдуулна. Хүснэгтэлсэн мэдээлэл энэ Онцгой албан татварын тухай хуульд энэ хуулийн төсөлтэй яг адилхан форматтай дэс дугаар, онцгой албан татвар ноогдуулах барааны нэр төрөл, биет нэгж, ноогдуулах онцгой албан татварын хэмжээ төгрөгөөр гээд. Ингээд одоо мөрдөж байгаа болон 2026 он, 2027 он, 2028 он, 2029 он, 2030 он гэсэн он нь бол ялгаатай юм байна шүү. Ийм ялгаатай мэдээлэлтэй, хуулийн төсөл дээр 2031 он хүртэл явж байгаа. Ингээд өсөн нэмэгдэх байдлаар тогтоосон. 1.Татаж хэрэглэх зориулалттай навчин, шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи, биет нэгж нь 100 ширхэг, одоо бол 4180 төгрөгөөр ингээд 2026 оноос эхлээд 6270 төгрөг, 6897 төгрөг, 7587 төгрөг, 8345 төгрөг, 9180 төгрөг гээд онцгой албан татвар нь өсөн нэмэгдээд явахаар он оноороо.

2-т халаадаг тамхин бүтээгдэхүүнийг тусад нь оруулах саналтай байна. Халаадаг тамхин бүтээгдэхүүн 100 ширхэг, хэмжих нэгж, онцгой албан татвар ноогдуулж байгаа нь 0 төгрөг, 2026 оноос эхлээд 3135 төгрөг, 3449 төгрөг, 3793 төгрөг, 4173 төгрөг, 4590 төгрөг болоод 2030 он хүртэл өсөөд явахаар.

3-т дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи, хэмжих нэгж 200 грамм, одоо байгаа татварын хэмжээ, онцгой албан татварын хэмжээ 626 төгрөг, 2026 оноос 939 төгрөг, 1033 төгрөг, 1136 төгрөг, 1250 төгрөг, 1375 төгрөг.

4.бүх төрлийн тамхины шингэн, хэмжих нэгж 10 миллилитр, 0 төгрөг одоо байгаа нь. 2026 оноос эхлээд 3136 төгрөг, 3449 төгрөг, 3793 төгрөг, 4173 төгрөг, 4590 төгрөг.

5.электрон тамхи төхөөрөмжийн хамт, хэмжих нэгж 10 миллилитр, одоо байгаа 0 төгрөг, 2026 оноос 3135 төгрөг, 3449 төгрөг, 3793 төгрөг, 4173 төгрөг, 4590 төгрөг.

Ууталсан никотинд болохоор онцгой албан татвар ноогдуулах саналтай байна гээд ууталсан никотин, хэмжих нэгж 1 килограмм, 2026 оноос эхлээд 20900 төгрөг, 29275 төгрөг, 35125 төгрөг, 42150 төгрөг, ингээд 2030 он гэхэд 46365 төгрөг байхаар ийм онцгой албан татварын шаталсан өсөн нэмэгдэх байдлаар тогтоож байгаа. Ингээд зарчмын зөрүүтэй санал гаргасан Нарантуяа-Нара гишүүн саналаа тайлбарлая.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр энэ ингэдэг юм байна лээ олон улсын жишигт утаат янжуур тамхийг, энэ IQOS гээд байгаа энэ тамхийг, вэйп тамхийг хор хөнөөлийн чанараар нь 3 жишиглээд, 3 ялгамжтай байдлаар татварыг оногдуулдаг ийм олон улсын жишиг байгаад байгаа юм. Тэгэхээр бид ялгамжтай тогтёе гэдэг энэ зарчмын байр суурь дээр нэгдсэн мөртөө яг энэ 3 хор хөнөөлийн чанараар нь 3 түвшинд ангилсан татварын бодлогын асуудлыг нэгдэж чадаагүй. Харин янжуур тамхи дээр нэг өөр. Нөгөө дараагийн 2 IQOS болон вэйп тамхи дээр яг ижил татвар ноогдуулсан байгаа нь энэ өөрөө Төсвийн байнгын хорооноос өгсөн ялгамжтай татварын бодлого гэсэн зүйлтэйгээ нийцэхгүй байгаа учраас ийм саналыг оруулсан байгаа.

П.Ганзориг: Ажлын хэсгийн гишүүн Жаргалан гишүүн тайлбар хийе.

Б.Жаргалан: Хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн татварын хувь хэмжээг янжуур тамхин дээр дараах байдлаар тогтоосон байдаг. Хууль үйлчилж эхлэх эхний жилд янжуур тамхины онцгой албан татварыг 20 ширхэг тутам 2 мянган төгрөгөөр, тэгээд жил болгон 2 мянган төгрөгөөр онцгой албан татварыг нэмэгдүүлээд, 5 дахь жилдээ болохоор нэг хайрцаг тамхины онцгой албан татвар 10 мянга байхаар. Тэгээд үүн дээр болохоор дэд ажлын хэсэг тодорхой тооцоо судалгаанууд хийж үзээд, ямар дүгнэлтэд хүрсэн бэ гэхээр ер нь өсөлт огцом байна гэдэг дээр гишүүдийн гаргаж байгаа Төсвийн байнгын хорооны гишүүдийн гаргасан саналтай санал нийлсэн.

Гэхдээ эхний жилдээ 2 мянга болгож байгаа нь үндэслэлтэй байна гэсэн ийм дүгнэлтэд хүрсэн. Яагаад гэхээр хамгийн сүүлд 2017 онд энэ онцгой албан татварыг хайрцаг тамхин дээр 836 төгрөг гэж тогтоосон байдаг, тэр цаг хугацаанаас хойш онцгой албан татварын хэмжээ өөрчлөгдөөгүй. Тэгэхээр тэр үеийн 836 төгрөг гэдэг одоо инфляцынхаа нөлөөллийг тооцохоор бараг 1500 төгрөг орчим болж байгаа юм. Тэгэхээр бараг л 1500 орчим төгрөгтэй тэнцэхүйц татварыг 2 мянган төгрөг болгож байна гэсэн үндэслэлээр 2 мянга нь байх нь зөв юм гэсэн дүгнэлтэд хүрсэн. 5 жилийн дараа онцгой албан татварыг 10 мянган төгрөг хүргэх үндэслэл юу вэ гэхээр олон улсын хэмжээнд тамхидалттай тэмцэх зорилгоор тамхины жижиглэнгийн үнэд эзлэх татварын хувь хэмжээг 75 хувьд хүргэх ёстой гэсэн ийм үндэслэл, ийм зорилтуудыг мөрддөг юм байна лээ. Одоогоор дэлхийн 30 гаруй

улсад жижиглэнгийн үнэд эзлэх татварын хувь хэмжээ 75 хувьд хүрчихсэн байгаа. Манай улсын хувьд хайрцаг тамхи маш харьцангуй хямд байгаа, тэгээд жижиглэнгийн үнэд болохоор татварын хувь хэмжээ нь 34 хувийг эзэлж байгаа. Өөрөөр хэлбэл олон улсын түвшнээс маш доогуур.

Тэгэхээр дийлэнх улс орнуудад болохоор энэ жижиглэнгийн үнэд эзлэх татварын хувь хэмжээ 60 орчим хувь байгаад байгаа юм. Тэгэхээр бид энэ 60 орчим хувьд хүргэх зорилгоор энэ 5 жилийн дараах онцгой албан татварыг 8 мянган төгрөг гэж оруулж ирсэн буюу хууль санаачлагчийн оруулж ирсэн хувь хэмжээнээс 20 хувь бууруулсан. Нарантуяа-Нара гишүүний ярьсан энэ ялгамжтай татвар тогтоох бодлогыг ажлын хэсэг дээр ярилцаад, халаадаг тамхи болон вэйп дээр янжуур тамхинд ноогдуулж байгаа онцгой албан татварын 75 хувийг ноогдуулахаар ингэж тохироод, тэгээд энэ та нарын өмнө байгаа хүснэгтэд ялгамжтай татвар орж ирсэн байгаа шүү гэдгийг хэлье.

П.Ганзориг: Санал хураалт явуулъя. Ингээд ажлын хэсгийн гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос 11 гишүүн дэмжиж, санал 64.7 хувиар дэмжигдлээ. Ажлын хэсгээс гарсан саналын томьёолол дэмжигдсэн тул гишүүдээс гарсан 2 саналын томьёолол дэмжигдээгүйд тооцно.

2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн саналыг танилцуулъя.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “, халаадаг, шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи” гэснийг “болон янжуур тамхи, тэдгээртэй адилтгах бусад тамхи, халаадаг тамхи” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Мөн энэ заалт дээр зарчмын зөрүүтэй санал гаргасан 2 гишүүний саналыг танилцуулъя. Лундаагийн Энхнасан гишүүн, яг адилхан 2 санал уу. Нарантуяа-Нара гишүүн гишүүний санал байна.

2 дугаар зүйл дээр Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 2 дахь мөрийн “янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи” гэснийг “татаж хэрэглэх зориулалттай навчин, шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи” гэж, “20 ширхэг” гэснийг “100 ширхэг”, мөн хэсэг дэх хүснэгтийн 3 дахь заалтын “1кг” гэснийг “200гр” гэж тус тус өөрчилсүгэй гээд Нарантуяа-Нара болон Лундаагийн Энхнасан гишүүн нарын гаргасан саналын томьёолол адилхан. Ингээд зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүн тайлбар хийх үү? Түрүүнийхтэй адилхан юм байна. Ажлын хэсгийн санал байна уу? Ажлын хэсгийн гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос 11 гишүүн дэмжиж, санал 64.7 хувиар дэмжигдлээ. Ингээд зарчмын зөрүүтэй санал гаргасан 2 гишүүний санал дэмжигдээгүйд тооцно.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

4.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн санал байхгүй юу? Улсын тэмдэгтийн хураамж дээр байхгүй юу. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Тус хуулийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Ажлын хэсгийн санал байгаа юм байна. Ажлын хэсгийн саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийн 6.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтын “хоёр зуун” гэснийг “гурван зуун” гэж, мөн заалтын “хоёр зуун” гэснийг “гурван зуун” гэж тус тус өөрчлөх. Тийм байна. Би дахиад уншъя. Ажлын хэсгийн гаргасан санал. Төслийн 2 дугаар зүйлийн 6.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтын “хоёр зуун” гэснийг “гурван зуун” гэж, мөн заалтын “хоёр мянган” гэснийг “гурван мянган” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос 11 гишүүн дэмжиж, санал 64.7 хувиар дэмжигдлээ.

Тус хуулийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна. 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ингээд 5 дугаар зүйлээр асуулт асууж, санал хураалт явуулж дууслаа.

6 дугаар зүйл. Зургаа.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Номинчимэг гишүүн байна. Номинчимэг гишүүнээр тасаллаа. Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Энэ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль дээр бид нэгхэн л өөрчлөлт хийсэн. Тэр нь юу вэ гэхээр энэ янжуур тамхи байна уу, тамхин бүтээгдэхүүн гэж энэ хуулиар үзэгдэж байгаа шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүний зар сурталчилгааны асуудал байгаа. Манай ажлын хэсэг дээр манай Саранчулуун гишүүн бид яг энэ асуудал дээр ярьж байсан. Ингээд л зар сурталчилгаа гээд л дижитал орчинд энийг чинь бүгдийг нь маш хүчтэй маркетинг хийдэг. Зар сурталчилгаа хийгээд, далд байдлаар зар сурталчилгаа хийх кино янз бүрийн юманд оруулах гээд тэр уг нь журамтай юм байна лээ л дээ. Тэгээд хэрэгжүүлэх газар гэхээр ерөөсөө байхгүй.

Зөрчлийн тухай хуулиараа энийг нь шалган шийдвэрлэх энэ процесстоо оруулаагүй. Тэгэхээр яг энэ зар сурталчилгаа хуулиар хориглосон энэ бүтээгдэхүүнүүдийг зар сурталчилгаа, архийг чинь сурталчилгаа хийхээ больчихсон шүү дээ. Одоо энэ бүтээгдэхүүний зар сурталчилгаа хийгээд зөрчил гарах юм бол Шударга өрсөлдөөний газар яг харьяалан шийднэ гэсэн энэ асуудлыг нь оруулж өгсөн юм. Тэгэхээр энэ хуулийн дагуу санал байгаа. Тэгээд энийгээ аваад энэ үтэр түргэн хууль маань хэрэгжих үед хэрэгжих ёстой болохоор энэ асуудлыг манай хуулийн ажлын хэсэг анхаараасай гэж хүсэж байна.

П.Ганзориг: Ажлын хэсгээс гарсан саналын томъёоллыг танилцуулъя. Төслийг хууль санаачлагчид нь буцаах санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос 2 гишүүн дэмжиж, 11.8 хувиар тус санал дэмжигдсэнгүй, уналаа.

Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Тус хуулийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсэг саналгүй.

Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Гишүүн алга байна. Тэгээд ажлын хэсгээс санал байгаа юм байна. Ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя.

1.Төслийн 1 дэх заалтыг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтад доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:

1/24 дүгээр бүлгийн 24.04 дүгээр зүйл:

24.4.тамхи, энэ хүснэгтэлсэн мэдээлэл байгаа учраас баганаар нь би уншаад явъя. 24, 25.4.тамхи, дахин боловсруулсан тамхи, никотин агуулсан эсвэл тамхи, никотин орлуулагч агуулсан шатаахгүйгээр сорж татах зориулалттай бүтээгдэхүүн, хүний биед никотин өгөх зориулалттай никотин агуулсан бусад бүтээгдэхүүн, энэ дээрээ 30 гэсэн нэгж тавьсан юм байна.

2 дахь мөр шатаахгүйгээр сорж татах зориулалттай бүтээгдэхүүн дээр тэг, тамхи эсвэл дахин боловсруулсан тамхи агуулсан бүтээгдэхүүн дээр тэг.

2 дугаар хэсэг нь 85 дугаар бүлгийн 85.43 дугаар зүйл: 85.43. 1 дүгээр мөр: энэ бүлгийн бусад газар заагдаагүй ганцаарчилсан зориулалтын цахилгаан машин болон аппарат энэ дээр тэг, 85.43.40.10 олон удаагийн хэрэглээний электрон тамхи 30 хувь, 85.43.40.20 цахилгаанаар ажилладаг ууршуулж татах төхөөрөмж 30 хувь, энэ агуулгын хүрээнд эд анги, 85.43.90.10 электрон тамхи болон түүнтэй төстэй цахилгаанаар ажилладаг ууршуулан татах төхөөрөмжийн 30 хувь, 85.43.90.90 бусад гээд 30 хувь;

3 дугаар хэсэг 96 дугаар бүлгийн 96.14 дүгээр зүйл: 96.14. 96.14.0000 тамхины гаанс /гаансны толгой орно/, сигар, янжуур тамхины соруул, тэдгээрийн эд анги 30 хувь.

2 дугаар хэсэг Төслийн 2 дахь заалтыг хасах. Дараагийнх уу, энэ бол хамгийн сүүлийн санал нь бол уншихгүй юм байна.

Нарантуяа-Нара гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг уншиж танилцуулъя. 1.Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээг батлах тухай Монгол УИХ-ын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтад 24, 85, 96 дугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 24.4, 85.43, 96.14 дүгээр зүйл тус тус нэмсүгэй:

24.1. хүснэгтэн мэдээлэл, баганын дагуу уншиж танилцуулъя. 24.01.түүхий тамхи, тамхины хаягдал 30 хувь; 24.02.тамхи эсвэл тамхи орлуулагч агуулсан сигар, үзүүрийг нь тайрсан сигар болон нарийн ороосон сигар болон янжуур тэг хувь; 24.03.боловсруулсан бусад тамхи болон тамхи орлуулагч, нэгэн төрлийн болгосон буюу сэлбэгдсэн тамхи, тамхины ханд болон охь тэг хувь; тамхи, дахин боловсруулсан тамхи, никотин агуулсан эсвэл тамхи, никотин орлуулагч агуулсан, асаахгүйгээр сорж татах зориулалттай бүтээгдэхүүн, хүний биед никотин өгөх зориулалттай никотин агуулсан бусад бүтээгдэхүүн 5 хувь; энэ 24 дүгээр бүлгийн 24.4 гэсэн үг: 24.04.11.тамхи эсвэл дахин боловсруулсан тамхи агуулсан 5 хувь; 24.04.11.10.цахилгаан халаагч хэрэгслээр татах тамхи 5 хувь; 24.04.12.никотин агуулсан бусад гээд дотор нь нэг удаагийн электрон тамхи болон цэнэглэгч шингэн орж байгаа, энэ 5 хувь; 24.04.91.амаар хэрэглэх зориулалттай дээр 5 хувь.

Хассуурийн Ганхуяг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулъя. 85 дугаар хүснэгт дээр 85.43 дээр 85.43.40.00 дээр электрон тамхи гээд араас нь түүнтэй төстэй цахилгаанаар ажилладаг ууршуулах гэдэг хэсгийг хасах, татах хэрэгсэл гээд ингэж үлдээх юм байна. Мөн тамхины цахилгаан халаагч хэрэгсэл device-г өөрөөр хэлбэл хасах 30 хувьтай татвартай нь. Ийм хасах санал гаргасан юм байна. Бусад гэдэг дээр нь 30 хувь хэвээрээ, 85.43.90.00 дээр дагалдах хэрэгсэл, эд анги дээрээ 30 хувь хэвээрээ ийм зарчмын зөрүүтэй санал гаргасан байна. Ингээд ажлын хэсгээс нэмэлт тайлбар өгөх үү? Санал байхгүй бол ажлын хэсгийн гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос 11 гишүүн дэмжиж, санал 64.7 хувиар дэмжигдлээ. Ажлын хэсгийн гаргасан санал дэмжигдсэн тул зарчмын зөрүүтэй санал гаргасан 2 гишүүний санал дэмжигдээгүйд тооцно.

2.Төслийн 2 дахь заалтыг хасах. Саналын томьёоллоор санал хураалт гишүүдээ, ажлын хэсгээс гаргасан саналын томьёоллын 2 дугаар зүйл дээр төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн томьёоллоор санал хураалт. Тус хуулийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. 3 дугаар зүйл, санал хураалт явуулж дууслаа.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулъя. Ажлын хэсгээс гарсан.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.2026 оны ... дугаар сарын ...-ны өдрийн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд:

1.1.Тамхины хяналтын тухай хуулиар стандарт, хэм хэмжээний акт батлах эрх олгосон Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагууд, Стандартчиллын

төв байгууллага тус хуульд нийцүүлэн холбогдох дүрэм, журам, стандарт, загварыг Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө шинэчлэн баталж, мөрдүүлнэ.

1.2. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан тамхин бүтээгдэхүүн, түүний орц найрлагыг таних, шалгах зориулалттай лабораторийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

1.3. Тамхины хамаарлаас гаргах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах төлөвлөгөөг Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө боловсруулж, эмчилгээ үйлчилгээг хэвийн явуулах, хуулийн хэрэгжилтийг хангана.

1.4. Тамхи үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаарх Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан мэдээллийн нэгдсэн санг бий болгох, уг мэдээллийн санг холбогдох бусад мэдээллийн сантай мэдээлэл солилцдог байх чиглэлд төрийн байгууллагууд хамтран ажиллана.

1.5. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө мөн хуулиар тамхин бүтээгдэхүүнд тооцсон шинэ төрлийн тамхийг Тамхины хяналтын тухай хуулиар хориглосон байдлаар сурталчилсан зар сурталчилгааг хуульд нийцүүлэх арга хэмжээ авах, тамхи үйлдвэрлэх, импортлох, худалдаалахад зүй ёсны монопол болон давамгайл байдалтай аж ахуй эрхлэгч байгаа эсэхийг тогтооно.” Санал гаргасан ажлын хэсэг. Гишүүдийн санал байгаа билүү? Байхгүй. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос 11 гишүүн дэмжиж, санал 64.7 хувиар дэмжигдлээ.

2. Төслийн 2, 3 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Нэмэлтээр ажлын хэсгээс тайлбар хийх үү? Ажлын хэсгийн гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос 11 гишүүн дэмжиж, санал 64.7 хувиар дэмжигдлээ. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл тус бүрээр хэлэлцэж дууслаа. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Чинбүрэн гишүүн танилцуулна. Ингээд ажлын хэсэгт талархлаа илэрхийлье.

17.49 цаг

Гурав. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Монгол Улсын ЗГ 2026 оны 6 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, ЗГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2025

оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулъя. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, ЗГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх танилцуулгыг Боловсролын сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан танилцуулна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Танилцуулгаа эхэлчихье, Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 25 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, ЗГ-ын 25 оны санхүүгийн нэгдсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн, Монгол УИХ-ын 26 оны хаврын чуулганы 6 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан билээ. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 25 онд 30 их наяд 303.2 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 30 их наяд 331 тэрбум, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1 их наяд 27.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан.

Монгол Улсын төсвийн гүйцэтгэл, ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Боловсролын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын сан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн сайдын багцын нийт 373 байгууллагын 78 төсөл, сан, 325 төсөвт байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 10 их наяд 185.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, үүнээс урсгал зардалд 9 их наяд 617.1 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 573.2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 25 онд тус Байнгын хороонд харьяалагдах 4 төсвийн ерөнхийлөн захирагчийн 304 төсөл, арга хэмжээнд 573.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэл 74.8 хувийн биелэлттэй байна.

Байнгын хорооны дарга, УИХ-ын эрхэм гишүүд ээ, та бүхэн 25 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж, Төсвийн тухай хуулийн Монгол Улсын 25 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

П.Ганзориг: Үндэсний аудитын газраас хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна. Магнайсүрэн даргын танилцуулгыг эхлүүлье. Магнайсүрэн дарга индэр дээрээс танилцуулчих уу.

С.Магнайсүрэн: УИХ-ын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хууль болон Төсвийн тухай хуульд заасны дагуу тус Байнгын хороонд хамаарагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ. Тус Байнгын хороонд харьяалагдах 6 төсвийн ерөнхийлөн

захирагчийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын талаар тоймлон танилцуулъя.

1.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 164 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 121 байгууллагад дүгнэлт гаргаж, 43 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 87 байгууллагад өөрчлөлтгүй, 34 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт тус тус өгсөн байна. Аудитаар 143.2 тэрбум төгрөгийн 453 зөрчил илэрснээс 0.5 тэрбум төгрөгийн 62 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 123.2 тэрбум төгрөгийн 171 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 0.5 тэрбум төгрөгийн 5 зөрчилд 7 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 4 албан шаардлага, 19 тэрбум төгрөгийн 215 зөрчилд зөвлөмж өгсөн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 19.3 тэрбум төгрөгийн 4 зөрчил илэрснээс 0.3 тэрбум төгрөгийн нэг төлбөрийн акт, зөрчил арилгах нэг албан шаардлага, хариуцлага тооцох нэг албан шаардлага, 19 тэрбум төгрөгийн нэг зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилт дунджаар 94.6 хувийн биелэлттэй гарсан байна.

2.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд бөгөөд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 33 санхүүгийн тайланд нэгтгэснээс 7 санд дүгнэлт гаргаж, 7 санг түүвэрт хамрууллаа. Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 27 санхүүгийн сангийн санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт тус тус өгсөн байна. Аудитаар 169.1 тэрбум төгрөгийн 49 зөрчил илэрснээс 0.01 тэрбум төгрөгийн нэг зөрчилд төлбөрийн акт тогтоож, 158.7 тэрбум төгрөгийн 17 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 10.4 тэрбум төгрөгийн 34 зөрчилд зөвлөмж өгөөд байна. Өмнөх оны аудитаар илэрсэн тавьсан аудитын шийдлийн хэрэгжилт дунджаар 80.6 хувийн биелэлттэй гарсан байна.

3.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 497 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 152 байгууллагад дүгнэлт гаргаж, 345 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 122 байгууллагад өөрчлөлтгүй, 28 байгууллагад хязгаарлалттай, нэг байгууллагад сөрөг дүгнэлт өглөө. Аудитаар 165.9 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.5 тэрбум төгрөгийн зөрчилд 151 төлбөрийн акт тогтоож, 34.2 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 256 албан шаардлага хүргүүлж, 131.2 тэрбум төгрөгийн зөрчилд 334 зөвлөмж өгч, 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 2 албан шаардлага, хууль хяналтын байгууллагад 2 асуудлыг шилжүүлэхээр шийдвэрлэлээ. Өмнөх оны аудитын шийдвэрийн биелэлт дунджаар 67 хувьтай байна.

4.Эрүүл мэндийн сайд. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 450 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 385 байгууллагад дүгнэлт гаргаж, 63 байгууллагыг түүвэрт хамруулж, үйл ажиллагаа явуулаагүй, хууль, эрх зүйн зохицуулалт тодорхой бус зэргээс шалтгаалан 2 байгууллага аудитад хамрагдаагүй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 323 байгууллагад өөрчлөлтгүй, 59 байгууллагад хязгаарлалттай, 2 байгууллагад сөрөг

дүгнэлт өгч, нэг байгууллагад дүгнэлт өгөхөөс татгалзсан байна. Өмнөх оны аудитын шийдвэрийн хэрэгжилт дунджаар 91.7 хувьтай гарсан байна.

5.Эрүүл мэндийн сайд бөгөөд Эрүүл мэндийн даатгал /ЭМД/-ын үндэсний зөвлөлийн дарга. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт өглөө. Аудитаар 442.1 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс зөрчлийг таслан зогсоох 7 албан шаардлагыг хүргүүлж шийдвэрлэжээ. Өмнөх оны санхүүгийн тайлангаар илэрсэн аудитын шийдвэрийн хэрэгжилт дунджаар 87.5 хувьтай гарсан байна.

6.Боловсролын сайд. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 1865 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 1144 байгууллагад дүгнэлт гаргаж, 713 байгууллагыг түүвэрт хамруулж, шинээр байгуулагдсан, татан буугдсан зэргээс шалтгаалан 8 байгууллага аудитад хамрагдаагүй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 1060 байгууллагад өөрчлөлтгүй, 80 байгууллагад хязгаарлалттай, 3 байгууллагад сөрөг, нэг байгууллагад дүгнэлт өгөхөөс татгалзсан байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт дунджаар 87.5 хувьтай гарсан байна.

Дээр дурдсан аудитын дүн, дүгнэлтээс үндэслэн дараах асуудалд анхаарал хандуулах шаардлагатай гэж үзлээ. 1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн төслийн саналыг боловсруулахдаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцүүлж, тухайн жилд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, түүнд шаардлагатай төсвийг үнэн зөв тооцоолж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.Хөрөнгийн оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх бүртгэх, үр дүнг үнэлэх үе шат бүрд төсвийн ерөнхийлөн захирагч болон оролцогч байгууллага, албан тушаалтнуудын хяналт хариуцлагыг сайжруулах;

3.Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн байдлын тайлан дахь бусад эргэлтийн хөрөнгийн дансанд хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон буюу ашиглалтад орсон хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, ажлын гүйцэтгэл санхүүжилтийг үе шат бүрээр бүртгээгүй зэрэг зөрчил илэрч байгаад дүн шинжилгээ хийж эрх бүхий төрийн байгууллагуудад асуудлыг шийдвэрлүүлэх талаар үүрэг чиглэл өгч ажиллах;

4.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон дамжуулан зээлийн болон санхүүгийн дэмжлэгийн хугацаа хэтэрсэн 34.3 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах чиглэлээр нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлж, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, цаашид олон жилийн насжилттай авлага үүсэхээс урьдчилан сэргийлж, сангийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, зээлдэгчийн санхүүгийн чадавхыг үнэлж, хяналт тавьж ажиллах талаар холбогдох байгууллагад чиглэл өгч ажиллах;

5.Нийгмийн даатгалын сан, ЭМД-ын сангийн Чингис Хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байгаа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болон Капитал банкин дахь эрх хүлээн авагчаас авах нийт 376.6 тэрбум төгрөгийн авлагаас 132.3

тэрбум төгрөгийг барагдуулж, 244.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, 61.4 тэрбум төгрөгийн хөрөнгийн борлуулах үйл ажиллагаа удаашралтай байгаад анхаарал тавьж, авлагын барагдуулалтын талаар төлөвлөгөө гарган хэрэгжилтийг эрчимжүүлэх, хүлээн авсан хөрөнгийг худалдан борлуулах үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй байдлаар зохион байгуулан сангийн мөнгөн хөрөнгийг бүрдүүлэх арга хэмжээг авах;

6.Соёл, урлагийн байгууллагууд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөж төсвийг батлуулах, үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн хуваарилалт, зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулж, салбарын хууль тогтоомжтой нийцүүлэн холбогдох заавар, журмыг боловсруулж батлах, хуулийн хэрэгжилтийг хангуулахад анхаарч, хариуцлагын үр нөлөө бүхий тогтолцоог бүрдүүлэх;

7.Эрүүл мэндийн байгууллагуудын ЭМД-ын сангаас авах авлага өмнөх оноос буурсан ч ажилчидтай холбоотой татвар, НДШ-ийн болон бараа, үйлчилгээний өр төлбөр 43.5тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь эрүүл мэндийн байгууллагын удирдлагын тогтвортой байдал, төсөв санхүүгийн сахилга бат, тогтолцоог сайжруулах шаардлагатайг харуулж байна.

8.Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний нийт 450 төсвийн шууд захирагчийн тайланг төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд нэгтгэж байгааг төсвийн төвлөрүүлэн захирагчтай болох эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар судалж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх;

9.Боловсролын салбарын хэмжээнд дижитал сурах бичиг, боловсролын мэдээллийн систем, цахим үйлчилгээний системүүд өргөжин хөгжиж байгаа боловч мэдээллийн нэгдсэн сан, өгөгдлийн уялдаа холбоо, бүртгэл, тайлагналын зохицуулалт хангалтгүй байна;

10.Төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн аудитын шийдвэрийн хэрэгжилтэд анхаарч, аудитын шийдвэрийн болон хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг дүн шинжилгээ хийж, цаашид гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, төсөв санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх талаар холбогдох байгууллагуудад чиглэл өгч, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллах, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах шаардлагатай гэж үзлээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Ганзориг: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ажлынх хэсгийн гишүүдийн нэрс. Л.Энх-Амгалан Боловсролын сайд, Батшугар сайд байхгүй байна. Т.Ням-Очир Боловсролын яам /БЯ/-ны ТНБД, А.Даваажаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД, Б.Бат-Эрдэнэ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ТНБД, Үндэсний аудитын газраас З.Цэнджав Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч, Н.Цэвэлмаа Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Б.Баттуяа Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Д.Баярсайхан Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Ч.Цэвэгдорж Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор, А.Цогбаяр Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, В.Эрдэнэцогт Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, С.Нацагдорж Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Э.Эрдэнэцэцэг Санхүүгийн аудитын

газрын аудитын менежер, У.Оюунхүү Гүйцэтгэлийн аудитын газрын ахлах аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүд А.Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Р.Рэнцэнбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн,

Сангийн яамнаас М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, О.Хуягцогт Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, П.Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Н.Мөнгөнсүх Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлангийн бүртгэлийн хэлтсийн дарга, Ч.Цацрал Төрийн сангийн газрын Санхүүжилтийн тайлан, бүртгэлийн хэлтсийн ахлах шинжээч, Б.Цагаанцэцэг Төрийн сангийн Санхүүжилт, тайлан, бүртгэлийн хэлтсийн шинжээч, Б.Баяр-Эрдэнэ Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлангийн бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Э.Буянхишиг Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлангийн бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, М.Алтанхорол Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлангийн бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, А.Дэлгэрмаа Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлангийн бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн,

Боловсролын яамнаас А.Мөнх-Оргил Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Б.Бадамжав Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Т.Түмэнжаргал Хоол үйлдвэрлэлийн хэлтсийн дарга, Х.Тамир Боловсролын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч,

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төлөөллийг танилцуулъя. Ж.Энхтөр Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ц.Эрдэнэтөгс Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч, ерөнхий нягтлан бодогч, Б.Батжаргал НДЕГ-ын дарга, Б.Алтанцэцэг НДЕГ-ын Санхүү, бүртгэлийн газрын дарга, З.Бауыржан байхгүй, байсан уу, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Т.Бадрахбаяр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга, нэлээн олон хүн оролцож байгаа юм байна. Л.Бадамцэцэг Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газрын Хүүхэд, гэр бүл хамгааллын бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Б.Мягмарсүрэн Хүүхэд, хөгжил хамгааллын ерөнхий газрын Санхүү, төсөв хариуцсан ахлах мэргэжилтэн, Ц.Өлзийдүүрэн Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газрын Дотоод аудит, мониторингийн ахлах мэргэжилтэн, Д.Гэрэл Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга, О.Содномпэрэнлэй Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Ерөнхий нягтлан бодогч, С.Нямдорж Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газрын Бодлогын хэрэгжилтийн нийгмийн түншлэлийн газрын ахлах мэргэжилтэн, М.Амаржаргал Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төвийн дарга,

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Ц.Ариунсанаа Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Б.Урьболд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ч.Энх-Амгалан Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Д.Наранцэцэг Соёл, урлагийн бодлогын зохицуулалтын газрын дарга, В.Батчимэг Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга,

ЭМЯ-наас Ц.Батбаатар ЭМД-ын ерөнхий газрын дарга, Л.Мөнхцэцэг ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, С.Цогзолмаа ЭМЯ-ны ерөнхий нягтлан бодогч, Ч.Гантөмөр Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийн бүрэлдэхүүн байна. Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Саранчулуун гишүүнээр тасаллаа. Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу? Аудитын энэ дүгнэлттэй холбоотой нэг юм асуучихъя. Аудитын дүгнэлтийг хийхдээ шалгуур үзүүлэлт нь хангалтгүй байна, зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт хангалтгүй байгаа учраас дүгнэх боломжгүй байна гэдэг өгүүлбэр яваад байгаа байхгүй юу. Би өмнө нь чуулган дээр асуусан л даа. Нарийвчлан тодорхойлоогүй, үнэлэх үнэлгээ, шалгуур үзүүлэлтийг гаргадаггүйгээс шалтгаалан тухайн жилд авч хэрэгжүүлсэн төсвийн бодлогыг үнэлэх боломж хязгаарлагдмал байна гэж байгаа юм. Тэгээд үнэлэх боломж хязгаарлагдмал юм бол юу үнэлсэн юм бэ гэдгийг асууя? Ер нь энэ аудитын хүрээнд тэр хэлэлцэж байгаа, дүгнэж байгаа тэр шалгуур үзүүлэлтүүд нь аль хүрээнд явдаг юм бэ? Яагаад энийг асуугаад байгаа вэ гэхээр хүртээмжийн асуудлыг бид нөгөө улс орноороо ярих гэж байгаа, тэгээд энэ аудит дээр хүртээмжтэй байна, хүртээмжгүй байна гэдэг энэ асуудал нь ерөнхийдөө огт тусгагддаггүй юм шиг байгаа юм.

Нөгөө талдаа энэ аудитыг хийхдээ ер нь олон улсын гэрээ, конвенцыг аль хэсэгтээ авч хэрэглэдэг юм бэ, олон улсын гэрээ, конвенцод тусгасан ажлаа хийж байна, хийхгүй байна гэдэг тийм дүгнэлт ер нь ямар байгууллага гаргадаг юм тэрийг, тэр дээр нэг мэдээлэл авчихмаар байна?

2 дугаарт нь хүртээмжийн талаар би асууя л даа, маш олон яамдаас төлөөлөл ирсэн байгаа юм чинь ярилцъя. Танай яам энэ гүйцэтгэл дээр, энэ ажил дээр ер нь биет хүртээмжийн үнэлгээ хийлгээд, яг төлөвлөөд ийм, ийм засварыг хийнэ, сайжруулна гэсэн ийм ямар, ямар ажил тусгагдсан бэ? Дараа нь тэр нь төсөвтөө тусгагдаад явж байгаа зүйлүүд ер нь байна уу гэдэг асуудал?

Дараа нь хэдэн яам гаднаа хөгжлийн бэрхшээлтэй хүн орох хүртээмжтэй зогсоол бий болгосон бэ? Эсвэл харьяа байгууллага нь ч юм уу. Ямар яам, ямар байгууллага, орц, гарц, үүд, хаалга, вэбсайт тэр цахимаар явуулж байгаа мэдээлэл дээрээ хүртээмжийг нэмсэн бэ? Энэ жилийнх нь гүйцэтгэл, мэдээллүүдийг нэг тоймлоод надад хэлээд өгөөч. Бүх яамдын төлөөллүүдээс нь. Олон гишүүд байхгүй байгаа учраас би сайхан давуу тал гэж бодож байна. Тийм болохоор бүгдээрэнг нь сонсоод, бид аль хэмжээнд байгаагаа бас ярилцъя гэж бодож байна.

П.Ганзориг: Ажлын хэсгийн бүрэлдэхүүн дээр Сангийн яамны төлөөллүүдээс ирсэн, төлөөллүүдээс нэмж танилцуулъя. Хулан Сангийн дэд сайд, Б.Анар Сангийн яамны ТНБД оролцож байгаа юм байна шүү Сангийн яамнаас хариулах. Ингээд Үндэсний аудитын газраас эхэлж хариулчхаад, тэгээд яамнуудаас хариулах уу. Индрийн микрофон.

Д.Энхболд: Үндэсний аудитын газар, Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Энхболд. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газраас бодлогын хэрэгжилт, шалгуур үзүүлэлт тодорхойгүй байна, хэмжих боломжгүй байна гэдэг ийм дүгнэлтүүдийг хийж байна гэдэг дээр гүйцэтгэлийн аудитын хувьд

шалгуур үзүүлэлтээ бодлогын зорилтуудыг хангаж байгаа байдлыг урт, дунд болон богино хугацааны жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй тухайн төсөл, арга хэмжээнүүд хэрхэн уялдаж байгаа юм бэ, энийг хэмжих хэрэгжсэн гэдгийгээ ямар шалгуур үзүүлэлтээр хэмжиж байгаа юм бэ, гол KPI /Key Performance Indicator/ үзүүлэлтүүд нь тухайн салбарынхан тодорхойлж чадсан уу, энэ үзүүлэлтийнхээ хүрэх түвшинд хүрсэн үү гэдэг байдлаар хэмжиж үзэж байгаа. Энийг салбар тус бүрээр нь бид байхгүй байсан учраас энэ жилийн хувьд боловсрол, эрүүл мэнд, соёлын, иргэдийн үйлчилгээний төв гэх мэтээр гол үзүүлэлтүүдийг өөрсдөө аудитын явцад судалгааны байгууллагатай хамтран гаргаад үнэлгээг хийсэн.

Тэгээд цаашдаа энэ тухайн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлээр л үнэлээд байгаа, хэдэн барилга, хэдэн километр зам ашиглалтад орсон бэ гэдэг гүйцэтгэлээр үнэлж байгаа. Гэтэл эдгээр төсөл, арга хэмжээ маань тухайн жилийнхээ богино хугацааны хөгжлийн төлөвлөгөө, дунд хугацааны, урт хугацааныхаа бодлогын зорилтуудын хүрэх түвшний хэдэн хувийг дэмжиж байгаа юм бэ, ямар үйл ажиллагааг нь бууруулахад юм уу, эсвэл сайжруулахад ямар үр нөлөө үзүүлсэн бэ гэдгийг хэмжиж чадахгүй байгаа учраас энийг үзүүлэлтүүдийгээ тодорхой болгож өгөөч гэдэг ийм зорилтуудыг дүгнэлтүүдийг хийсэн байгаа.

2-т нь олон улсын гэрээ, конвенцыг шалгуур үзүүлэлт болгодог уу гэдэг дээр бид гүйцэтгэлийн аудит дээр салбарын үйл ажиллагаануудыг үздэг. Тухайлбал цөлжилтийн асуудал гэдэг юм уу, уул уурхайн салбарын асуудлууд дээр тухайн салбарт олон улсын ямар гэрээ, конвенцоор хүлээсэн үүргүүд байна вэ, энийгээ хэрэгжилтийг нь хянаж тайлагнадаг үйл ажиллагаа байгаа юу гэдэг дээр дүгнэлт гаргаж, гүйцэтгэлийн аудитын зарчим, стандартад нийцүүлээд шалгуур үзүүлэлт болгож энэ дээрээ дүгнэлтдээ оруулдаг байгаа.

П.Ганзориг: Индэр дээрээс очоод хариулаад явчихъя.

С.Магнайсүрэн: Нэмэлтээр бид аудитын газраас 2027 онд сэдвээр хийх бодлогоор буюу сэдвээр аудит хийх сэдвээ батлуулахаар Төсвийн байнгын хороонд өнөөдөр албан тоотой ирүүлсэн. Завсарлахаас өмнө хаврын чуулганаар бид батлуулж бэлтгэлээ хангах ёстой. Энэ хүрээнд бид энэ хүртээмжтэй холбоотой асуудлыг бодлогоор оруулсан. 1 дүгээрт иргэдээс хүсэлт ирсэн, 2 дугаарт зарим байгууллагаас ТББ-аас хүсэлт ирсэн байгаа. Ингээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилт, үр нөлөө сэдвээр бид 2027 оны 5 сарын 1-нээс 8 сарын 31-ний хооронд бодлогоор энэ сэдвээр аудит хийж, Байнгын хороонд танилцуулъя гэсэн ийм зүйл орсон байгаа. Энийг Байнгын хороон дээр юу яах үед нь гишүүд нь анхаараад дэмжээд өгвөл энэ хийгдчих ийм бололцоотой байгаа. Баярлалаа.

А.Энхбат: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Энхбат. Чуулган дээр та энэ асуудлыг асууж байсан. Өөрөөр хэлбэл манай дүгнэлтэд гарсан байгаа ЗГ-аас дараа жилийн төсвийн төслийг боловсруулан өргөн мэдүүлэхдээ тухайн жилд хэрэгжүүлэх төсвийн бодлого, зорилго, зорилтыг нарийвчлан тодорхойлж, үнэлэх үнэлгээ, шалгуур үзүүлэлтүүдийг гаргадгүйгээс шалтгаалаад тухайн жилд хэрэгжүүлсэн төсвийн бодлогыг үнэлэх боломж хязгаарлагдмал байна гээд. Тэгэхээр ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгад Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсөл нь улсын хөгжлийн

төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ гээд танилцуулчихсан байсан. Мөн төсвийн бодлогын хүрээнд төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулж, дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн мөчлөгийг сөрөөд, нийт эдийн засгийн идэвхжилийн мөчлөгийг тогтворжуулах бодлогыг баримтална гэж дурдсан байсан. Ер нь энэ хөгжлийн бодлого төлөвлөлт болон улсын төсвийн.../минут дуусав/

П.Ганзориг: Индэр дээрээс нэмэлтээр хариулъя.

А.Энхбат: Хоорондоо уялдаагүй байгаа нь өөрөөр хэлбэл түрүүн ярьж байсан Монгол Улсын 25 оны нэгдсэн төсөв нь улсын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ гэсэн хэдий ч энэ улсын хөгжлийн төлөвлөгөөнд туссан нийт төсөл, нийт 160 гаруй төсөл, арга хэмжээний 4.6 их наяд төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээс 74 төсөл, арга хэмжээ буюу 1.5 их наяд буюу 46.3 хувийн санхүүжилтийг төсвөөс, 25 оны төсвөөс хуульд тусгаж баталсан. 86 төсөл, арга хэмжээний 3.1 их наяд төгрөг буюу 53.7 хувийг тусгаагүй байна гэсэн ийм бидэнд дүгнэлт өгсөн байгаа. Ер нь цаашдаа энэ нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг үнэлэхдээ хөгжлийн бодлогын хэрэгжилттэй уялдуулж дүгнэх, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг, үр дүн тодорхойлох шаардлагатай байна гэсэн ийм дүгнэлт өгсөн байгаа. Баярлалаа.

П.Ганзориг: Саранчулуун гишүүн тодруулах уу? Яамнуудаас асуултад нь яам болгоноос төлөөлөөд индэр дээрээс 2 дахь асуулттай холбоотой хариулт өгье.

Т.Ням-Очир: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Боловсролын яамны ТНБД Ням-Очир. 2025-аас 2026 оны хичээлийн жилд сургуулийн өмнө боловсрол /СӨБ/-оос эхлээд насан туршийн суралцахуйн төв, дэмжих үйлчилгээ хүртэлх энэ боловсрол, сургалтын байгууллагуудад 0-оос 19 насны 10407 хүүхэд сурч төлөвшиж байна. Үүний 2175 нь СӨБ-д, 6735 нь мэргэжлийн болон техникийн боловсролд, дээд боловсролд 347, насан туршийн суралцахуйд 302, дэмжих үйлчилгээний төвөөр 125 гэсэн ийм тоо гарч байгаа. 2025 оны Боловсролын яам, харьяа байгууллагуудын хяналт-шалгалтын үр дүнгээр бид боловсролын салбарт мөрдөгдөж байгаа 50 гаруй стандартын дагуу сонгогдсон байгууллагуудад хяналт-шалгалт хийхэд энэ стандартын хэрэгжилт 60 гаруй хувьтай дунджаар гарч байгаа. Тухайлбал 885 ерөнхий.../минут дуусав/

П.Ганзориг: Индэр дээрээс нэмэлтээр хариулъя.

Т.Ням-Очир: 885 ерөнхий боловсролын сургууль /ЕБС/-ийн ариун цэврийн орчин, хүртээмжтэй байдал 72.5 хувь, орц, гарцын хүртээмжтэй байдал 65 хувьтай, 304 цэцэрлэг дээр хүүхдийн ялгаатай хэрэгцээг хангах орчин 46 хувьтай, 268 ЕБС дээр энэ хүртээмжтэй байдал 55 хувьтай, мөн их сургуулиудын хувьд 20 хувьтай гэсэн ийм тооцоо судалгаануудыг гаргаж, тэгээд энэ хүртээмжтэй байдлыг хангуулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллаж байгаа.

П.Ганзориг: Өөр яамдаас нэмэлтээр хариулах уу? Индрийн микрофон.

А.Даваажаргал: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Даваажаргал. Манай яамны хувьд 2025 оны салбарын бодлогын хэрэгжүүлэлттэй холбоотойгоор хүртээмжийг сайжруулах бодлогыг дэвшүүлж ажилласан. Энэ хүрээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар

96751 хүүхдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Энэ нь нийт хүүхдүүдийн 7.6 хувийг эзэлж байгаа учраас хүртээмжийн хувьд эндээ хангалтгүй тоо үзүүлэлтүүдийг гаргаж байгаа нь үнэн.

2 дугаарт, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалахтай холбоотой ажлуудыг яамдын салбарын хэмжээний барилга байгууламж, боловсрол, дэд бүтцийн хувьд яам 72 хувийн биелэлттэй хүртээмжийн асуудлуудыг шийдвэрлэсэн. Улсын хэмжээний барилга байгууламж, иргэний болон бусад зориулалттай барилга байгууламжийн хүртээмжийн асуудал дээр, хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан барилга байгууламжийн хүртээмжийн асуудал дээр яам онцгойлон анхаарч ажиллаж байгаа. Энэ дээр тэгэхдээ бид шууд.../минут дуусав/

П.Ганзориг: Нэмэлт минут өгье.

А.Даваажаргал: Нийгмийн халамжийн бодлогын хувь дээр хүртээмжийн асуудал нэлээн хоцрогдолтой явж байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа. Тэр дээр халамж яг зорилтот бүлгийн иргэддээ хүрч байгаа юу, үгүй юү гэдэг асуудал эргээд анхаарал татаж байгаа. Тэгээд энэ дээр Халамжийн хуулийн шинэчилсэн найруулгаар бид 1 дүгээрт зорилтот бүлгийн иргэдээ зөв тодорхойлох, 2 дугаарт зорилтот бүлгийн иргэд рүүгээ яг төр өөрөө халамж авч байгаа иргэд рүүгээ чиглэх үү, эсвэл халамж авч байгаа иргэдэд үйлчилж байгаа нийгмийн ажилтандаа чиглэх үү гэдэг энэ эрх зүйн зохицуулалтыг нь хийж өгөхөөр ажиллаж байгаа.

П.Ганзориг: Тодруулах уу Саранчулуун гишүүн. Соёлын яам.

Д.Наранцэцэг: Гишүүдэд оройн мэнд хүргэе. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам Наранцэцэг. Хөгжлийн бэрхшээлтэй, Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Ер нь дэд бүтэц, барилга байгууламж, орчны хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх чиглэлийг салбарын төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудад тогтмол өгч ажиллаж байгаа. 24-өөс 25 онд, ер нь 25 онд 5 Соёлын төв шинээр баригдсан. Сүүлийн соёлын байгууламж бүх холбогдох стандартын дагуу хүртээмжийн маш өндөр түвшинд баригдаж байгаа. 70 гаруй соёлын байгууллагаас дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хэрэгжүүлсэн. Энэний хүрээнд мэдээж гадна, дотор орчинд налуу зам хийх, хаалганы босгыг намсгах, хаалга, шатны нэмэлт бариул, зам тавих, брайл тэмдэглэгээ байршуулах, мөн хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчид зориулсан тусгай тэмдэглэгээтэй суудал төлөвлөх театрт гэх мэтчилнээр барилга байгууламжийн орчны хүртээмжийг.../минут дуусав/

П.Ганзориг: Гүйцээж хариулъя.

Д.Наранцэцэг: Нийтлэг ажлуудыг хийж байгаа. Мөн тэрнээс гадна бид энэ дэд бүтцээс гадна мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, мөн Чингис хаан үндэсний музей, Монголын үндэсний номын сан, Улсын хүүхэд, залуучуудын театр гэх мэт сүүлийн үеийн соёл, урлагийн барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй барилга байгууламжаар ашиглалтад орж үйлчилгээ үзүүлж байгаа. Цаашид ер нь шинээр ашиглалтад орох барилга байгууламжийн ажлыг зураг төсөл боловсруулах үе шатаас нь эхлээд MNS холбогдох стандартуудыг нийцүүлэх шаардлага тавьж, хяналт тавьж ажиллаж байгаа.

Мөн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр И-Монгол /E-Mongolia/-той хамтраад энэ сургалтыг бүх харьяа байгууллагуудын хэмжээнд хийж байна. Мөн энэ WCAG /Web Content Accessibility Guidelines/ зааварчилгааг нэвтрүүлэх ийм ажлуудыг хийж байгаа. Ном хэвлэл, уран бүтээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх.../минут дуусав/

П.Ганзориг: Гүйцээж хариулах уу?

Д.Наранцэцэг: Тэгье. Соёлын тухай хууль болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу холбогдох соёлын үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох ажлуудыг үе шаттай хэрэгжүүлж байгаа. Ер нь 2024 онд мөн энэ соёлын ажилтнуудад зориулсан сургалтуудыг зохион байгуулах, түүнчлэн сүүлийн үед ашиглалтад орсон музейнүүд энэ цахим технологийг ашиглаад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмж нэмэгдэх энэ чиглэлийн ажлууд түлхүү хийгдэж байгаа. Гэсэн хэдий ч мэдээж бидэнд төсөв хөрөнгөний асуудал тулгамдсан асуудлууд байгаа. Баярлалаа.

П.Ганзориг: Сангийн яамнаас Сангийн дэд сайд хариулъя.

Б.Хулан: Сангийн дэд сайд Хулан. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Хариулахаасаа өмнө нөгөө нийтлэг байдлаар 2025 онд гарсан тоон үзүүлэлтүүдийг харахад хүртээмж гэдгийг хүүхэд, ахмад, эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй гээд өргөн агуулгаар нь харж байгаа. Энэ утгаараа тэтгэмжид хамрагдсан 2 сая иргэн байна, 1.7 их наяд төгрөгийн зарцуулалт тэтгэмжид гарсан байна. Халамжтай болохоороо 468 мянган иргэн, 559 тэрбум төгрөгийн зарцуулалт энэ чиглэлээр гарсан байна. Үүн дотроо тодруулаад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн халамж дээр 123509 иргэн, 231.8 тэрбум төгрөгийн зарцуулалтыг хөдөлмөрийн чадвар алдсан, байнгын асаргаа шаардлагатай иргэн болон асрагч, хөнгөлөлт, тусламж байдлаар гарсан байна. Хөрөнгө оруулалттай холбоотой асуудлыг та хөндлөө. Тэгэхээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсролын сайд, мөн Гэр бүл, хөдөлмөр зэрэг дээр улсын төсөв болон гадаадын.../минут дуусав/

П.Ганзориг: Гүйцээж хариулъя.

Б.Хулан: Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр 2025 онд 21 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна. 2026 оны батлагдсан төсөв дээр 28.2 тэрбум төгрөг гэж ингэж батлагдсан. Хүртээмжийн асуудлыг төсөвлөлт төлөвлөгөө дээр яаж тусгах вэ гээд тэгэхээр ер нь хөрөнгө оруулалтын төслүүдийг шинээр төлөвлөхдөө хүртээмжтэй буюу хэрэгцээнд нийцсэн байх шалгуурыг аргачлалаар нь баталчихсан. Гэхдээ хэрэгжилт төдийлөн хангалттай байж чадахгүй байгаа нь барилгын норм, дүрмээ түүнийг дагуулан шинэчлэхдээ асуудлууд тодорхой хэмжээгээр жигдрээгүй байгаатай холбоотой гэж ингэж үзэж байгаа. Нөгөө талаасаа мөн гишүүний санаачилсан Саадгүй үйлчилгээний тухай хуулийн төсөлтэй холбоотойгоор 2027 оны төсвийн саналыг төсвийн ерөнхийлөн захирагч нараас авахдаа тусгай маягыг явуулж, төсвийн саналд тусгахаар ажиллаж байгаа. Баярлалаа.

П.Ганзориг: ЭМЯ-наас хариулах уу? Энэний дараа Бейсен гишүүний тавьсан нөгөө эрүүл мэндийн салбарын зардал, санхүүжилт, эмийн үнийн талаар асуулга явуулна. Батшугар сайд хаана байгаа вэ, байгаа юу? Нааш нь дуудаад энэ төсвийн гүйцэтгэл дээр ч гэсэн хариултуудаа өгөх ёстой, хариулаад явна шүү. Индрийн микрофон нээе.

Н.Эрдэнэбаяр: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. ЭМЯ-ны ТНБД Эрдэнэбаяр. Ер нь бид эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа барилга байшингууд, шинээр баригдаж байгаа барилга байшингууд болон их засваруудын ажлууд дээр заавал энэ стандарт дээр нь энийг байлгахыг ингэж тусгаж өгч байгаа. Жилд ер нь 3-аас 5 шинэ барилга ашиглалтад орж байна. Хуучин барилгуудын хувьд бид үйлчилгээний стандарт 7014:2023 гэсэн энэ стандартуудыг хэрэгжүүлэх чиглэл дээр 2023 оноос эхлээд ажиллаж байгаа. Нийт бүх эрүүл мэндийн байгууллага дээр анхан шатаас эхлээд лавлагаа тусламж хүртэл энэ бүх эрүүл мэндийн байгууллагууд дээр энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан энэ орчныг бий болгох, энэ аюулгүй орчныг бий болгох чиглэл дээр ингэж ажиллаж байгаа. Зүгээр яг бодит амьдрал дээр тэр налуу нь яг градустаа хүрэхгүй байх ч гэдэг юм уу ийм асуудлууд байгаад байгаа. Энэ нөгөө яг хуучин барилга дээр ингээд засварлаж шинэчлэлтүүд хийхээр бас ийм нэлээн тулгамдсан асуудлууд байдаг. Ер нь эрүүл мэндийн салбарын гол зорилго хэнийг ч орхигдуулахгүй байх гэсэн энэ үзэл баримтлал дээр явдаг. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд өнөөдөр бидний авч байгаа статистик мэдээгээр.../минут дуусав/

П.Ганзориг: Гүйцээж яриулъя.

Н.Эрдэнэбаяр: Нийт хүн амын 81 хувь нь хамрагдсан байна гэдэг ийм үзүүлэлт байгаа. Гэхдээ энэ 19 хувь дотор энэ тодорхой хувиуд ингээд дутуу байгаад байгаа. Тэгэхээр энэ дээрээ бид илүү сайжруулах чиглэл дээр бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Яг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд бидэнд энэ нэлээн салбар зөвлөл ажиллаж байгаа. Энэ хүрээндээ бид ярилцаж, ялангуяа энэ дээр бага насны энэ нярайгаас нь өгсүүлээд энэ эрт илрүүлгийн тогтолцоог нэлээн их анхаарч ажиллаж байгаа. Энэ дээр бид, жишээ нь, энэ статистик, тоон мэдээллүүдийг гаргаж, энэ бүх зүйлүүдээ ингэж явсан байгаа. Ургийн эрт илрүүлгийн асуудлууд, нярайн эрт илрүүлгүүд, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн эрт илрүүлэг, нярай, ЕБС-ийн суралцагчдын урьдчилан сэргийлэх 6 настны эрт илрүүлэг гээд, ингээд мөн ургийн хромосомын гажгийн эрт илрүүлэг гээд цогц илрүүлгүүд, 9, 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн эрт илрүүлэг гэсэн ийм байдлуудаар энэ эрт илрүүлгийн.../минут дуусав/

П.Ганзориг: Саранчулуун гишүүн тодруулах уу, болчихсон уу? Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Баярлалаа, зөндөө удаан хүлээгээд ажлуудаа танилцуулж бүгдээрээ яривал зүгээр шүү дээ гэж бодоод бүгдээс нь асуулаа. Тэгээд мэдээлэл өгсөнд баярлалаа. Яах вэ, хүртээмжийн талаар бид нөгөө харилцан өөр ойлголтууд байгаа учраас бид төсвийн захирагчид болон Сангийн яаманд зориулж зааварчилгаанууд бэлдэж байгаа. Тэгээд НҮБ-ын Хүн амын сангаас дэмжлэг авч байгаад төсөв төлөвлөхөд чинь тустай, дэмтэй ийм аргачлалууд бол яг энэ нь юм гэдгийг зааж өгөхөөр бэлдэж байгаа. Энэ дээр хэдүүлээ хамтарч ажиллая. Ер нь хэдүүлээ нэг Хүртээмжтэй Монгол гээд нэг юмыг яг бодитой ингээд хэрэгжүүлчихвэл

болох гээд байгаа байхгүй юу. Энд тэнд юм хийгээд байгаа, гэхдээ нөгөө нэгдсэн арга зүй хэмжигдэхгүй байгаа учраас одоо болохгүй байна. Тэгэхээр намар орж ирэхдээ бид ингээд зааварчилгаагаа гаргаад нэгдчих юм бол харахад аягүй ойлгомжтой болоод ингээд явах байх гэж бодож байна. Би энэ 3 яамны хамтарсан ажил дээр ганц нэг минутаа авчихъя, тэгэх үү даргаа.

П.Ганзориг: Нэмэлт нэг минут өгье.

О.Саранчулуун: Хүртээмжийг хэрэгжүүлэх болон ер нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад хамгийн эхний алхам ЗГ-ын хувьд байна шүү дээ хамгийн хийх эхний алхам хэнийг хөгжлийн бэрхшээлтэй гэж үзэх юм бэ, энэ нөгөө хөдөлмөрийн хувь юмыг нь тооцох асуудал байхгүй юу. Тэрэн дээр бид нөгөө 10 жил ярьсан нөгөө ICF-ээ хөдөлгөөнд оруулах хэрэгтэй байна. Энэ дээр саяхан 3 яам уулзаж ажилласан байсан, гэхдээ ICF-тэй холбоотой эсэхийг би мэдэхгүй. Тэгэхээр би юу санал болгох гээд байгаа вэ гэхээр ДЭМБ нэгэнт Монгол хувилбарыг нь орчуулаад нээлт хийхэд бэлэн бид нарыг хүлээж байгаа, тэрний дараа НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр комиссоо сургая гэж байгаа юм. Тэгэхээр саяын Эрүүл мэндийн ТНБД-ын ярьсан ажлуудыг илүү нөгөө 3 яам хамтарч байгаад ажил хэрэг болгохын тулд бүгдээрээ энэ дээр гялс уулзаад, энэ ажлыг явуулчих юм бол ЗГ-ын мөрийн хөтөлбөрийн тэр ICF-д яг нэвтрүүлнэ гэдэг чинь яг жинхэнээсээ яг болох боломжтой байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ямар шийдэл байна вэ гэдгийг нэг хариулаад өгөөч? Яг энэ 3 яамны хамтын ажиллагаа дээр.

П.Ганзориг: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? ЭМЯ-наас индэр дээрээс хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Саранчулуун гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Ер нь 3 яам уулзсан байж байгаа, дараагийн уулзалтыг ЭМЯ дээр зохион байгуулахаар ингэж төлөвлөсөн. Энэ уулзалт бид ер нь 7 сардаа гэж ингээд төлөвлөчихсөн явж байгаа. Тэгээд энэ үеэр таны саяын ярьж байгаа энэ ICF-ийн юунуудыг ярилцахаар байгаа. Тэгээд энэ дээр тантай жич мэдээллүүдээ солилцоод, тэгээд энийг аль болох бид бодит үйл ажиллагаа болгох чиглэл дээр ажиллана. Энэ дээр яам хооронд ойлголцлын хувьд маш ахицтай байгаа гэж хэлэх гэж байгаа юм.

П.Ганзориг: Сархадын Зулпхар гишүүн асуулт асууя.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд, эрхэм ЗГ-ын гишүүд болон яамдын албан хаагчдын өдрийн амгаланг айлтгая. 3 асуулт байна. 1 дүгээр асуулт Боловсролын сайд Энх-Амгалангаас асуулт байна. Боловсролын байгууллагын хүртээмжийг тэрнээс гадна чанарыг нэмэгдүүлэхтэй холбоотой хамгийн том зорилт шаардлагатай барилга байгууламжийг хугацаанд нь барьж ашиглалтад оруулах, хүлээлгэж өгөх, үүнийг ашиглах асуудал гэж бид ойлгож байгаа. Яг өнгөрсөн хугацаанд ажил нь эхэлчхээд дуусаагүй байгаа вэ хэчнээн сургууль, цэцэрлэгийн барилга байгууламж байна вэ гэсэн нэг ийм асуулт байна. Тэрнээс гадна ашиглалтад ороход бэлэн болчихоод ашиглалтад оруулж чадахгүй байгаа хэдий хэмжээний ийм барилга байгууламж байна вэ гэсэн ийм асуулт байгаа юм. Ер нь цаашдаа ийм нөхцөл байдлыг гаргуулахгүйн тулд бид ер нь яах ёстой вэ? Зарим газар 8 жил үргэлжилчихсэн барилга байгууламж нь ашиглалтад орох гэж 8 сар хүлээж байгаа ийм барилга ч байгаа. Ийм мэдээлэл бидэнд ирж байна л даа, энэ дээр та их тийм асуудалд ажил хэрэгчээр, их туршлагатай ханддаг хүний хувьд

их тодорхой чиглэл гаргасан гэж би сонссон учраас энэ дээр та байр сууриа илэрхийлээч, мэдээлэл өгөөч гэж байгаа юм?

2 дахь зүйлийг би Магнайсүрэн даргаас асууя гэж бодож байгаа юм. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудит хийгдлээ. Их сайн. Тэгээд энэ удаа Үндэсний баялгийн санд гүйцэтгэлийн аудит хийсэн байна. Бид Үндэсний баялгийн сантай болсон, тэр сангаа ямар байгааг сонсох үүрэг бидэнд бий. Тэгээд энэ хүрээнд 9894 хүнд ипотекийн зээл олгосон гэсэн ийм тоо байгаа юм. Их сайн тоо байна. Гэтэл үүнтэй зэрэгцээд ипотекийн зээлийг ер нь давхардуулаад олгочихдог гэсэн ийм мэдээлэл явсан. Энэ их тийм ноцтой л асуудал байгаа юм л даа. Яагаад гэвэл энэ чинь эрх тэгш байх ёстой бол энэ эрх тэгш байх ёстой. Энэ зарчим алдагдчихсан байгаа юм. Тэгэхээр ийм боломж бий юү, яг ингэж нөхцөл байдал тогтоогдсон уу? Хэрвээ ийм нөхцөл байдал тогтоогдсон бол энэ дээр ямар хяналт шалгалт, цаашлаад ямар хариуцлагын механизм үйлчлэх юм бэ гэсэн тодорхой асуулт байна?

Би НДЕГ-ын дарга Батжаргал даргаас асуулт байна. Нийгмийн даатгалын хуулийг 2023 онд шинэчлэн найруулсан найруулгыг нь баталсан. Энэ хууль баталсантай холбоотойгоор зохих түвшний үр дүнгүүд гарч байгаа гэж бид ойлгож байгаа, Нийгмийн даатгалын сан мэргэжлийн мэргэшсэн удирдлагатай болсон. Сангийн жишээ нь, чөлөөт үлдэгдлийг мөн захиран зарцуулахтай холбоотой шинэ менежмент буюу мэргэжлийн менежмент нэвтэрч байгаа гэж ойлгож байгаа юм л даа. Даргаа нэг минутаа нэмээд авчхаж болох уу.

П.Ганзориг: Нэмэлт минут өгье.

С.Зулпхар: Тэгэхээр мэдээж хэрэг аудит хийгдсэн, аудит хийгдэхээс гадна яг сангийн менежментийг, удирдлагыг бүрэн хариуцаж байгаа байгууллагын хувьд та бүхэн олон нийтийг зарим талаар зөв мэдээллээр хангах шаардлагатай гэсэн үүднээс нэг зүйлийг тодруулъя гэж байгаа юм. Сангийн чөлөөт мөнгөн үлдэгдлийг та бүхэн мэргэжлийн түвшинд удирдаад ямар үр дүн гарсан бэ? Өөрөөр хэлбэл, жишээ нь, арилжааны банканд байршуулах ийм эрхийг нь нээчихсэн шүү дээ хуулиар. Тэгээд үүний үр дүнд ер нь ямар хэмжээний орлого олов? Цаашдаа ер нь энийг мэргэшсэн энэ менежментийг нь илүү, жишээ нь, тогтвортой авч явах чиглэлээр та бүхэнд ямар туршлага бий болов гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

П.Ганзориг: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Ийм байна Зулпхар гишүүнээ, энэ манай салбарын хувьд нийт 303 төсөл, арга хэмжээнүүд ингээд үргэлжлээд шинэ нь 63 цэцэрлэг, сургууль, дотуур байр, спорт заал, шилжихээр 175 объект, хөрөнгөгүй гээд түр царцсан гэхэд хаашаа юм, гэхдээ ямар ч байсан ийм ойлгомжгүй нөхцөл байдалтай болчихсон 65 объект ингээд нийт 303 объект, тэгээд энэ 26 оны төсөвт өртгөөр 1.9 их наяд буюу 26 онд санхүүждэг нь 506 тэрбум төгрөгийн ийм хөрөнгө оруулалтууд байгаа юм, явж байгаа юм. Тэгэхээр өнгөрсөн хугацааны энэ хөрөнгө оруулалтын гүйцэтгэл дээр гарсан нэг том алдаа гарсан. Ямар алдаа гарсан гэхээр хуучин Боловсролын ерөнхий газар энэ хөрөнгө оруулалтын хэрэгжилт, хяналт, мониторингуудыг авч явдаг, бид хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд 98 хувь ч хүрч байсан он жилүүд байгаа.

Ингээд энэ бүх чиг үүргүүдийг яаман дээрээ татаж авчраад, тэгээд яаман дээрээ бүх тендерээ зарладаг, яаман дээрээ бүх хэрэгжилт, мониторингоо хийдэг нэг ийм бодлогын яамыг хэрэгжилтийн яам болгосон энэ алдаанаас болж энэ 25, 26 он дээр энэ хөрөнгө оруулалтууд нэлээн саарсан, үр дүн муутай болсон нэг ийм нөхцөл байдал үүссэн юм байна лээ. Энийг ингээд ажил аваад засаж залруулах ажлуудыг хийж байна. Одоо ямар ч байсан буцаад энэ тендер шалгаруулалттай холбоотой, тендерийн гүйцэтгэлтэй холбоотой энэ бүх чиг үүргүүдийг Боловсролын ерөнхий газар руугаа шилжүүлээд, одоо нэлээн үр дүнд хүрэх ийм юутай л ажиллаж байгаа.

Тэгээд хамгийн сүүлд настай болчихсон, ашиглалтад ороогүй объект гэвэл 15-аас 20 оны хооронд нийт 120 орчим объект байна Зулпхар гишүүнээ. Ингээд 20 оноос хойшоо 30 орчим ингээд объект байна. Ямар ч байсан бид удахгүй энэ нэг салбарын хар жагсаалтыг зарлая гэсэн ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Ер нь тендерт маш хямдхан үнээр ороод, ингээд жил бүхэн тендерийнхээ буюу энэ төсөвт өртгийг нь нэмээд байдаг нэг ийм төсвийн хулгай гэх юм уу, юу гэх юм нэг шалгарсан ийм технологи болчихсон нөхцөл байна шүү дээ, энэ дээр би энэ Барилгын хөгжлийн төв, тэр тусмаа энэ барилгын цэцэрлэг, сургуулиудын зураг хийж байгаа энэ зургийн компаниуд дээр бид ер нь нэг жаахан төрийн хяналтуудаа яахгүй бол, сайжруулахгүй бол ингээд Аудитын ерөнхий газраас сууж байх шиг байна. Энэ аудит дээр чинь жил бүхэн энэ төсвийн төсөв нэмэгдсэн юун дээр магадлан хийлгэж байгаа, тэгээд энэ тоо жилээс жилд ингээд өсөж байгаа нэг ийм нөхцөл байдлууд байгаа.

Аудитын ерөнхий газар энэ дээр нэлээн өөрийнхөө дүгнэлтүүдийг хүргэх болов уу гэж бодож байна. Ер нь яг ингээд нэг ийм зургийн цэцэрлэг, сургууль, дотуур байрнуудын зургаар мэргэшсэн, мэргэших мэргэшихдээ энэ төсвийн хөрөнгө оруулалтуудыг нь жил бүхэн нэмж байдаг нэг ийм тендерийн хонгил гэдэг юм уу, шударга бусын хонгил гэж хэлээд байдаг байх. Тэгээд ийм хонгил үүсчихсэн юм байна лээ Магнайсүрэн даргаа. Энэ дээр яг Сангийн яам, аудит, мэргэжлийн захиалагч байгууллага, тэгээд Барилгын яамтай хамтарч тодорхой тогтолцооны шинж чанарын арга хэмжээ авахгүй бол энэ ингээд яг нэг ийм ужгирсан, нэг ийм энүүгээр мэргэшсэн нэг ийм нөхдүүд байна. Энэ дээр би салбарын сайдын хувьд бусад салбаруудыг манлайлж ажиллаж, салбараасаа эхэлж 17 компанийн хар жагсаалтыг зарлахаар бид удахгүй ЗГ, Сангийн яаманд хүргүүлэхээр ажиллаж байгаа гэдэг мэдээллийг танд өгье.

П.Ганзориг: Үндэсний аудитын газраас Магнайсүрэн дарга хариулъя. Индрийн микрофоныг нээе.

С.Магнайсүрэн: Үндэсний аудитын газар Магнайсүрэн, Зулпхар гишүүний асуултад хариулъя. Саяын Энх-Амгалан сайдын асуудал дээр шууд үргэлжлээд тодотгоод хэлэхэд бид 23, 25 онд 2 удаа энэ юуг хийсэн нөгөө төсөвт өртгийн нэмэгдлийн аудитыг. Тэгэхээр энэ уг нь манай хийх ажил биш юм байгаа юм. Энэ ерөөсөө тухайн салбарын хөгжлийн төв нь хийгээд л, хариуцлагаа хүлээгээд ингээд явах ёстой асуудал дээр манай дээр ачаалал нэмээд бүх газар нэмэгдэж байгаа юм. Тэгээд энд ирээд Байнгын хороон дээр нэмэгдэж байгаа, яам дээр нэмэгдэнэ, Сангийн яам дээр нэмэгдээд ингээд саяын ярьдаг шалтгаан бол асуудал байгаа учраас ингээд баахан газар асуудал нэмж байна гэж үзээд өнгөрсөн жил бид яасан бэ гэхээр дахиж бид магадлал хийхгүй, бид аудит хийхгүй. Бид харин энэ жил 2026

онд саяын ярьдаг Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Зам, авто замын хөгжлийн төв рүү энэ зураг хийгээд яагаад ингээд асуудал үүсгээд байгаа юм бэ гэдэг рүү нь.../минут дуусав/

П.Ганзориг: Гүйцээж хариулъя.

С.Магнайсүрэн: Сэдэв батлаад орчихсон байгаа, одоо манайх яг үзэж байна. Яагаад ингэж алдаатай, буруу зөрүү, чанаргүй зураг хийгээд, тэрэн дээрээ үндэслэсэн буруу зөрүү төсөв хийгээд магадлаад байгаа юм бэ гэдэг асуудал руу орох гэж байгаа учраас саяын Энх-Амгалан сайдын ярьдаг энэ асуудал энэ хүрээнд гарч ирээд, бид намар гэхэд Байнгын хороон дээрээ яриад нэлээн онош юм нь гаргаж ирээд, холбогдох арга хэмжээг авчих болов уу гэсэн ийм тооцоолол хийж байгаа. Цаашдаа манайх энэ төсөвт өртөгтэй холбоотой магадлал хийхгүй ийм байгаа. Энэ жил шал өөр сэдэв рүү орж байгаа. Хуучин Төсвийн байнгын хороон дээр төсөвт өртгийн нэмэгдэл гэж сэдэв баталчхаад ингээд ороод байдаг байсан, энэ асар их ачаалалтай байсан.

Зулпхар гишүүний асуусан энэ ипотекийн зээлтэй холбоотой асуудлаар орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 25 онд 1.2 их наяд төгрөгийн зээлийг 9894 иргэнд олгосон ийм дүн мэдээ гарсан. Үүнээс арилжааны банкны эх үүсвэр 214.6 тэрбум төгрөгөөр.../минут дуусав/

П.Ганзориг: Гүйцээж хариулъя.

С.Магнайсүрэн: Арилжааны банк өөрийн эх үүсвэрээрээ 1566 иргэнд олгосон юм байна лээ. Энэ нөгөө хүүгийн хувьд арай өөр ийм юутай. Монголбанкны эх үүсвэр 583.9 тэрбум төгрөгийг 4664 иргэнд олгосон, хуримтлалын сангийн эх үүсвэрээр 462.3 тэрбум төгрөгийг 3664 иргэнд тус тус олгосон байдаг. Нийт олгосон зээлийн 63.7 хувь нь Улаанбаатар хотод, бусад нь орон нутагт олгогдсон ийм дүнтэй байгаа. Ер нь Улаанбаатар хотоос орон нутагт шилжин ажиллах төрийн албан хаагчдыг төрийн албанд ажилласан жилтэй нь уялдуулаад орон нутгийн 3 хувийн ипотекийн зээлд хамруулж, орон сууцны урьдчилгаа төлбөрийн 60 хүртэлх хувийг батлан даалт гаргах үйл ажиллагааны хүрээнд 1111 зээлдэгчид 131.8 тэрбум төгрөг олгогдсон ийм дүн мэдээтэй байгаа. Манай шийдэл цаашдаа энэ стратегийн орд болоод үүсмэл ордоос орлого олж, энэ баялгийн санд төвлөрүүлэх замаар энэ тал дээр тодорхой арга хэмжээ авах ийм санал шийдлийг гаргаж тавьсан байгаа.

П.Ганзориг: НДЕГ хариулах уу?

Б.Батжаргал: НДЕГ Батжаргал. Зулпхар гишүүний асуултад хариулъя. 2023 онд батлагдаад 2024 оноос хэрэгжиж байгаа Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдах ажлыг НДЕГ гүйцэтгэж байгаа. Гэхдээ энэ ажлыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Үндэсний зөвлөлийн дэргэд ажиллаж байгаа мэргэжлийн хороо, хараат бус мэргэжлийн багууд ажиллаж байгаа. Олон нийтийн хяналтын зөвлөл хяналт тавьж ажиллаж байгаа. Бид энэ ажлыг Монголбанктай, Сангийн яамтай, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай мэдээлэл солилцоод ажиллаад өнгөрсөн онд удирдлаа. Энэ удирдсаны үр дүнд нийт 700 тэрбум төгрөгийг арилжааны системийн ач холбогдол бүхий арилжааны 5 банканд байршуулсан. Энэ хүү нь жилийн 15 хувьтай байсан. Нийт олох хүүгийн хэмжээ 25 онд яг санд бүртгэж авсан дүн нь 70 тэрбум төгрөгийн хүүгийн орлого

байлаа. 300 тэрбум төгрөгийг ЗГ-ын бондыг хаалттай арилжаагаар бид худалдаж авсан. Энэ дотроо 100, 100 тэрбумаараа 3 өөр хүүтэй, хугацаатай.../минут дуусав/

П.Ганзориг: Гүйцээж хариулъя.

Б.Батжаргал: 2025 онд санд хүлээж авсан хүүгийн орлого нь 30 тэрбум төгрөг байгаа. Арилжааны банкнуудтай хэлцэл хийгээд бид сангийн чөлөөт үлдэгдлийн хүү дээр бид харилцахын хүүгээр орлого олдог. Энэ дээр 5 тэрбум болсон, ингээд нийтдээ 2025 онд нийтдээ 105 тэрбум төгрөгийн орлого ингээд санд хүлээж авсан, санг арвижуулж байгаа. Нийт хөрөнгө оруулалтынхаа удирдлагаар одоогийн байдлаар хүлээгдэж байгаа орлого 325 тэрбум төгрөгийг бид санд хүлээж авахаар ингээд хүлээгээд удирдаж ажиллаж байна. Баярлалаа.

П.Ганзориг: Зулпхар гишүүн тодруулъя.

С.Зулпхар: Энх-Амгалан гишүүнд баярлалаа, их тодорхой зүйл ярилаа, тендерийн хонгил бий болчихсон юм байна гэж. Энэ тендерийн хонгил сурагчдын эрхэд халдаж байгаа юм байна, боловсролын хөгжлийг сааруулж байгаа юм байна, улс орны хөгжлийн ний нуугүй хэлэхэд чөдөр тушаа болж л байгаа гэдгийг бүгд мэдэж байгаа. Тэгэхээр бид энэ 65 объектын асуудал яригдаж байна, тийм ээ, ойрын хугацаанд ашиглалтад оруулах ёстой, ашиглалтад ороход бэлэн болчихсон байгаа бол комисс хүлээгээд авах ёстой ч гэдэг юм уу. Тэгэхээр энэ тендерийн хонгилыг яаж задлах вэ, эсвэл яаж энэ хонгилыг дэлбэлэх вэ, эсвэл ийм хонгилыг яаж байхгүй болгох вэ гэдэг дээр ямар бодлого, ямар чиглэл барих ёстой вэ? Энэ дээр зүгээр таны байр суурийг сонсьё.

П.Ганзориг: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Яах вэ энд Сангийн яам нэлээн манлайлал үзүүлж энэ ямар ч байсан нэг бүх объектыг 3 жилийн дотор ордог нэг ийм л санхүүжилтийн юу тавиад яваад байгаа шүү дээ. Гол нь тендерийн хонгил хаанаас үүсдэг вэ гэвэл Их Хурлаас үүсдэг шүү дээ, тийм ээ. Бид Их Хурал дээр яг төсөв хэлэлцэх үед зураггүй, газаргүй, энэ жил гэхэд 6 газаргүй сургуулиудын төсвийг нь батлаад явуулчхаж байгаа шүү дээ гэх мэтчилнээр улсын төсөв дээр суулгаад явуулчхаж байгаа юм, гэх мэтчилнээр энэ асуудлыг бид Их Хурлын гишүүдээсээ, Их Хурлаасаа төсөв баталж байгаа энэ процессоос эхлэх ёстой гэж ойлгож байгаа. Уг нь Сангийн яаман дээр хэрэгжиж байгаа, манай яаман дээр хэрэгжиж байгаа энэ School Mapping гэдэг энэ платформуудаараа яг төлөвлөлтүүдээ зөв хийгээд, тэгээд яг цэцэрлэг, сургууль, дотуур байр, шаардлагатай газарт нь төлөвлөж чаддаг, тэр нь газартай, тэгээд тэр нь тодорхой яг 3 жилийн дотор, 2-оос 3 жилийн дотор орох ийм бололцоотой тендерүүдийг л зохион байгуулбал бид энэ тендерийн хонгилыг л нураах хамгийн зөв арга.

П.Ганзориг: Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Рэгдэл гишүүн асуулт асууя, үг хэлье.

Д.Рэгдэл: Төсвийн гүйцэтгэл хэлэлцэж байгаатай холбогдуулаад 2 санал байгаа юм. 1 дүгээрт, энэ Төрийн хэмнэлтийн тухай хууль гээд нэг хууль байдаг юм, тэгээд энэ хууль чинь нэг их сонин хууль шүү дээ. Монгол Улсад санхүүгийн жил 1 дүгээр сарын 1-нээс эхлээд л 12 дугаар сарын 31-нд дуусаад байх шиг байгаа юм.

Тэгэхээр энэ хууль дээр, энэ Төрийн хэмнэлтийн хууль дээр энэ тендертэй холбоотой асуудлыг 5 дугаар сарын 31-нээр гэрээ байгуулаагүйг таслаад хаячхаж байгаа юм. 5 дугаар сарын 31-нээр дуусаад, хамгийн гайхалтай нь энэ хуульд бас нэг заалт яваад байгаа. Энэ манай Сангийн яамныхан энэ дээр анхаарах ёстой. Энэнээс, энэ тендерээс хэмнэсэн мөнгийг зарцуулж болохгүй гэсэн заалттай агуулгаараа. Тэгэхээр зэрэг тэр мөнгийг яах ёстой юм. Яагаад 5 дугаар сарын 31-нд бүх юмаа ингээд хаагаад хаячихдаг юм. Энэнээс болоод ер нь хөрөнгө оруулалтын, ялангуяа энэ тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт дээр их хохирол гарч байгаа юм. Санаатай юм шиг нэг компани, ялагдсан компани зарга үүсгэчихдэг, 5 дугаар сарын 31-нд зарга нь дуусна, тэгээд л тэр тендер тэгээд уначихдаг. Тэгэхээр энэ төсвийн, энэ Төрийн хэмнэлтийн хуулийг яг энэ заалт дээр анхаарч, энэ санхүүгийнхээ жилтэй, ялангуяа энэ барилга байгууламжаас бусад хэсэг дээр бүтэн жил энэ тендер сонгон шалгаруулалт, энэ процесс явдаг болгож хийхгүй бол олон байгууллага хохирч байгаа бодитой жишээнүүд байдаг.

2 дахь асуудал Энх-Амгалан сайд хэллээ. Энэ төсөв ер нь ихэнх стандарт объектуудыг 3 жилд нь багтаагаад барихаар ингээд төсөвлөж байгаа нь их оновчтой зөв шийдэл байгаа юм. Гэтэл 3 жилд багтаагаад үнийг нь бараг нугалаад өсгөчихдөг энэ арга барил яваад байгаа юм. Одоо үүнд чинь аудит манай аудит хийхээ больж байгаа юм байна, Ерөнхий газар маань татгалзаж байгаа юм байна. Тэгэхээр энэ юунаас болоод үнэ өсөв? Энэ үнэ өсөлтийн энэ механизм яваад байгаа шүү дээ, энэ чинь. Барилгын хөгжлийн төвөөр ч юм уу ямар нэгэн хөгжлийн төвөөс гаргаж ирээд л, тэгээд л Сангийн яамаар оруулаад л ингэж явсаар байгаад үнийг ерөөсөө хамаагүй өсгөөд хаячихдаг. Энийг зогсооход хамгийн үүрэг гүйцэтгэх газар Сангийн яамыг гэж бодоод байгаа Сангийн яам. Ингэж Сангийн яам энэ дээр хяналт тавьж, хязгаарлаж чадвал, жишээ нь аудит хянахгүй юм чинь энэ үнэ өсгөдөг механизм, энэ технологи улам боловсронгуй болдог, улам цар хүрээтэй болдог ийм явдал болоод байгаа юм. Энийг Сангийн яам анхаарч дараа дараагийн асуудал дээр их анхаармаар байгаа юм.

3 дахь асуудал сая аудитын дүгнэлт дээр гарч байна шүү дээ, ингээд яг ингээд үнэлээд дүгнээд ингээд үзэхээр нөгөө шалгуур үзүүлэлтүүд тодорхой биш, хэмжих аргагүй юм байгаад байдаг. Энэ дээр манай Их Хурал, манай Байнгын хороо хариуцах асуудал дээр анхаарч ажилламаар байгаа юм. 26 оны улсын хөгжлийн төлөвлөгөөнөөс эхлээд манай Их Хурлын зарим гишүүд санаачилга гаргаад энэ шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох нэлээн асуудлуудыг тод томруун хэмжиж болдог болгоод явж байгаа юм. Тэгээд тэрнээс өмнөх, жишээлбэл 24 оных чинь шалгуур үзүүлэлтийн тодорхой бусаас болоод аудитыг дүгнэлт хийхэд хэцүү байдалд үүсгэж байгаа явдал Их Хурал өөрөө буруутай байгаа юм. Энэ дээр Их Хуралтай ажилладаг байгууллагууд санаа оноогоо тавьж ингэж өгвөл энэ шалгуур үзүүлэлтийг сайжруулах амархан шүү дээ. Энэ чинь Их Хурлын гарт л байж байгаа юм чинь. Тендерийн хуулийг сайжруулъя гэвэл Их Хуралд л байна. Энэ дээр та нөхдийн санаа оноо их хэрэгтэй байгаа юм. Энэ төсвийн гүйцэтгэл том байр суурь эзэлдэг хэрэгжилт талдаа тодорхой.../минут дуусав/

П.Ганзориг: Сархадын Зулпхар гишүүн үг хэлье.

С.Зулпхар: Маш чухал зүйлийг бид ярьж байна л даа. Энэ тендерийн хонгил гээд шинэ ойлголт бий боллоо. Яагаад гэвэл нөхцөл байдал нь тодорхой байгаа учраас тэрнийг бид энгийнээр л илэрхийлэх нэг ийм л алхам. Гэхдээ энэ тендерийн,

жишээ нь хонгил их олон оролцогчтой юм шиг байгаа юм. Энэ дангаараа яах вэ УИХ-ын гишүүд биш байх, мэдээж УИХ-ын гишүүд оролцогдог юм шиг байна. Нөгөөтээгүүр энэ дээр Барилгын хөгжлийн төв л гэнэ, цаашлаад энэ дээр чинь тухайн барилга байгууламжийг барихаар тендер авчихсан компаниуд байж байгаа байх, тухайн асуудлыг хянаж байх ёстой байгууллагууд байгаа байх. Тэгэхээр энэ их олон оролцогчтой ийм л хонгил боллоо л доо. Тэгэхээр энэ хонгилыг бид задлахгүй, энэ хонгилыг байхгүй болгохгүй бол ингээд үргэлжлэх юм бол их олон салбарт энэ цаана нь олон хүний эрх зөрчигдсөн нөхцөл байдлыг бий болгож байгаа. Энэ ер нь бодитой үг. Энэ үгийг бодож олж хэлсэн Энх-Амгалан сайдын хувьд бодит туршлага дээр, бодит байгаа нөхцөл байдлыг хамгийн жишээ нь ойроос ойлгодог хүний хувьд хэлж байна. Та очсон салбар дээрээ тодорхой асуудлыг маш тодорхой олж аваад, тэрийг дандаа шийдэж байсан, шийдэж, цаашдаа ч гэсэн шийдэх байх. Танай салбарт их олон асуудал байсны шийдлийг тухайн үед та тодорхойлж байсан. Өнөөдөр сайд болоод та шийдлүүдийг нь хийгээд явж байгаа. Би энэнд талархалтай хандаж байна.

Гэхдээ сая гишүүд хэлж байна, Рэгдэл гишүүн ч гэсэн хэлж байна, энэ тэгэхдээ тендерийн хонгилыг жишээ нь бид үгүй болгох чиглэлээр их тодорхой ажлууд хийж байгаа байх. Цаашдаа их салбар салбараасаа хийх ёстой юм байна гэж. Сангийн яам үнэхээрийн ажиллах ёстой, энэ жишээ нь төсвийг нь ингээд он дамнуулаад 5, 6 жилээр тавьдгийг болиулмаар байна. Тухайлбал, нэг сургуулийн жишээ нь анхны төсөвт өртөг нь 4 дахин нэмэгдчихсэн, 8 жилийн дараа одоо ашиглалтад ороогүй байж байгаа байхгүй юу. Энэ үнэхээрийн харамсалтай, цаана нь хэчнээн 100 хүүхдийн хөгжих эрх зөрчигдөж байгаа юм. Энэ улс орны л хөгжлийн асуудал шүү дээ. Тэрний цаана чинь хөгжсөн хүний асуудал яригдаж байгаа учраас. Тэгэхээр энэ хонгилыг нураах ёстой, энийг бараг ЗГ-ын тэргүүлэх жишээ нь зорилт болгох ёстой. Ардчилсан нам /АН/-ынхан ч гэсэн энэ асуудлаар их тодорхой байр суурь илэрхийлсэн шүү дээ. Энэ өнгөрсөн хугацаанд он дамнуулж хийж байгаа ажлаас болоод хэдэн их наядын жишээ нь төсөвт ачаалал үүсгэсэн ийм байдал үүсчихсэн гэж байгаа юм.

Гэтэл бид сургуулийг жилийн дотор, 2 жилийн дотор барьж болдог, цэцэрлэгийг жилийн дотор, 2 жилийн дотор барьж болдог, бусад барилгуудыг ч гэсэн тэгж барьж болдог бодитой жишээ нь туршлагыг хувийн хэвшлээсээ харж байна шүү дээ. Тэгэхээр тэр туршлагаар нь тендерийг нь жишээ нь 2 жилд нь багтаадаг болгомоор байна. Цаашлаад энэ нэг шүүхээр явдаг тэгээд янз янзын процессууд байна. Шүүхдээд очоод жишээ нь янз янзын байдлаар тухайн ажлыг гацаадаг, энэ нөгөө тендерийг авсан талыг л хэлж байгаа шүү дээ. Энэнээс болоод 8 жил юм уу, 10 жил юм уу болчихсон барилга байж байдаг, хэзээ ашиглалтад орох нь бүү мэд бараг музей болж байгаа байхгүй юу. Зарим нь жишээ нь балгас болчихсон, тэр нь бараг эртний жишээ нь юу гэдэг юм туурь болчихсон ийм газрууд байж байна. Энэ манай хөгжилд байж болохгүй зүйл. Бид 21 дүгээр зууны 26 онд амьдарч байна. Зарим зүйлээс маш хурдан татгалзаж, шинэ нөхцөл байдалтайгаа уялдсан байдлаар бидэнтэй ижилхэн гарааны нөхцөлөөс гарсан улсуудын тэр туршлагаас нь суралцсан байдлаар урагшлахгүй бол болохгүй.

Тэр Их Хурлын гишүүд ерөөсөө чухал асуудал биш шүү дээ. Тэр хүн жишээ нь 4 жил байгаад дараа нь байх эсэх нь тодорхойгүй байж байгаа бол, тэгээд л тэр тендерийн араас нэг удаа жишээ нь санаа тавьчихаад 6 жилийн дараа, 8 жилийн дараа санаа тавих боломжгүй ийм л нөхцөл байдлууд үүсэж байгаа учраас энэ дээр

бид аль, аль нь хариуцлагатай байх ёстой юм байна. Миний хувьд жишээ нь Их Хурлын гишүүддээ ч гэсэн уриалж байна. Ийм тендерийн хонгилууд руу битгий жишээ нь санаатай, санамсаргүй орчхоорой л гэж хэлмээр байна. Жишээ нь та бүхэн ч гэсэн энэ дээр олон нийт бидэнд анхаарал тавих ёстой, бидэнд хяналт тавих ёстой. Компаниуд ч гэсэн хариуцлагатай байя, компаниудыг эх оронч байя гэж хэлмээр байна. Эх оронч байя, цаана нь хүүхдүүдийн хувь заяа байгаа, та бол үнэхээрийн хариуцлагагүй, сэтгэлгүй л байна гэдгийг ойлгох ёстой ийм л юм байгаа юм. Олон нийтээрээ л бид чинь жишээ нь тодорхой асуудалд хариуцлагатай байх ёстой юм байна гэдгийг л ойлгох ёстой.

П.Ганзориг: Буланы Бейсен гишүүн үг хэлье.

Б.Бейсен: Энэ боловсрол, эрүүл мэндтэй холбоотой юм ярья. Ер нь хөдөө тендер авчхаад ер нь ашиглалтад оруулахгүй 7, 8 жил болсон барилгууд байж байгаа. Ногооннуур сумын Соёл, спортын төв гээд байгаа, 7 дахь жилдээ байна уу, 8 дахь жилдээ байна уу. Хотгорын уурхай гээд байгаа, бараг 9 дэх жилдээ байна уу энэ жил. Эмнэлэгт, тэнд чинь сургууль, цэцэрлэгтэй, эмнэлэг, уурхай, тэнд нөгөө олон уурхай байгаа. Тэгээд аваар осол гардаг эмнэлгийг нь барьж өгөхдөө анх 400 сая төсөвтэй байсан, одоо 2 тэрбум давсан уу яав ийм юм байна. Ийм юман дээр хариуцлага тооцож ажиллахгүй бол ер нь Аудитын газар, Сангийн яам, сая Энх-Амгалан сайдын ярьдгаар ер нь хар дансанд оруулахгүй бол энэ улсууд чинь төсөв өсгөөд, улсын төсөвт хүндрэл учруулж байна шүү дээ. Энийг анхаарах шаардлагатай байгаа юм. Өлгийн үерийн хамгаалалтын асуудал байж байгаа, анх 12 тэрбум байсан, одоо бараг 30 тэрбум хүрчхэв үү дээ ийм л асуудал байгаа юм. Жалга, онгоцоор явж байхад жалга дагаад үерийн хамгаалалт хийчихсэн, хот тойруулан хамгаалалт хийгээд, ноднин ер болоход тэгээд ихэнх айлууд усанд автсан асуудал байгаа юм.

Дараа нь энэ эрүүл мэндийн салбарын өр зээлийн асуудал байж байна. Энэ эмийн компанийн өр гээд байх юм, эмнэлгүүд чинь эм, эмнэлгийн хэрэгсэлгүйгээр явахгүй. Энийг эмийн төсөв, урсгал зардлыг нь Сангийн яам хассан гэсэн, би ЭМЯ-наас асуусан. Сангийн яам энэ дээр анхааралтай хандахгүй бол зарим юман дээр шууд хасчхаад, энэ цаашлаад эмнэлгийн тусламж, үйлчилгээ цалгардаж байгаа асуудал үүсэж байна. Хэвтэж байгаа улсууд гаднаас эм авчирч байна, эм, эмнэлгийн хэрэгслийг гаднаас авчирч байна, гадагшаа явж байна, дугаар дараалал хэдэн сараар хүлээж байна, чирэгдэл ихтэй ийм асуудал гарч байна. Даатгалтай улсууд хэвтэж эмчлүүлж чадахгүй байна. Өндөр өртөгтэй юуны хамаарал, бүлгийн юунаас хамааралтай, бүлгийн багцаас хувийн эмнэлгүүд их хэмжээний тэрбумаар нь юм авчхаад, тэгээд төлбөртэй үйлчилж байгаа асуудлууд байж байна. Үнэхээр эрүүл мэндийн салбарын ажил хүнд байна. Харин Батшугар сайд очоод нэг цэгцэлж байх шиг байна. Тэгэхдээ ер нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний байдал хүнд байгаа шүү, эрүүл мэндийн салбарын төсвийг битгий хасаач та нар. Сангийн яамныхан маань анхаараад энийг. Цаана нь чирэгдэл үүсэж байна, тэгээд эмийн үнэ өндөр байна, буухгүй байна, эм авч чадахгүй байна, үнэхээр хүнд байдалтай байна, энийг нэг анхаараач гэдгийг хэлмээр байх юм нэгдүгээрт.

2 дугаарт энэ эмнэлэг барьчхаад төсөв, бүтэц, орон тоо баталж чадахгүй, Ховд багийн эмнэлэг барьчхаад 3 дахь жил болж байна. Тэнд сургуультай, цэцэрлэгтэй олон айл байдаг, сайхан эмнэлэг барьчихсан мөртөө төсвийг нь баталж өгдөггүй ийм асуудал байж байна. Машиныг нь олгочихсон, эмч нь бэлэн байж

байдаг, одоогоор нэг ганц бага эмч л ажиллаж байгаа, их эмч энэ тэр нь тэнд хүлээж байгаа, тэгээд байшинг нь манасан нэг манаач тэнд байж байгаа. Тэгэхээр ийм барилга баривал комплексоор нь шийдэж байхгүй бол болохгүй асуудал байж байна. Ноднингийн Өлгийд тэр том эмнэлэг баригдсан, оношилгооны төв, бас дотор тоног төхөөрөмж нь дутагдлаа, энэ жил бид тавьж байна. Ялангуяа сэхээ, мэс заслын асуудал дээр. Тийм учраас ийм юм дээр анхаарч ажиллаач гэдгийг хэлмээр байх юм.

П.Ганзориг: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн үг хэлье.

Л.Энх-Амгалан: Би энэ 25 оны төсвийн гүйцэтгэл ярьж байна. Мэдээж хойтон гээд 26 оных яригдана. Тэгээд эндээс нэг ийм тогтолцооны шинэчлэлээ хийдэг нэг ийм эрх зүйн боломжуудыг нь өгдөг байгаасай гэж би бодож байгаа юм. Тэгэхээр үндсэндээ бид ингээд нэг ийм баахан зовлон тоочоод, тэгээд зовлонгийнхоо шалтгааныг олохгүй бол, зовлонгийнхоо үндсэн шалтгааныг олохгүй бол зовлонгоос арилахгүй гэдэгтэй адилхнаар ингээд бид үндсэндээ энэ төсвөөс санхүүжүүлдэг энэ тогтолцоогоо нэг жаахан эргэж харах болсон юм шиг байна гэж би 3 удаа салбарын сайдаар, ЗГ-ын гишүүнээр ажиллаж байна. Ингэж бодогдоод байгаа юм.

Жишээ нь, цаашдаа төр ер нь ингээд ийм сургууль, цэцэрлэгүүд ингээд бариад, барьсан нэртэй ингээд нэг ийм баахан өндөр зардалтай ийм тогтолцоогоор явах юм уу, эсхүл төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрүүдийг гаргаж ирэх ийм зайлшгүй шаардлагууд байна гэж бодож байгаа шүү дээ. Үндсэндээ манай боловсролын салбарын 100 гаруй мянган багш, ажилтнуудын чинь бараг 50 гаруй хувь нь багш бус ажилтнууд болчихоод байж байгаа шүү дээ. Тэгээд нөгөө төрийн албан хаагчдын тоо нэмэгдэж байгаа, нэг ийм тоо нэмэгдээд байдаг. Шинэ сургууль, цэцэрлэг орох бүрд дандаа төрийн албан хаагчдын, төрийн үйлчилгээний албан хаагчдын тоо нэмэгддэг. Уг нь түрүүчийн удаа би Боловсролын сайдаар ажиллаж байхад шинээр орсон цэцэрлэг, сургууль, дотуур байрууд дээр би ер нь үйлчилгээний ажилтан нэмэхгүй, гэрээт ажилтнаар явъя, outsource хийе гэдэг их сайн туршлагуудыг нэвтрүүлээд ингээд нэг үр дүнд хүрэх ёстой байсан. Тэгээд харамсалтай нь ингээд энэ бодлого дундаа гээгдээд, сарниад ингээд алга болчих шиг боллоо л доо.

Тэгэхээр би Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яамныхныг цаашдаа энэ төсвийг санхүүжүүлдэг энэ санхүүжилтийнхээ тогтолцоог бид жаахан эргэж хармаар юм байна гэж харж байгаа. Бид маш сайн гүйцэтгэдэг гүйцэтгэгч их олонтой болсон. Монгол Улсын барилгын салбар жилд 20 мянган айлын орон сууц барьчихдаг, ийм хороолол хорооллоор нь барьчихдаг ийм чадавхтай. Манай салбарт сургууль, цэцэрлэгүүдийг нэг жил байтугай 6 сарын дотор гүйцэтгэж байсан сайн туршлагууд байгаа шүү дээ. Тийм биз дээ Ганзориг даргаа. Хөдөө суманд 650 хүүхдийн сургуулийг оруулж байсан ийм компаниуд байдаг. Тэгэхээр энэ үндэсний энэ гүйцэтгэгчид энэ компаниудыг яг энэ сургууль, цэцэрлэг сайн барьж байгаа компаниудыг урамшуулдаг энэ тогтолцоо руугаа бид 1 дүгээрт орох ёстой гэж бодож байгаа.

2 дугаарт, энэ гүйцэтгэлд суурилсан энэ санхүүжилтийнхээ тогтолцоо руу орохгүй ингээд 2, 3 жилээр хувааж тавиад ингээд л яг л үндсэндээ төр өөрөө энэ бүх юмны чинь тендерийн хонгилыг чинь төр өөрөө үүсгэж байгаа байхгүй юу. Зулпхар гишүүнээ, төр өөрөө үүсгэж байгаа. Тэгэхээр төр энэ байдлаасаа нэг салж, ер нь

салбар бүхэн цаашдаа энэ зөвхөн барилга байшин биш амархан элэгддэг энэ компьютер, тоног төхөөрөмжүүд, эмнэлгийн тоног төхөөрөмжүүд гэх мэтчилнээр ингээд энэ төсвийн санхүүжилт нөгөө санхүүгийн түрээсийн хэлбэрээр 3-аас 5 жил түрээслээд амархан элэгддэг зүйлүүдээ төр худалдан авалт хийхгүйгээр нэг ийм хэлбэрүүдийг хийдэг. Энийг ингээд нэг төсвийн ерөнхийлөн захирагчдад нь тодорхой эрх мэдлүүдийг нь өгдөг нэг ийм реформын шинж чанартай төр яаж хэзээ, үр дүнтэй, өгөөжтэй, бүтээмжтэй төр болох вэ л гэдэг асуудал яриад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ боломжуудыг нь энэ Төсвийн тухай хууль, энэ Төрийн албаны тухай хууль, Тендерийн хууль гээд нэг хэдэн чөдөр тушаа болчихсон хэдэн хуулиуд байгаад байгаа шүү дээ.

Тэгээд Монгол Улсын ЗГ-аас хэрэгжүүлж байгаа энэ чөлөөлье гэдэг энэ хүрээнд цаашдаа энэ төсвийн ерөнхийлөн захирагч нарт яг энэ хөрөнгө оруулалт, тухайн салбарын хөрөнгө оруулалтыг явал өгөөжтэй хурдан болгох вэ, санхүүжилтийн хамгийн зөв хэлбэрүүд юу болох вэ гэдэг энэ тогтолцооныхоо шинэчлэлийг бид ярихгүйгээр ингээд л жил бүхэн яг л ийм зовлон ярина, аудит яг л ийм дүгнэлт уншина. Тэгээд ингээд тодорхой шийдлүүдгүй, бодлогын шийдлүүдгүйгээр бид их удаж байна шүү. Нэг ийм шаварт суучихсан ингээд нэг л ийм машин шиг л болчихсон улс орон болчихоод байж байна шүү дээ. Тэгэхээр хамгийн их хөрөнгө оруулалтууд татдаг энэ боловсролын салбар, эрүүл мэндийн салбар магадгүй энэ манай Байнгын хорооноос иймэрхүү.../минут дуусав/

П.Ганзориг: Би энэ төсвийн гүйцэтгэлтэй холбоотой тодорхой саналууд хэлье. Ер нь асуултууд их байна. Тэгээд ер нь төсөв батлахаас илүүтэйгээр төсвийн гүйцэтгэл хэлэлцэх маш өндөр ач холбогдолтой байдаг. Бусад улс орнууд тэгж л явдаг. Төслийн цаглавар дотроос, төсөв батлах цаглавар дотроо төсвийнхөө гүйцэтгэлд хийж байгаа санал дүгнэлтийг авч, ирэх оныхоо төсвийн төлөвлөлтөд нарийн тусгаж явдаг. Харамсалтай нь манай Монгол Улсын хувьд төсвийн гүйцэтгэлийг сонсоод, нэг аудитын тайлан сонсоод ингээд орхидог. Жилийн жилд ингэж явдаг.

Тэгэхээр аудитын дүгнэлтийг харж байхад жил болгоны гардаг алдаа доголдол хэвээрээ л байна. Яг энэ байдлаараа цаашдаа хэвээрээ байх нь. Тэгэхээр энэ юунаас гол үүдэлтэй вэ гээд тэгэхээр гүйцэтгэл дээр гарч байгаа асуудлуудыг бид сонсоод өнгөрөх биш, яг бодитой төсвийн үр ашиг, сахилга хариуцлагыг сайжруулахад хариуцлагын тогтолцоо бий болох чухал байгаад байгаа юм. Энэ хариуцлагын тогтолцоо сайжраагүйгээр тэр зураг төсөв нь тодорхойгүй төсвийн хөрөнгө оруулалтууд тавьж төсөв баталдаг байдал арилаагүйгээр, эсвэл батлагдсан төсвийг зориулалтын бусаар зарцуулдаг, хэтрүүлдэг, үр ашиггүй зүйл зардаг асуудал дээр хатуу хариуцлага ноогдуулдаг, хатуу хариуцлага ноогдуулдаг болохгүйгээр энэ өөрчлөгдөхгүй. Цаашдаа энэ давтагдаад л жил болгон бид төсвийнхөө, аудитынхаа дүгнэлтийг сонсоод л ингээд явна.

Тийм учраас бид цаашдаа энэ төсвийн сахилга хариуцлагын асуудлыг чангатгах, хууль, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлд Их Хурал анхаарч ажиллах ёстой гэж бодож байна. Тухайлбал бид төсвийнхөө дандаа дүнг хараад яриад байдаг, жил болгон төсвөө өсгөөд яваад байдаг. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын төсөв байгаагүйгээрээ огцом нэмэгдсэн шүү дээ, өссөн. Одоо 34, 35 их наядын төсөв яриад сууж байдаг. Харамсалтай нь яг энэ төсөв тэлсэн хэрээр ард иргэд, ААН-ийн бодит орлого, ашиг, амьдрал сайжраагүй, үр нөлөө нь хүрээгүй. Тийм болохоор энэ

зардлын тоон дүнд биш яг энэ төсвийн үр нөлөөг нарийн тооцдог, тэр хэмждэг нэгжүүдийг оруулж ирдэг ийм зүйл рүү явахгүй бол болохгүй. Тэгээд энэ төсвийн асуудал ярихаар зөвхөн Сангийн яамтай яриад байдаг, гүйцэтгэл дээр ч гэсэн Эдийн засаг, хөгжлийн яам байх ёстой. Хөгжлийн бодлого хэрэгжүүлэх гол хэрэгсэл чинь төсөв шүү дээ. Тэгээд тэрийгээ яаж тавиад, ямар үр ашигтай Монгол Улсынхаа эдийн засгийг харж байгаа юм бэ гэдэг дээр гүйцэтгэл дээр нь ч ялгаа байхгүй, төсвийн төлөвлөлт дээр ч байхгүй энэ Эдийн засаг, хөгжлийн яамыг жаахан чухал үүрэг рольтой оруулахгүй бол тэгээд төсвийн орлого бүрдүүлэх гол үүрэгтэй байгууллагаа бид Сангийн яаман дээр бүх ачаа, үүрэг хариуцлагаа өгөөд суугаад байгаа нь буруу гэж харж байгаа юм нэг.

2-т тухайлбал хөрөнгө оруулалтын асуудал байж байна, урсгал зардлын асуудал байж байна. Асар олон шаардлагагүй урсгал зардлуудыг бид төр дагаж томорч байгаа хэлбэрээ дагаж тавьж өгдөг, төрийн бүтэц, яам, агентлагууд томорч байгаа хэрээр дагаж өгдөг, тавьдаг, хурал уулзалт, гадаад томилолтын зардал гээд л яривал олон зардлууд байж байгаа. Тэгээд эдгээр дээр нэг дүн шинжилгээ хийж цэгцлэхгүй бол энэ урсгал зардлууд нь хүртэл үр нөлөө их муутай болчихсон. Зүгээр тодорхой жишээ хэлэхэд бид уул уурхайн баялгаасаа олж байгаа орлогоороо Баялгийн сангаа бүрдүүлж байгаа. Ирээдүйн өв санд, Хуримтлалын санд 2-т нийлээд бараг 2.3 тэрбум доллар бүрдчихсэн байгаа байх, тийм ээ. Гэтэл энийгээ бид зүгээр гадаад валютынхаа албан нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор гаднын банкнуудад 4 хувиар хадгалдаг. Бусад улс орнуудын баялгийн сан үр ашигтай ирээдүй рүүгээ хөрөнгө оруулалтад ороод өсөж байдаг. Гаднаас бид зээл авахаараа долларын, энэ гадаадад хадгалж байгаа өөрсдийнхөө баялгаас олсон эх үүсвэрээс 2 дахин өндөр хүүтэй зээл авдаг, 8 хувиар ч байдаг юм уу. Өөрсдийнхөө байгаа мөнгийг болохоор 2 дахин бага хүүтэй хадгалдаг. Иймэрхүү байдлаар томоохон хэмжээний тогтолцооны энэ асуудлууд, том хэмжээний зардал гарч байгаа асуудлуудыг бид анхаарч ажиллахгүй бол болохгүй.

Дээр нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргаж байгаа дүгнэлтүүдийг, үнэхээр энэ хууль, эрх зүйн орчныг нь жаахан чангатгаж, энэ зөвлөмжийг нь авч хэрэгжүүлдэг л болохгүй бол тэгээд л нөгөө мөчлөг сөрсөн биш дандаа дагасан бодлого явуулдаг. Тэгээд аз болж өнгөрсөн 2025 онд нүүрсний үнэ төсөвт сууснаас унасан ч гэсэн зөрөөд зэс өссөн. Төсөв дээр бид нэг тонн нүүрсийг 105 доллароор тавьсан, тэгээд 70-аас 90 долларын хооронд л байсан. Азаар зэс 10 мянгаас дээш давж байж нөхөж байгаа байхгүй юу. Тэгээд бид энэ уул уурхайн циклд барьцаалагдсан, хэдхэн эрдэс баялгаас хамааралтай эдийн засагтай яваад энэ төсвийн сахилга бат сайжрахгүйгээр явахгүй. Тэгэхээр энэнээс авхуулаад төсвийн тогтвортой байдлын энэ зөвлөмжүүдийг сайн хэрэгжүүлдэг, хууль, эрх зүйн орчиндоо сайн тусгаж өгдөг болох, мөн Үндэсний аудитын газрын гаргасан дүгнэлтийг зүгээр сонсоод өнгөрөх биш, энийг цааш нь сахилга хариуцлагын асуудлыг нь ингэж шийддэг, хэрэгжүүлдэг тогтолцоотой болж байж л цаашдаа энэ төлөвлөлт, гүйцэтгэл нь ч үр ашигтай, үр дүнтэй, үр нөлөө нь иргэдийн амьдрал, ААН-ийн үйл ажиллагаанд эерэг нөлөөтэй, эдийн засгийн өсөлтийг бодитоор хангах руугаа чиглэнэ л гэж бодож байна. Тэгэхээр энийг холбогдох байгууллагууд нь анхаарч, төсөв төлөвлөгөө боловсруулахаасаа авхуулаад ингээд ажиллаасай гэж хүсэж байна.

2-т сая гишүүдийн асуулт, саналууд дээр чухал саналууд гарлаа. Энийг та бүхэн сонсож тэмдэглэж авсан байх гэж бодож байна. Тэгээд ажилдаа ажил хэрэг

болгохыг хүсье. Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, ЗГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлэг хийж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд УИХ-ын гишүүн Д.Рэгдэл танилцуулна. Ажлын хэсгийн нийт бүрэлдэхүүнд баярлалаа. Орой хүлээж байгаад, энэ өргөн бүрэлдэхүүнтэй орж ирсэнд талархлаа илэрхийлье.

19.08 цаг

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Өнөөдөр бараг манай Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо л ганцхан ирц бүрдэж хуралдаж байх шиг байна. ЗГ-аас Боловсролын сайд Энх-Амгалан сайд цагаа гаргаж бүрэн сууж байгаад талархал илэрхийлье, энэ хурлууд.

Дөрөв.Эрүүл мэндийн салбарын санхүүжилт, эмийн үнэ, хүний нөөц, цалин хөлсний талаарх Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсох

3 дахь асуудал Эрүүл мэндийн салбарын санхүүжилт, эмийн үнэ, хүний нөөц, цалин хөлсний талаарх Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсоно. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулах уу. Хаана байна вэ? Батшугар сайд танилцуулгаа хийчихье. Тэгье.

Э.Батшугар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

УИХ-ын гишүүн Бейсенээс эрүүл мэндийн салбарын санхүүжилт болон салбарт тулгамдаж буй асуудлын талаарх дараах 4 агуулгын хүрээнд мэдээлэл сонсох саналыг ирүүлсний дагуу дараах мэдээллийг танилцуулж байна. Эрүүл мэндийн салбар 2021 оноос эхлэн санхүүжилтийн шинэ тогтолцоонд шилжиж, ЭМД-ын санд түшиглэн нэг худалдан авагчийн тогтолцоог хэрэгжүүлж байна. Энэхүү шинэчлэлийн хүрээнд ЭМД-ын сангийн төсвийн хэмжээ нэмэгдэж, даатгалд учирч буй эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлийг хуваах чадамж нь дээшилж, хувь хүний халаасны төлбөр буурсан. ЭМД-ын эрүүл мэндийн санхүүжилтэд гүйцэтгэх үүрэг, оролцоо нэмэгдэж, түүний хэрээр хариуцлага нэмэгдсэн.

Гэвч сүүлийн жилүүдэд зардлын өсөлттэй уялдсан санхүүгийн хүндрэлүүд үүсээд байна. Тухайлбал эрүүл мэндийн байгууллагуудын өглөг, авлагын харьцаа 2023 онд харьцангуй тэнцвэртэй байсан хэдий ч төрийн албан хаагчдын цалинг 2023 онд 40 хувь хүртэл, 24 онд 8 хувиар нэмэгдүүлсэн, мөн орон нутгийн нэмэгдлийн 40 хувийн нэмэгдэл зэрэг хүний нөөцийн зардал огцом өссөн. ЭМД-ын байгууллага 2025 оноос эхлэн үүссэн өр төлбөрөө бууруулах, сангийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор тусламж, үйлчилгээг худалдан авах үйл ажиллагаанд төсвийн сахилга бат тогтоох арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлсэн. Мөн 2025 онд эрүүл мэндийн байгууллагуудын өр төлбөр нэмэгдэхэд нөлөөлсөн томоохон хүчин зүйлсийн нэг нь 2025 оны улсын төсвийн тодотголын хүрээнд төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулж, үүнийг дагасан төсвийн 54.3 тэрбум төгрөгийг бууруулсантай холбоотойгоор эрүүл мэндийн байгууллагуудын ЭМД-ын сангаас санхүүжих төсвийн мөнгийг бууруулж гэрээ байгуулан ажилласан. Гэвч богино хугацаанд эрүүл мэндийн байгууллагад орон тооны цомхотгол хийх боломжгүй, мөн эмч, сувилагчаас бусад орон тоог бууруулах

чиглэл өгсөн хэдий ч энэ нь хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүссэнээс цалин, НДШ-ийн өр төлбөр энэ хэмжээнд нэмэгдэхэд үндэслэл болсон байна. Үүнтэй холбоотойгоор авлага, өглөгт зөрүү үүсэж эхэлсэн.

ЭМД-ын санд 2022 оноос 24 онд тайлангаар баталгаажсан нийт 316.8 тэрбум төгрөгийн хуримтлагдсан өр төлбөр үүссэн бөгөөд 2025 онд санхүүжилтийн зохицуулалт, бодлого, арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт өр төлбөр 198.3 тэрбум төгрөг болж, 118.5 тэрбум төгрөгөөр буурсан байна. Мөн одоогийн 2026 оны 6 дугаар сарын байдлаар ЭМД-ын сан ямар ч өргүй болсныг хэлмээр байна. ЭМД-ын сангаас 2026 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар лавлагаа шатлалын улсын эмнэлэг 2025 оны өглөгийг бүрэн барагдуулж, 118.3 тэрбум, тусламж үйлчилгээний 1-ээс 4 дүгээр сарын гүйцэтгэл болон 5, 6 дугаар сарын урьдчилгаа санхүүжилтэд 467.2 тэрбум, гэрээний давсан цочмог төлөвлөгөө тусламж үйлчилгээний гүйцэтгэлд ЭМД-ын Үндэсний зөвлөл нь 2025 оны жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга хэмжээ шинэчлэн батлах тухай 04 дүгээр тогтоолын дагуу 81.3 тэрбум, нийт 667.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоод байна.

Эрүүл мэндийн сайдын багцын эрүүл мэндийн байгууллагууд 2025 оны жилийн эцсийн байдлаар 141.1 тэрбум төгрөгийн авлагатай гарсан бөгөөд 217.7 тэрбум төгрөгийн өртэй гарсан байна. Үүний 61.9 тэрбум төгрөг нь татвар болон НДШ-ийн өр төлбөр, 130.2 тэрбум төгрөг нь эм бэлдмэлийн зардлын өр байна. Үүнтэй холбоотойгоор нэмж хэлэхэд энэ өрийн бараг 70 хувийг эрүүл мэндийн 10 байгууллага л эзэлж байгаа шүү. Эмнэлгүүдийн өр төлбөрийн шалтгаанд дүн шинжилгээ хийхэд дараах 2 төрлийн шийдвэрлэх асуудал гарч байна. Үүнд нэгдүгээрт, эмнэлгийн удирдлага, бүтэц зохион байгуулалт, менежменттэй холбоотой асуудал байна. Үүнд эмнэлгийн эмч, ажилтны орон тоо 2020 онтой харьцуулахад огцом өссөн, бараг 4 мянгаар өссөн, эмийн зардлын тэлэлт, тендер хийхгүй авдаг, төлөвлөгөөгүй эмийн тус тусдаа үнээр хийдэг эдгээр асуудал нь өр төлбөрийн шалтгаан байна. Энэ хүрээнд эрүүл мэндийн салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай ЗГ-ын 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 134 тоот тогтоолыг батлуулан цогц арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа бөгөөд уг тогтоолын хүрээнд эмч, ажилтны цалин урамшууллыг шударга, ажлын гүйцэтгэлтэй уялдуулах ажлыг эрчимжүүлж KPI тогтолцоог нэвтрүүлэх, эмнэлгийн бүх шатны үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж давхар цаас хөтлөлтгүй болгох ажлууд, эмийн төвлөрсөн худалдан авалт хийх байдлаар улсын хэмжээнд ижил үнээр авах зэргээр ажлууд хийгдэж байна.

Бодлогын хувьд шийдвэрлэх асуудлууд байгаа бөгөөд үүнд эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг эргэн харах шаардлагатай байна. 20-оос 30 мянган хүн амтай газарт 100 мянган хүн амд байдаг эмнэлэг байгуулсан, орон нутагт эмнэлгүүд байгуулж байна. Энэ бүхэн хүн амын хэрэгцээнээс давсан урсгал зардал нь тогтмол гарч байна. Зарим төрөлжсөн эмнэлгүүдийн хувьд хэт нэг төрлийн үйлчилгээ төвлөрсөн зэрэг асуудлууд байна. Эдгээрийг иргэндээ хүртээмжтэй цогц авах боломжийг бий болгохоор дахин зохион байгуулах, оновчтой болгох зэргээр бодлогын шийдвэр гаргах шаардлагатай байна.

Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлтийг эхлүүлснээс хойш ЭМД-ын сангаас үнийн хөнгөлөлтөд олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг ЭМД-ын Үндэсний зөвлөл 2020 оны 13 дугаар

тогтоолоор баталсан ба 22 оны 11 дүгээр тогтоолоор шинэчлэн баталж одоо мөрдөж байна. Тус 11 дүгээр тогтоолын дагуу 156 өвчний үед хэрэглэх 651 худалдааны нэршлийн 30, 50, 70, 100 хувиар хөнгөлөлт үзүүлж байна. ЭМД-аар хөнгөлөлттэй олгох эмийн жагсаалт гарах тухайн үед бүртгэлтэй байсан хэдий ч бүртгэлийн хугацаа дууссан, бүртгэлийн хугацаанд импорт хийгдээгүй зэрэг шалтгаантай эмийн судалгааг хийж, зохицуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

Монгол Улсын нийт хэрэглэж буй эмийн 20 гаруй хувийг дотоодын 30 орчим үйлдвэр үйлдвэрлэсээр байна, 80 орчим хувийг импортоор авч байна. Эдгээрээс зөвхөн эм үйлдвэрлэх чиглэлтэй 20 үйлдвэрийн 10 үйлдвэр нь эм үйлдвэрлэлийн зохистой дадал болох GMP /Good Manufacturing Practice/-ийн шаардлага хангаж батламж авсан ба дотоодын нийт эмийн үйлдвэрийн 90 хувийг эм үйлдвэрлэлийн зохистой дадлын шаардлага хангасан үйлдвэрүүд үйлдвэрлэсээр байна. Хүн амын тоо цөөн, хэрэглээ хязгаарлагдмал байдлаас шалтгаалан зарим нэрийн эмийг бага тоо хэмжээгээр гадаадын улсын үйлдвэрлэгчид эм, эмийн хэрэгслийг нийлүүлэхгүй байгаагаас эмийн таслалт үүсэх, цаашлаад үнэ нэмэгдэхэд эрсдэл үүсээд байна.

Эрүүл мэндийн салбарын ажилтны үндсэн цалинг 2026 оны 1-ээс 4 дүгээр сард 30 хувиар нэмэгдүүлж, нэмэгдэл цалинг өмнөх түвшинд царцаан хэрэгжүүлсэн бол 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс үндсэн цалинг ЗГ-ын 26 оны 135 дугаар тогтоолын дагуу тогтоож, нэмэгдэл цалинг нэмж тогтоосон цалингаас тооцож эхэлсэн. Тоон үзүүлэлтээр эмч, сувилагч, бусад албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлсэн шийдвэрийн өмнөх үндсэн цалинтай харьцуулж үзвэл эмчийн, тухайлбал, ТҮМ-6 зэрэглэлийн үндсэн цалин нь 2025 онд 1 сая 559 мянган төгрөг байсан бол 26 оны 1 дүгээр сараас 2 сая 26700 төгрөг хүрч, 467 мянган төгрөгөөр өссөн, сувилагчийн ТҮМ-3 зэрэглэлийн үндсэн цалин нь 1 сая 347 мянган төгрөгөөс 1 сая 751 мянган төгрөг хүрч, үндсэн цалин нь 404 мянган төгрөгөөр өссөн. Анхаарал хандуулсанд баярлалаа.

П.Ганзориг: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Э.Батшугар Эрүүл мэндийн сайд, Н.Эрдэнэбаяр ТНБД, Л.Мөнхцэцэг Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Ц.Батбаатар ЭМД-ын ерөнхий газрын дарга, П.Алтанцэцэг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дарга, Ш.Энхтуяа Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын ахлах шинжээч гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байна. Ингээд танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Бейсен гишүүнээр тасаллаа. Сархадын Зулпхар гишүүн асуулт асууя.

С.Зулпхар: Батшугар гишүүнд баярлалаа, их тодорхой мэдээлэл өгч байна. Надад тодорхой ганцхан асуулт байна. Бид гаднаас эм авахдаа одоо байгаа хуулиар ДЭМБ-д бүртгэлтэй, улсын бүртгэлтэй компанийн эмийг Монгол Улсад яаралтай горимоор оруулж ирж тэрийг жишээ нь хэрэглэдэг нэг ийм зохицуулалт хийчихсэн байгаа юм. Яах вэ, тэр байж болох байх олон улсын сайн стандарт гээд. Гэтэл яг тэрэнтэй зэрэгцүүлээд ИСН гээд, жишээ нь миний ойлгосноор олон улсын стандарт байна, өөр ч стандарт байх шиг байгаа юм. Гэхдээ энэ стандартууд ер нь бие биетэйгээ дүйцдэг, бие биеийнхээ түвшинд хэрэглэгддэг, гэхдээ янз янзын улсуудад хэрэглэгддэг. Жишээ нь ИСН-ийг Европын холбооны улсууд л хэрэглэдэг юм байна л даа. Тэгээд ийм зохицуулалт оруулчихсанаас болоод бид их олон улсаас тодорхой төрлийн эмийг янз янзын үнийн санал авч авчирдаг байсан

боломжийг хязгаарлачихсан. Тэгээд үүнээсээ болоод тодорхой төрлийн эмийг ганц хоёрхон улсаас авдаг, тэр нь тогтсон бөгөөд тодорхой өндөр үнэтэй байх ийм нөхцөл байдал үүсчхээд байдаг.

Энэ өндөр үнэтэй эмийг хэрэглэгч нь халааснаасаа төлдөг, нэг бол ЭМД-аас бид мөнгө гаргаж төлдөг нэг ийм байдал руу орчихсон нөхцөл байдлыг бид мэдээлэл авч, энэнтэй холбоотой тодорхой саналууд ирж, үүнийг Эрүүл мэндийн сайдад уламжилж байсан. Тэгээд энэ даруй жил гаруй, жил хагас боллоо. Яах ёстой вэ? Та бүхэн их тодорхой шийдэл хийж байгаа. Батшугар сайд салбарт хэдийгээр шинээр очсон ч гэсэн салбарын ер нь санхүүгийн болон эрх зүйн орчныг, тэрнээс гадна ЭМД-тай холбоотой асуудал дээр их онцгой шуурхай ажиллаж байгаа гэж ойлгож байгаа. Мэдээж өмнөх сайдууд ч гэсэн зохих түвшинд хичээж ажилласан, өмнөхийг нь үгүйсгэж болохгүй. Тэгэхээр энэ дээр та бүхэн яах вэ гэж байгаа юм. Ингээд цаашдаа ингээд иргэд маань өндөр үнэтэй эмийг халааснаасаа төлсөөр байх уу, ЭМД-ын сангаас бид өндөр үнэтэй юм авч өгсөөр байх уу, эсвэл сонголттой болох уу? Энэ дээр яг ямар менежмент хийх вэ гэсэн ийм тодорхой асуулт.

П.Ганзориг: Батшугар сайд хариулъя.

Э.Батшугар: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Одоогийн хэрэгжиж байгаа хууль, дүрмийн дагуу ДЭМБ-ын хатуу зохицуулалттай улс орон гэж байдаг. Нэлээн өндөр стандарт тавьсан тийм эмийг л түргэвчилсэн байдлаар бүртгэнэ гэсэн тийм заалт байгаад байгаа юм. Энэ нь яг үндсэндээ Ази улсдаа гуравхан улс орон тэр стандартыг баримталдаг нь Япон, Солонгос, Сингапур, Европын холбоонд харьцангуй гайгүй хэрэгждэг, мөн Америкт хэрэгждэг. Тэгээд таны хэлсэнтэй адилхан энэ ICH гэдэг нь зайлшгүй мөрдөгдөх ёстой. Энэ яг үнэндээ юу юм билээ, International Council for Harmonisation гэж англиар нь ярьдаг, нэг ёсондоо олон улсад хөгжсөн, өндөр чанарын эм, ялангуяа хамгийн хүнсний болон эмийн өндөр шалгалт авдаг Европын холбооны улс орнууд бүрэн зөвшөөрөгдсөн байгаа юм.

Үүнтэй холбоотойгоор, жишээлбэл, Турк улсын жишээг авмаар байна. Турк улс Европын холбооны улс руу маш их хэмжээний эмийн экспорт гаргадаг, Европын холбооны үнийг хүлээн зөвшөөрдөг. Эмийн үнийн дүнгийн хувьд харьцангуй бага, хямдхан гэж ойлгож болно. Тэгсэн мөртөө дотоодын нийт эмийн хэрэгцээнийхээ 98 хувийг өөрсдөө хангадаг. Тэгэхээр энийг Монгол Улс зайлшгүй нэвтрүүлэх нь зөв гэж яг салбарын сайдын хувьд харж байгаа юм. Энийг ойрын хугацаанд хийнэ гэж гишүүнд хэлмээр байна. Яагаад гэвэл үр дүнд нь энэ Монгол хүний эрүүл мэнд, Монгол хүний эмийн хэрэглээ, чанартай, хямд өртөгтэй эмийн хэрэглээний асуудал яригдаж байгаа болохоор.

П.Ганзориг: Буланы Бейсен гишүүн асуулт асууя.

Б.Бейсен: Энэ би салбарын эмч хүн учраас санаа зовсондоо энэ асуудлыг тавьсан. Заримдаа сая би хэллээ, төсвийн юун дээр. Эрүүл мэндийн төсвийг Сангийн яамныхан дур мэдэн хасаад хаячихдаг ерөөсөө, ялангуяа эмийн төсөв, урсгал зардлыг нь хасаад хаячихсан зарим юмнууд энэ төсвийг нь тавьж өгөх асуудал байгаа. Тэгээд энэ яамнаас түрүүн яг 2026 оны 5 дугаар сарын 30-ны байдлаар энэ өр зээлийг нь авсан л даа хотын клиникийн эмнэлгүүдийн. 1 дүгээр эмнэлэг 13 тэрбум, энэнээс эм нь болохоор 12.8 тэрбум юм байна, бусад гээд өөр зээл байх юм. Бусад гэдэг дээр, жишээлбэл, 2 дугаар эмнэлэг дээр 3 тэрбум 89 сая,

3 дугаар эмнэлэг дээр 1.2 тэрбум, Гэмтэл согог дээр 3 тэрбум, Хавдар дээр 4.5 тэрбумын бусад гээд өр зээлүүд байж байна.

НДШ 1 дүгээр эмнэлэг дээр байхгүй байна, 3 дугаар эмнэлэг дээр байхгүй байна, цалин нийгмийн даатгал байна. Зарим дээр нь 3-3,8 жишээлбэл 2 дугаар эмнэлэг дээр, Халдварт дээр 4.3 тэрбум, Сэтгэц дээр 4.6 тэрбум байна. Энэ нь ямар учиртай юм бол? Аймгууд дээр энэ өндөр байна л даа, аймгуудыг яриад яах вэ, дүүргүүд дээр байж байна. Өр зээлийн асуудал дээр чинь зарим нь 6 тэрбумын өртэй, яг энэ 5 дугаар сарын 26-ны байдлаар, зарим нь 7 тэрбум, 6.8 тэрбум гэх мэт Налайхын эмнэлгүүд гэх мэт энэ өр зээлийг яах вэ?

Дараагийн асуудал энэ урамшууллаа өгч чадахгүй байна уу? Энэ цалин, НДШ гээд, аль эсвэл нийгмийн даатгалдаа ЭМД энэ тэр, тэр юугаа хийж чадахгүй байгаа юм уу? Ямар учиртай юм? Илүү ажилтан авчхаад, төсвийн захирагч орон тоог нь хэтрүүлчхээд байна уу? Энэ юутай холбоотой юм бол, дараа нь тодруулъя.

П.Ганзориг: Батшугар сайд хариулъя.

Э.Батшугар: Бейсен гишүүний асуултад хариулъя. Ер нь яг салбарын яг өнөөдрийн байдлаар манай салбарт 220 тэрбумын зээл байгаад байгаа юм, өр зээл. Үүний 121 тэрбум нь эмийн, эм ханган нийлүүлэлтийн компанийн зээл, тэд нарт өртэй байгаа эмнэлгүүд. 80 тэрбум нь юу байна, Нийгмийн даатгалын шимтгэлийн зээл. Тэгээд энэ эмнэлгүүдээ ингэж харахад 10 эмнэлэг л их асуудалтай байгаад байна яг асуудалтай байна. Танд яг хэлэхэд энэ нь бараг 70 тэрбумын зээлтэй аравхан эмнэлэг эзлээд байгаа юм. 2 дугаар эмнэлэг 19 тэрбумын өр зээлтэй, ХӨСҮТ 7, тэгэхдээ энэ ХӨСҮТ 7 өөрөө онцгой, та мэдэж байгаа. Нөгөө халдварт өвчин дэгдэлт гэхээр гүйцэтгэлийн санхүүжилт аваад байдаг, энэ нь нийгэмд муу, бусад үедээ санхүүжилт авдаггүй, энэ нь нийгэмд сайн гээд ийм 2 салгаа байгаад байдаг юм. Багануур 6.6 тэрбумын өр зээлтэй, Налайх, Багахангай, Налайх 6... Энэ түрүүн хэлсэн энэ маш том байгууламж, бараг 100-аас 200 мянган хүнд зориулсан эмнэлэг барьчихсан, нөгөө хүн ам нь ёсондоо нэг Чойртой л адилхан байж байгаа шүү дээ. Тэгэхээр урсгал зардал нь маш өндөр. Эх нялхас 9.7 тэрбумын зээлтэй, Чингэлтэй дүүргийн дүүргийн эмнэлэг 4.1, Өмнөговь 6 тэрбум, Дундговь 2.6 тэрбум, Орхон аймаг 4.3 тэрбум, Дархан 3 тэрбум гээд.

Энэ асуудлыг 2 зүйлийг хэлмээр байна. 1 дүгээрт, энэ цэвэр менежментийн асуудал байгаа юм. Жишээлбэл, Дундговьтой яг адилхан хүн амтай Сэлэнгийн Мандал сумын эмнэлэг менежмент нь маш сайн, тэгээд эерэг гараад байдаг, ашигтай гараад байдаг. Тэгэнгүүт Дундговь маш их хүний нөөц нь тэлчихсэн, дээрээс нь зардал өндөртэй, менежмент муутай, алдагдалтай. Аль эсвэл Хавдар судлал байгаад байгаа юм, ашигтай ажиллаж байгаа. 2 дугаар эмнэлэг тэгэхэд 19 тэрбумын зардалтай. Тэгэхээр би түрүүн хэлсэн энэ ЗГ-ын 134 дүгээр тогтоол гараад эмнэлэг болгон дээр KPI батлаад, тэр KPI-ийг нь мөрдөөд явна. Мөн нэмж хэлэхэд, 2 дугаар эмнэлэг дээр ЗГ-аас хэрэгжүүлэх агентлагаас шалгалт оруулсан байгаа. Чиг үүргийн болон санхүүгийн шалгалт хийнэ, яагаад энэ хэмжээний зээл гараад байна, өр үүсгээд байгаа юм бэ, үйлдвэрлээд байгаа юм бэ, яагаад энийгээ шийдэж чадахгүй байна гээд.

Нэмж хэлэхэд яг 6 дугаар сарын байдлаар бид манай яамнаас болон ЭМД-ын газар, агентлаг нийтдээ зуугаад тэрбумын нэмж санхүүжилт олгож байгаа юм

эмнэлгүүддээ. 100 тэрбумын 50 хувь болох 60 тэрбумыг нь шууд эмийн компаниудын өрийн төлөө гэж байгаа юм. Нэг ёсны 121 тэрбумаас 60-ыг нь төлчих, 50 хувиар төлөөд, тэгээд үе шаттайгаар ондоо багтаагаад тэглэх. Нийгмийн даатгал шимтгэл талдаа ахиад 40 тэрбумыг нь 6 дугаар сардаа багтаагаад төлчихнө, тэгээд ирээдүйдээ ондоо багтаагаад өргүй болох тийм хүсэлт явуулж, шаардлага явуулж байгаа гэж ойлгож болно. Тэгээд эцсийн үр дүндээ би юу гэж харсан бэ гэхээр яг л эмнэлгийн дарга нарын асуудал маш хүнд асуудал юм байна. Үнэхээр сайн менежерүүд байна. Үнэхээр чанаргүй гэх юм уу, эмнэлгээ муу удирдаж авч явж байгаа, өр үүсгээд байгаа нөхдүүд байна. Жишээлбэл нэг эм худалдаж авахдаа хавдрын бай эмчилгээний эмийг нэг эмнэлэг яг адилхан нэг компанийн эмнэлгийг 1 сая 800 төгрөгөөр авчхаж байгаа юм. Өөр нэг эмнэлэг яг тэр бай эмчилгээний эмийг 3 сая 700 мянган төгрөгөөр авчхаад байгаа юм. Тэгэхээр ирэх жил нэгдсэн худалдан авалт хийнэ. Үүнтэй холбоотойгоор гэж хэлмээр байна. Тэгээд гэх мэтчилэн энэ аль менежментийн асуудал, нэгдсэн худалдан авалт байна, ахиад КРІ байгуулаад ингээд эмнэлгүүдийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхээс гадна менежментийг нь сайжруулаад урсгал зардлыг нь бууруулна гэж хэлье

П.Ганзориг: Ерөнхий газрын дарга Батбаатар нэмж хариулах уу, эсвэл та тодруулах уу? Тодруулчихъя Бейсен гишүүн.

Б.Бейсен: Нийтдээ 240 тэрбумын өр байна. Энэнээс цалин, НДШ-ийнх нь 86 тэрбум, эм 124 тэрбум, бусад гээд 29.4 тэрбум байж байх юм. Энэ бусад өр зээл нь юуных юм бэ 1 дүгээрт?

2 дугаарт, энэ хувийн эмнэлгүүд өндөр өртөгтэй онош хамааралтай бүлгийн багцаас хэдэн хувийг нь авдаг юм бэ? Хувийн эмнэлгүүд тэгээд хэчнээн тэрбум төгрөг, хэдэн эмнэлэг тийм ийм өндөр өртөгтэй эмийг авч байна. Эд чинь өндөр өртөгтэй юм авчхаад төлбөртэй үйлчилж байна. Өнөөдөр нэг нугасны хагалгаа Грандмед дээр орох гэсэн чинь 8 саяар, 8.5 саяар ор гэсэн гэнэ. 32 жилийн хугацаанд багшаар ажиллаж байгаа хүн, тэгээд өнөөдөр би 3 дугаар эмнэлэг гуйж байгаад танайх нэг орж өгөөч гээд, тэгсэн чинь дугаар байхгүй тийшээ явлаа. Тэгэхээр чинь ийм улсууд хувийн эмнэлгүүдийн яг авч байгаа санхүүжилтийг нь тодорхой хэлж өгөөч?

П.Ганзориг: Батшугар сайд хариулъя.

Э.Батшугар: Өнгөрсөн оны 10 дугаар сараас эхлээд хувийн эмнэлгүүдэд санхүүжилт олгохоо больчихсон, зөвхөн 5 оношны бүлэг дээр олгож байгаа одоогийн байдлаар. Яаралтай тусламж үйлчилгээ, хавдрын хими эмчилгээ, хавдрын бай эмчилгээ, диализ, тэгээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусламж үйлчилгээнд олгож байгаа. Тэгээд энэ онд нэг сараас өнөөдөр хүртэл 30 тэрбумыг олгочихсон байгаа. Нэг юмыг би зориуд хэлмээр байна. Өмнөх онуудад нэлээн замбараагүй олгож байсан байна лээ. 24 онд гэхэд л 293 тэрбум, 25 онд 182 тэрбумыг олгож байсан. Ингэхдээ нэг асуудал харагдсан байна. Юу гэхээр хязгаар тавиагүй олгож байсан, тэгэнгүүт оны эхнээс сар болгон гүйцэтгэлийн санхүүжилтийг нь хязгааргүй олгож, олгож байгаад 10 сар, 11 сарын үед өр тавиад, тэгээд дараачийн ондоо ахиад нэг сард нь тэр өрийг нь дараад ингээд яваад байсан, урьдчилаад байсан. Одоо тийм зүйл байхгүй болчихсон гэж би Бейсен гишүүнд хэлье.

П.Ганзориг: Батбаатар дарга нэмж хариулъя, тэгье. Наадах чинь индэр дээрээс хариулахгүй бол нээгдэхгүй байх.

Ц.Батбаатар: Хувийн эмнэлгүүдийн санхүүжилтийн хувьд 2024 онд 183 тэрбум төгрөгийн санхүүжилтийг даатгалын сангаас авсан, 2025 онд 183, 25 онд 293 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан. Хувийн эмнэлгүүдээс хамгийн их үзүүлдэг тусламж үйлчилгээг нь зардлаар нь аваад үзэх юм бол нэгдүгээрт гемодиализын тусламж үйлчилгээ байна. Энэ дээр 2024 онд нийт 21.6 тэрбум төгрөгийн санхүүжилт, 25 онд 22.7 тэрбум төгрөг. 2-т нь сувиллын тусламж үйлчилгээ байна. 2024 онд 23.7 тэрбум төгрөг, 25 онд 12.6 тэрбум төгрөг. 3-т нь уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээгээр санхүүжилтийг өндөр авсан байна. 2024 онд 16 тэрбум төгрөг, 25 онд 7.9 тэрбум төгрөг, мөн амбулаторийн цогц тусламж үйлчилгээгээр 2024 онд 16.3 тэрбум төгрөг, 25 онд 5.2 тэрбум төгрөг.../минут дуусав/

П.Ганзориг: Гүйцээж хариулъя.

Ц.Батбаатар: Хавдрын дараах химийн эмчилгээгээр 24 онд 3.2 тэрбум төгрөг, 25 онд 4.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хувийн эмнэлгүүд авсан байна. Эдгээр нь хувийн эмнэлгүүдэд нь ямар оношийн хамааралтай бүлгээр илүү гэрээтэй гэдгээсээ шалтгаалж өндөр өртөгтэй оношийн хамааралтай бүлгээр гэрээтэй бол илүү өндөр санхүүжилтийг авч байгаа ийм тохиолдлууд бүртгэгдсэн.

П.Ганзориг: Индэр дээрээс нэмж хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Бейсен гишүүний асуултад тодруулж хариулъя. Энэ бусад зардал гэдэг энэ ангиллууд байж байгаа. Ер нь зардлын 20 гаруй эдийн засгийн ангилал байж байгаа, бусад гэдэг дээр бид түрүүн хэлж байгаануудаас үлдсэн зардлууд буюу энэ дээр эмнэлгийн багаж, техник хэрэгслийн зардлууд байж байгаа. Энэ дээр бүх төрлийн мэс заслын гэдэг юм уу дурангийн хагалгааны мэс заслын иж бүрдэл, унтуулга гээд ингээд бүх энэ зардлууд орж байгаа.

2 дугаарт нь урсгал засварууд орж байгаа. Энэ дээр оношилгооны тоног төхөөрөмжүүд, лабораторийн шинжилгээний аппаратууд, түргэн тусламжийн автомашинууд гэдэг юм уу эрүүл мэндийн байгууллагууд ашиглаж байгаа энэ автомашинууд, хүчилтөрөгчийн үйлдвэрийн засвар үйлчилгээ, сантехник гээд ингээд, тэрнээс гадна өвчтөний хоол үйлчилгээ гээд энэ орж байгаа, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээнүүд орж байгаа харуул хамгаалалтын зардал, бусад гэрээний дагуу хийгдэж байгаа энэ шинжилгээний зардлууд, баталгаажуулалтууд, эмч дуудлагын төлбөр гээд ингээд энэ зардлуудаа нийлээд бид бусад гэж үзээд байгаа. Тэгээд энэ өндөр дүнтэй байгаад байгаа нь гишүүнээ, энэ нөгөө нийт дүнгээрээ гаргачихсан, ер нь энэ дотор ингээд хөрөнгө оруулалтын барьцааны зардал.../минут дуусав/

П.Ганзориг: Гүйцээж хариулъя. Батшугар сайд гүйцээж хариулъя.

Э.Батшугар: Түрүүн минут дуусчихлаа. Одоо бол нийт өр төлбөрийг бууруулах, мөн төвлөрлийг бууруулах талаар нийтдээ 212 тэрбумын санхүүжилтийг эмнэлгүүдэд болон орон нутгийн эмнэлгүүдэд нэмж санхүүжилт олгож байгаа. Үүний 81 тэрбум нь цэвэр төвлөрлийг бууруулах тал дээр явж байгаа. Мөн цаашлаад 8

дугаар сардаа багтаагаад хувийн эмнэлгүүдийн сонгон зарлах төлөвлөгөөтэй байгаа. Гэхдээ шалгууртай зарлана. Эхний ээлжид тухайн бүс, орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээний шаардлагыг харна, 2-т нь эмнэлгийн чадамжийг харна. Яг тухайн эмч тэнд ажиллаж байна уу, үгүй юү гээд. 2-т нь яг эмнэлгийн мэргэжлийн аппаратыг харна. Жишээлбэл, рентгений аппарат нь байна уу, үгүй юү гээд. Өмнө нь юу болсон бэ гэхээр интернэтээс, Google-ээс рентгений төхөөрөмжийн зураг авчхаад, тэрийгээ Эрүүл мэндийн даатгалын сан руу явуулсан тийм кэйсүүд байгаа юм байна лээ. Яг үндсэн аппарат нь тусламж үйлчилгээ үзүүлж чаддаггүй эмнэлгүүд авсан. Тэгэхдээ тийм зүйл гаргахгүй гэсэн тийм сахилга баттай ажиллаж байгаагаа танд хэлмээр байна.

П.Ганзориг: Гишүүд, та хоёр тодруулчихсан шүү дээ, тийм үү. Бейсен гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Тэгэхээр ийм байгаа одоогийн ЭМЯ-ны удирдлагууд, Эм, эмнэлгийн хэрэгслийн газрынхан ер нь сайн ажиллаж байгаа гэж үзэж байгаа би энэ ЭМД-ынхан цэгцэлж эхэлж байна. Тэгэхдээ нэг асуудал байна. Энэ эмнэлгийн бүтэц орон тоог бид шинэчилж баталж өгөхгүй бол ерөөсөө энэ дураараа орон тооны хэтрэлт, дураараа давраад ерөөсөө хамаагүй юм тавьж байгаа. Би эмнэлгийн дарга хийж байсны хувьд мэдэж байна шүү дээ, 100 хэдэн орон тоогоор нэмээд хаячихсан, юу гэсэн үг юм энэ чинь.

2 дугаарт, энэ ЭМД-ын сангаас хөнгөлөлттэй 680 эмийн 200 нь бүртгэгдээгүй байна гээд байх юм. Тэгээд эм авч чадахгүй, зарим хавдрын эмүүд тэр үнэн юм уу, худлаа юм уу, тэр талын тодорхой мэдээлэл өгөөч?

3 дугаарт энэ Эм, эмнэлгийн хэрэгслийн газар энэ дээр нэг сайн хяналт хийгээд, ... эм гээд тендерээр ороод аягүй өндөр үнээр эмийн төсөв чинь ихэнх нь тэнд явж байгаа, энийг болиулахгүй бол эмийн төсөв чинь хүрэхгүй шүү. Энэ талаар мэдээлэл өгөөч?

П.Ганзориг: Батшугар сайд хариулъя.

Э.Батшугар: Бейсен гишүүний асуултад хариулъя. Тантай 100 хувь санал нэг байна. Менежментийн тал дээр бүр хорьхон ортой мөртөө 200 хэдэн эмч нар авчихсан тийм эмнэлгүүд байгаад байгаа юм. Тэгээд яг үүнтэй холбоотой яг KPI батлаад, суурь KPI-ийг нь баталж өгөөд, тэгээд тухайн захиралд нь тодорхой хэмжээнд хариуцлага үүрүүлээд явна. Мөн эмнэлгүүдийг дийлэнхийг нь ТУЗ-тэй болгоод, ТУЗ нь өөрөө сонгон шалгаруулалт зарлаад, тэгээд хамгийн сайн менежерийг тухайн эмнэлгийн захирал болгох нь зүйтэй. Мөн нэгдсэн худалдан авалтын төлөвлөгөө батлахгүйгээр яг одоогийн байдлаар эмнэлгүүд тус тусдаа тендер зарлаад эм аваад байна. Энийг би түрүүн хэлсэн, нэг эмийг тас өөр үнээр аваад байгаа юм. Тэгэхээр нэгдсэн худалдан авалт зарлаад, бүх Монгол Улсын ЭМЯ-ны доорх төрийн эмнэлгүүд 360 тэрбум төгрөгийн эмийн худалдан авалт хийдэг, энийг бүгдийг нэгдсэн байдлаар зарлаад, хамгийн сайн чанартай болон хямд өртөгтэй эмийг худалдан авахаар тийм төлөвлөгөөтэй явж байгаа гэж танд хэлье.

П.Ганзориг: Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гэсэн нэрсээ өгье? Бейсен гишүүний асуусан асуултад бичгээр нэмэлтээр мэдээллүүдийг нь

ирүүлээрэй. Би нөгөө нэмэлтээр тайлбар аль, аль талаас нь хэд хэдэн удаа нэмж хариулууллаа шүү дээ. Үг хэлэх гишүүд нэрсээ өгсөн байна, Бейсен гишүүнээр тасаллаа. Сархадын Зулпхар гишүүн үг хэлье.

С.Зулпхар: Холбогдох асуудлаар мэдээлэл өгч байгаа Эрүүл мэндийн сайд, холбогдох албаны улсуудад талархсанаа илэрхийлье. Нөгөөтээгүүр яах вэ салбарт болж бүтэж байгаа болгоё гэж байгаа зүйлийг сонсох сайн байна. Олон нийт дандаа болохгүй байгаа юм сонсохоос гадна болж байгаа болон болох гэж байгаа зүйлийг сонсож байх нь их зөв, нийгэм эерэг мэдээлэлтэй, тэр эерэг мэдээллийнхээ дагуу итгэл үнэмшилтэй л байх ёстой шүү дээ. Ингэж байж улс орон өөрөө урагшилдаг байх.

Би Батшугар сайдын өгсөн мэдээллүүд дээр нэг чухал зүйлийг их олзуурхаж байна. Юу гэхээр зэрэг бид үйлчлүүлэгчээ бодсон байдлаар энэ эм, эмнэлгийн хэрэгсэлтэй холбоотой менежмент, шинэ удирдлагыг нэвтрүүлж байна гэж байгаа юм. Мэдээж энэ урьд нь яригдаж байсан зүйл, та шуурхай нэвтрүүлж байгаа юм байна. Нэг зүйл их тодорхой шүү дээ. Ер нь эрүүл мэндийн үйлчилгээ насны бүлгээс хамаараад их тийм эрэлт ялгаатай байдаг. Бага насны хүүхэд болон ахмадуудад эрүүл мэндийн үйлчилгээ нэмэгдчихдэг юм. Энэ хүн амын хүн ам чинь их онцлог л доо. Тэгээд энийгээ дагаад өрхийн эдийн засагт юм уу, эсхүл тэтгэврийн насны хүний тэтгэвэрт ингээд нөлөөлдөг. Энх-Амгалан сайд сууж байна, Энх-Амгалан сайд сайн мэдэж байгаа. Ахмадуудын ер нь тэтгэврийн 30-аас 35 хувь нь эмийн хэрэглээ рүүгээ явчихдаг байхгүй юу. Ингээд ирэхээр зэрэг бид эм, эмийн хэрэгслийг саяын хэлсэн сонголттой болгоход чиглэсэн энэ менежментийг нэвтрүүлэх ёстой байгаа.

Одоо байгаа Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар бид чинь сайн стандарт нэвтрүүлнэ гэж л бодсон байх л даа. Үндсэндээ энэ сонголтыг хязгаарлаад хаячихсан зүйл оруулчхаж байгаа. Тэр үед зөвийг бодож л хийсэн байх. Гэхдээ энэ өөрөө менежментийг хязгаарласан, тэгээд цаашлаад иргэдийн, өрхийн эдийн засагт, ахмадуудын саяын хэлсэн орлогод шууд нөлөөлсөн ийм шийдвэр гарчихсан байгаа байхгүй юу. Та сая өөрөө хэлж байна. Хавдрын тодорхой эмчилгээтэй холбоотой тэр эм нь өөрөө 2 эмнэлэг 2 өөр үнээр худалдаж авч байна гэж байна шүү дээ. Нэг эмнэлэг нь 1 сая 700-гаар, нөгөөх нь 3 сая 500-гаар худалдаад авсан гэж байна. Энэ бол тэнд менежмент алдагдсаны сонгодог жишээ.

Гэтэл цаана нь сонголтыг бий болгоно гэдэг өөрөө их чухал. Бид өндөр стандарт тавьдаг нь сайн. Гэтэл тэр стандарт Сингапур, Япон болон Солонгост хэрэгжиж байгаа байхгүй юу. Энэ 3 улс чинь өндөр хөгжилтэй орон, цаана нь ажиллах хүчнийх нь жишээ нь цалин хөлс нь их өндөр байдаг учраас эмийнх нь өртөг өндөр байхгүй юу. Технологийн түвшин нь сайн байх л даа. Гэтэл яг технологийн түвшин ижил мөртөө ажиллах хүчний хувьд хөдөлмөрийн хөлс нь бага учраас эм, эмнэлгийнх нь жишээ нь эмийнх нь үнэ нь бага байдаг улсууд байгаа байхгүй юу. Энэтхэг байна, маш өндөр технологийн үйлдвэрлэлтэй эмийн бид хэрэглэдэг. Цаана Европын улсуудыг хэлэх юм Унгар байна, Словени байна, хамгийн өндөр түвшний эмийн үйлдвэрлэлтэй улсууд шүү дээ, Турк байна. Гэтэл тэнд тодорхой эм Солонгосоос авах ёстой эмээс 2 дахин бага байхад бид авч чадахгүй ийм хуулийн нөхцөл байдалтай байж байгаа юм. Тэгэхлээр зэрэг энийг та бүхэн сайн мэдэж байгаа юм байна, энэ чиглэлээр тодорхой бодлого барьж байгаа юм байна. Би жишээ нь талархалтай байна, иргэдийн нэрийн өмнөөс мэдээж хэрэг би ч гэсэн хэрэглэгчийн хувьд талархалтай байна. Тэгэхлээр энэ дээр та бүхэн

мэдээж шаардлагатай хуулийнхаа төслийг оруулж ирээч. Бид энэ хуулийн төслийг шаардлагатай бол шуурхай дэмжье.

Өмнөх улсуудын гаргасан шийдвэрийг үгүйсгэж байгаа юм биш, зөвийг бодож, сайныг бодож л гаргасан шийдвэр байх. Гэхдээ тэр гаргасан шийдвэр нь өөрөө сорилт дагуулчхаж байна. Тэгэхлээр бид энэ сорилтыг даван туулах шийдлийг шуурхай хийх ёстой. Хууль 2 нөхцөлд л өөрчлөгддөг юм шүү дээ. Нэг бол өөрчлөлтийг бий болгохын тулд хууль өөрчилдөг, нэг өөрчлөгдсөн нөхцөл байдлыг шийдвэрлэхийн тулд хууль өөрчилдөг, аль ч нөхцөлд нь энэ бол хууль өөрчлөгдөх ёстой болчихсон байна гэдгийг хэлж байна. Тэгээд манай ЭМД-ын сангийн менежмент ч гэсэн зохих түвшинд сайжирч байгаад талархалтай байна, баяртай байна. Та бүхэн мэдээж хэрэг энэ сорилттой тулгарсан, энэ сорилтыг давах ёстой. Сангийн менежмент өөрөө их чухал зүйл. Сангийн менежмент мэргэжлийн байж чадах юм бол үр дүнгээ өгдөг, мэргэжлийн байдал нь алдагдаад магадгүй улс төрийн нөлөө, янз янзын нөлөө ороод эхлэх юм бол энд маш их сорилт дагадгийг харлаа. Тэгэхлээр энэ чиглэлээр та бүхэн цаашдаа яг энэ санаачилгаа бүрэн үргэлжлүүлж, үр дүнг нь.../минут дуусав/

П.Ганзориг: Буланы Бейсен гишүүн үг хэлье.

Б.Бейсен: Би энэ 4 төрлийн асуулгын хариу авах гээд өгсөн. Эрүүл мэндийн салбарт ер нь төсөв хэмнэх боломж байгаа, төсвийн ерөнхий захирагч менежерүүд муу ажиллаж байна гэж бодож байгаа ерөөсөө. Гарынхаа салаагаар төсвөө урсгаад явуулчихдаг. Эм батлахдаа ч гэсэн стандартаар баталдаггүй, зуны цагт ялангуяа ингээд 6, 7 хүүхдүүд тарснаас хойш чих, хамар, хоолой, арьс өнгө, сүрьеэ, өөр юу билээ, энэ 4 тасагт хүн хэвтдэггүй байхгүй юу. Гэтэл бүгдийг нь зуны цагт амруулчихаад, оронд нь түр сувилагч аваад ажиллуулчихдаг нөгөөдүүл нь. 300 сувилагч аваад ажиллуулахад тэгээд дуусна шүү дээ тэр нь төсөв нь ингээд урсаад явчхаж байгаа юм чинь. Тийм учраас энэ дээр ЭМЯ, эмнэлгийн менежерүүдэд нь тодорхой хэмжээний юм ярих шаардлагатай. Нөгөө талаар илүү орон тоо их байгаа. Хүний нөөцийн дарга, мэргэжилтэн 2, 3 хүн болчихсон, даргын нарийн бичиг, тэгээд 1 хүний нөөц гээд нэг л хүн байхад тэгээд бүгдийг нь анкетыг нь аваад л болоо шүү дээ тэр чинь. Тэгээд бүх албуудад нэмсэн, 2, 3 даргатай болсон. 7, 8, 10 машинтай байхад 12, 13 жолоочтой гэх мэт илүү орон тоо их байна. Тийм учраас энэ бүтэц орон тоог бид нийлж байгаад энийг батлаад шинэчилж өгөхгүй бол хуучин 72 оны нэг, 13 оны нэг, дараа нь 17 оны нэг бүтэц стандарт, энүүгээр ч замбараагүй юм батлаад байсан. Тухайн үед би эсэргүүцээд дийлээгүй юм. Бодит яг Монгол орны хөрсөнд буусан бүтэц орон тоог нь баталж өгөхгүй бол болохгүй байна.

Нөгөө талаар гишүүдийн багцаар ч очсон юм байж байна, ЭМЯ-ны хөрөнгө оруулалт олон улсын байгууллага /ОУБ/-аар очсон тоног төхөөрөмжүүд байж байна. Ажиллахгүй сумууд дээр бүтээгээд тавьчихдаг, тэнд ажил хийхгүй олон улсууд байж байгаа. зүгээр цалин аваад л явж байдаг, бүртгүүлээд л явж байдаг. Дагалдан сургах ерөөсөө юу байхгүй, сэтгэл байхгүй, дагалдуулан сургаад тэр аппаратуудыг ажиллуулах хэрэгтэй байгаа юм. Би энэ гишүүдийн багцынхаа юмыг ихэнхийг нь эрүүл мэнд, боловсрол дээр тавьдаг жил болгон, энэ жил ч гэсэн би дахиад түргэний машин тавьсан, ноднин тавьсан нөгөө түргэний машин ирж байгаа болов уу, үгүй болов уу, 3 машин тавьсан, тийм асуудлууд байж байгаа юм. Тийм учраас энэ дээр нэлээн хамтраад ажиллаад, тоног төхөөрөмж дээр нь анхаарахгүй бол зүгээр хөдөө сумууд дээр чинь цалин аваад л түгжихээд л яваад байна шүү дээ ерөөсөө, хайран

тоног төхөөрөмж. Хөдөө сумууд дээр чинь цус, шээс, биохими, ЭКГ, ЭХО, хавдрын маркер үздэг, тэгээд болбол рентгентэй байвал тэгээд өөр юм хэрэггүй шүү дээ. Аймаг руу явахгүй, улсууд тэндээ эмчилгээ хийлгээд байж болж байгаа юм чинь.

Нөгөө талаар энэ эмийн үнэ ерөөсөө буухгүй байна. Эмийн үнэ дээр, эмийн төсөв ихэнх нь тэр лабораторийн хаалттай систем гэдэг дээр ... хийгээд авдаг ерөөсөө, одоо бүр үнэ нь 2, 3 нэмэгдсэн. Энийг ерөөсөө задлаад ер нь зах зээлийн үнээр авахгүй бол энэ ерөөсөө бүх юм тийшээ яваад байгаа шүү төсвийн ихэнх нь, энийг анхаарахгүй бол болохгүй асуудлууд байж байгаа юм. Нөгөө талаар энэ эмийн тендер дээр анхаараад сая нөгөө төвлөрсөн юугаар, хуучин хангаж байсан юмаар хангахгүй бол бас болохгүй асуудлууд байж байгаа. Энэний цаана нь, тендерийн цаана нь авлигын асуудал байдаг байхгүй юу. Энийг би сайн мэднэ, тийм учраас энэ дээр нэлээн анхаарч ажиллах шаардлагатай байгаа. Нөгөө талаар эмч, мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх асуудал дээр нэлээн анхаарахгүй бол болохгүй. Оношилгооны төв 4 аймаг гэхгүй, аймаг болгонд эмнэлгийн байр нь бэлэн байж байгаа юм чинь MRI аппарат, ... аппарат тавьчихаад, тэгээд эмч мэргэжилтнийг нь сургахад тэр оношилгооны төв тэр. Мэргэжилтнүүдээ сургах хэрэгтэй. Тэгвэл хот руу ирэх асуудал саарна. Байшин барилга нь бэлэн байж байгаа юмыг бид ашиглаж чадахгүй байна шүү дээ. Тиймээс ийм юман дээр анхаарч ажиллана, хамтарч ажиллая. Эмч хүний хувьд санаа зовоод.../минут дуусав/

П.Ганзориг: Гишүүдийн асуусан асуулт, хэлсэн үгтэй холбоотой гарсан саналуудыг анхаарч ажиллахыг хүсье. Эрүүл мэндийн салбарын санхүүжилт, эмийн үнэ, хүний нөөц, цалин хөлсний талаарх мэдээллийг хэлэлцэж дууслаа. Ажлын хэсгийн гишүүдэд талархал илэрхийлье.

19.44 цаг

Дараагийн асуудалдаа оръё. Энэ чинь 12 хүртэл хуралдана шүү дээ бид чинь. Өнөөдөр ганцхан манай Байнгын хороо л явж байх шиг байна.

Тав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны 2025 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Боловсролын сайдын мэдээллийг сонсох

ЗГ-т чиглэл өгөх тухай Байнгын хорооны 2025 оны 5 дугаар тогтоолын биелэлтийн талаарх Боловсролын сайдын мэдээллийг сонсоно. Ингээд Боловсролын сайдыг танилцуулга хийхийг хүсье.

Л.Энх-Амгалан: Байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгон зарласантай холбогдуулж УИХ-ын Байнгын хорооны Монгол Улсын ЗГ-т чиглэл өгөх тухай 4 чиглэл бүхий 31 заалт бүхий тогтоолыг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр баталсан. Энэ хүрээнд Монгол Улсын ЗГ эмхлэн зохион байгуулагдаж, Монгол Улсын ЗГ-аас Монгол хүүхдийг мэдлэгийн хоцрогдлоос чөлөөлье, Монгол хүүхдийг ур чадварын хоцрогдлоос чөлөөлье гэдэг энэ бодлогыг ЗГ-аар батлуулж, мөн сая УИХ-аар батлагдсан 27 оны улсын хөгжлийн төлөвлөгөөнд энэ төлөвлөгөө маань ингээд орсон байгаа. Яг энэ төлөвлөгөөний дагуу ерөнхийдөө ЗГ-т чиглэл өгсөн энэ тогтоолын бүх заалтууд нь энэ төлөвлөгөөнд заалт бүрээр орсон байгаа. Энийг би

УИХ дахь улс төрийн намын бүлэг Монгол Ардын нам /МАН/-ын бүлэг, АН-ын бүлэг, ХҮН намын зөвлөлд бас танилцуулсан учраас өнөөдрийн хийх гэж байгаа энэ танилцуулгыг товчилъё гэж бодож байна. Тэгээд бүх гишүүдэд дэлгэрүүлсэн танилцуулгыг хүргүүлсэн байж байгаа.

Мэдээж ЗГ-т чиглэл өгөх тухай энэ тогтоол СӨБ, мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсрол, насан туршийн боловсролын түвшинд хийгдэх ёстой ажлуудын чиглэлүүд өгөгдсөн. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын чиглэлээр мэдээж чанар, хүртээмжийн асуудал. Тэгээд ЗГ-аас хэрэгжүүлэх Монгол хүүхэд бүрийг мэдлэгийн хоцрогдлоос чөлөөлөх энэ бодлогын хүрээнд гэрт ойрхон сургууль хамгийн сайн сургууль гэсэн энэ бодлогыг дэвшүүлж, ингээд сум дундын 200-аас доош хүүхэдтэй байгаа сургуулиудыг бид шинэчлэн зохион байгуулж, сум дундын 200-аас доош хүүхэдтэй сургуулиудыг 9 жилийн тогтолцоо, сум дундын ахлах сургуулиудыг зохион байгуулах, аймгууд дээр Кембрижийн /Cambridge/ тогтолцоотой ахлах сургууль, бүс дээр Кембрижийн тогтолцоотой ахлах сургууль, Улаанбаатар хотод 3 мянгаас дээш хүүхэдтэй байгаа 3800 сургуулиудыг шинэчлэн зохион байгуулж, нэг бүлэгт 35 хүүхдээс дээшгүй байхаар зохион байгуулахын тулд хотхоны бага сургуулиудыг зохион байгуулах, төрөлжсөн ахлах сургуулиудыг зохион байгуулах энэ ажлуудыг хийж байна.

Гэрт ойрхон сургууль хамгийн сайн сургуулийг хийх энэ бодлогын хүрээнд бид 6 шинэчлэлийг харж байгаа. Энэ 6 шинэчлэлийн хүрээнд энэ ЗГ-аас өгөх чиглэл дээр энэ 6 чиглэлүүдийг нэг бүрчлэн оруулсан байгаад би талархаж байна. Энэ хөтөлбөрийн шинэчлэл, багшийн хөгжлийн 3 тулгуурт бодлого, ингээд хүүхэд бүрийн хувьсах зардал, мөн үнэлгээний тогтолцоо, 5-д нь сургууль, цэцэрлэгийн менежментийг сайжруулах, эцэст нь боловсролын салбарын дижитал шилжилтүүдийг хийх энэ 6 ажил, томоохон бодлогын ажлуудыг хийхээр ингэж төлөвлөгдсөн байж байгаа. Мөн англи хэлийг 5 дугаар ангиас заадаг байсныг 3 дугаар ангиас заадаг ийм тогтолцоонд бид шилжсэн. Энэний бэлтгэл ажлуудыг бид хийж байна.

Хүртээмжийн хувьд мэдээж хамгийн чухал асуудал байгаа. Тэгэхээр бид Улаанбаатар хотод өндөр ачаалалтай сургуулиудыг өөрчлөн зохион байгуулах асуудлуудыг хийж, УИХ-ын гишүүн Галбадрахаар ахлуулсан ажлын хэсэгтэй хамтарч ажиллаж, судалгаагаар 108 сургууль, 95 цэцэрлэгийг 30 он хүртэл өргөтгөх, барих шинэ тооцоонууд гарсан. Энийг бид АХБ /ADB/, Дэлхийн банк /World Bank/-ны хөнгөлөлттэй зээл болон төр, хувийн хэвшлийн түншлэлээр зохион байгуулахаар ингээд ажиллаж байна.

Мэргэжлийн болон техникийн боловсролын хувьд өнгөрсөн сард бид энэ Монголын томоохон ААН, Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран ажиллах санамж бичгүүдийг зуруулсан. Энэ санамж бичигт сургалтын байгууллагууд хувийн хэвшилтэй түншилж ажиллаж хамтарсан сургалт зохион байгуулах, суралцангаа ажиллах, ажиллангаа суралцах, сургалтын хөтөлбөр боловсруулах, судалгаа хийх, үйлдвэрлэлийн орчинд хосмог ажлын байрны сургалт зохион байгуулах, дэд бүтэц, хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлууд ингэж хийгдэж байна. Мөн удахгүй энэ АХБ-ны 20 сая долларын хөнгөлөлттэй зээлээр бид ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа загвар коллежуудыг төрөлжүүлж, мөн энүүгээр сургалт, судалгаа, үйлдвэрлэлийн чиглэлийн сургалтын баазуудыг барьж байгуулах ажлуудыг хийхээр зорьж байна. Мөн олон улсын Жайка /JICA/ байгууллагын

буцалтгүй тусламжийн хүрээнд Косэн /Kosen/ хөтөлбөр хэрэгжүүлэх ажлуудыг коллежийн дундын дадлага, сургалтын бааз барьж ажиллах зэрэг энд чиглүүлнэ гэж харж байна.

Дээд боловсролын хүрээнд бид томоохон дээд боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлнэ, манай Дээд боловсролын тухай хууль маш сайн хууль гарсан. Харамсалтай нь өнгөрсөн хугацаанд Дээд боловсролын хуулиа бид бүрэн хэрэгжүүлж чадсангүй. Энэ хуулийнхаа дөнгөж хуулиар олгогдож байгаа томоохон энэ боломжуудын 30 хувийг л ашиглаж байна гэж ойлгож байгаа. Ингээд цаашдаа бид холбогдох журамд өөрчлөлт оруулж, Монгол Улсад чанартай дээд боловсрол буюу 20 их сургууль, бусад нь коллежийн тогтолцоонд шилжүүлэх энэ ажлыг олон улсын Times Higher Education зэрэглэл тогтоодог энэ байгууллагуудтай хамтарч ажиллаж, хөдөлмөрийн зах зээл, боловсролын салбарын уялдааг хангах чиглэлээр хөдөлмөрийн зах зээлийг холбосон их өгөгдлийн платформуудыг боловсруулж, энэ намар гэхэд бид бэлэн болохоор ажиллаж байна.

Мөн Боловсролын зээлийн санг хөгжлийн сан болгох ажлыг бид Улсын Их Хурал, юу Засгийн газрын хуралдаанаар танилцуулсан байгаа. Өнгөрсөн хугацаанд энэ Боловсролын зээлийн сан дээр үүссэн асуудлууд дээр бид нэг мөр цэг тавих, ингээд Боловсролын зээлийн санг Хөгжлийн сан болгож, суралцагчдын гэрээг дүгнэх, зээлийн эргэн төлөлтийн хугацаа, төлөвлөгөөг бодитой тооцох, гэрээний үүргээ биелүүлсэн суралцагчдын асуудлыг бүрэн шийдвэрлэж дуусгах, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төгсөгчдийн орлогоос хамаарсан уян хатан эргэн төлөлтийн тогтолцоо, сайн төлөгчийг дэмжих урамшууллын тогтолцоо бий болгох, салбар хоорондын их өгөгдлийг боловсруулж, ингээд Боловсролын зээлийн сангийн 2.0 гэдэг хөгжлийн хувилбарууд дээр бид ажиллаж байна. Энийг удахгүй энэ мэргэжлийн Байнгын хороон дээрээ энэ концепцуудыг танилцуулна.

Мөн багш нарын, боловсролын салбарын цалингийн асуудал дээр тодорхой үл ойлголцол үүссэн байсан, энийг бид энэ үл ойлголцол дээр цэг тавьж, нэг цалингийн тогтолцоонд шилжүүлсэн ийм ажлуудыг өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлээ гэдгийг ингээд товчлоод хэлчихье гэж бодож байна. Холбогдох танилцуулгыг Байнгын хорооны гишүүдэд хүргүүлсэн байгаа.

П.Ганзориг: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Т.Ням-Очир ТНБД, П.Оюунаа Боловсролын сайдын зөвлөх, Х.Тамир Боловсролын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, А.Мөнх-Оргил Боловсролын эдийн засаг, санхүү бодлогын газрын дарга, Б.Түмэндэлгэр Дээд боловсролын бодлогын газрын дарга, Л.Ганбат Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна. Танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгье? Зулпхар гишүүнээр тасаллаа. Сархадын Зулпхар гишүүн асуулт асууя.

С.Зулпхар: Баярлалаа. Богино хугацаанд боловсролын хөгжлийн жилийн хүрээнд хийсэн ажлуудын үр дүн гарч байгаад маш их талархалтай байна. Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны гишүүд энэ тогтоолын төслийг санаачилж, манай Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо үүнийг дэмжиж, бид тогтоолын төсөл батлуулж байсан. Өнгөрсөн жилийн 11 дүгээр сарын 25. Тэрнээс хойш богинохон хугацаа л даа. Тэгэхдээ богинохон хугацаа боловч та бүхний урьд нь хангасан бэлтгэлүүд байсан, тодорхой бодлогын шийдлүүд байсан.

Мэдээж хэрэг, жишээ нь салбарыг мэдэж байгаа сайдын өөрийнх нь ажлын арга барил ч байгаа байх, өмнөх сайдын ч гэсэн тодорхой ажлын үр дүнг залгаж байгаа байх. Тэгэхээр үр дүн сонсох сайхан байна. Цаашдаа энэ үр дүн үргэлжлэх ёстой. Тэгэхдээ би их олон асуулт байгаа учраас асуугаад, асуугаад явчихъя гэж бодож байна.

Англи хэлний хувьд сургалтыг шинэ шатанд гаргана гэсэн, ингээд сургалтууд хийгдээд явж байна. 3 дугаар ангиас жишээ нь заагдах байх. Хэчнээн багш энэ сургалтад хамрагдаад байж байна, ямаршуу үр дүн гарч байна гэсэн 1 дүгээр асуулт?

2 дахь зүйл маш чухал, үр дүн гаргачихсан байна. Тэртээ тэргүй бид хиймэл оюун ухааныг сургалтад битгий хэл нийгмийн бүх хүрээнд хэрэглэхээр болчихсон байгаа. 3 дугаар ангиас эхлээд энэ компьютерын хичээлийн агуулгад орж ирсэн юм байна. Энэ чиглэлээр багш нар сургалтад хамрагдсан уу? Бид багш нараа хамруулъя гэсэн, тийм ээ, эхнээсээ хамрагдаж байгаа гэсэн мэдээлэл байгаа. Энэ хэчнээн багш хамрагдав, багш маань бэлтгэл хэр хангаж байна гэсэн 2 дахь асуулт байна?

3 дахь зүйл Боловсролын зээлийн санг Хөгжлийн сан болгоё гэдэг энэ үг Энх-Амгалан сайдаас өөрөөс нь гарч байсан. Бид энийг зөвхөн зээл олгодог сан биш, үндсэндээ боловсролоо хөгжүүлэхэд ашиглах ёстой сан гэж ойлгож байсан. Энэ байдлаар Засгийн газар 6 дугаар сарын 10-нд эхнийхээ шийдвэрийг гаргачихсан юм байна. Тэгэхлээр зэрэг цаашдаа энэтэй холбоотой бодлогууд орж ирэх юм байна. Энэ санг зөвхөн гадаад явж сурахтай холбоотой биш, гадаадаас их дээд сургуулиудын, боловсролын байгууллагуудад багш урьж ажиллуулах чиглэлээр ер нь бид ашиглая гэдэг ийм санал гарч байгаа юм. Энэ бодлого дээр та бүхэн ямар байр суурьтай байгаа вэ гэсэн асуулт байна?

5 дахь асуулт дээд боловсролын сургалтын байгууллагуудын суралцагчдын тоог тодорхой хөтөлбөрөөр шүү дээ, энэ хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэе гэдэг ийм асуудлыг ярьж байсан юм байгаа юм. Энэ судалгааг та Хөдөлмөрийн сайд байх үедээ хийж байсан, энийг та маш тодорхой ярьдаг байсан. Энэ хөтөлбөрүүдийг хөдөлмөрийн зах зээлтэй уялдсан байдлаар ямар нэгэн байдлаар код тогтоохгүй бол болохгүй юм байна гэж байсан. Тэгэхлээр энэ чиглэлээр энэ ямар байр суурь, ямар чиглэл байна вэ гэсэн асуулт байгаа юм?

Энэ санхүүгийн түрээсийн асуудал, энийг 2025 оны төсөв батлах үед энийг би яг тогтоолын төсөлд оруулж энийг батлуулж байсан юм. Энэний үр дүн эхнээсээ гарч байгаа юм шиг байна, та энийг үргэлжлүүлэх нь зүйтэй гэсэн ийм чигтэй байгаа юм байна. Энэ дээр ямар үр дүн гарч байна вэ гэсэн нэг ийм асуулт байгаа юм.

П.Ганзориг: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Англи хэлний бэлтгэл хэр зэрэг хангагдаж байна вэ гэж. Ингээд 3 дүгээр ангиасаа бид англи хэл зааж эхэлж байгаа, энэ хүрээндээ бид энэ Pearson гэж Английн компанитай хамтран энэ үндэсний хэмжээнд энэ платформ хэрэгжүүлж байгаа. Энэ багшийн ур чадварыг нөхөх, багшийн ачааллыг бууруулах, хүүхэд өөрөө хиймэл оюун ухааны багштай ингэж ярих, унших энэ ур чадваруудаа дэмжихэд маш том дэмжлэг болж байгаа ийм платформ байгаа, цаашдаа ч гэсэн

энэ Pearson платформ манай үндэсний англи хэлний нэг хөтөлбөр болоод ингээд явна. Ингээд өнгөрсөн хугацаанд намайг боловсролын сайдаар ажиллаж байх хугацаанд Их Британи, Умард Ирландын Гадаад хэргийн сайд, тухайн үедээ Англи улсын ерөнхий сайд байсан хүн ирж 10 сая фунтийн буцалтгүй тусламжийг үзүүлэх энэ чиглэлээр бид нарт амлалтуудыг өгсөн. Ингээд өнгөрсөн хугацаанд энэ 10 саяын 1.1 сая фунт стерлингийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 1655 багшийг чадваржуулж, мөн англи хэлнийхээ 5 жилийн стратеги төлөвлөгөөг батлуулж авсан их том ажлууд хийгдсэн гэж харж байгаа. Цаашдаа бид энэ Улаанбаатар хот, орон нутагтай хамтарч энэ Филиппинээс олон багш нар авчрах энэ ажлуудыг зохион байгуулж байна. Энэ харьцангуй хямд өртөгтэй бөгөөд богино хугацаанд үр дүнд хүрэх их томоохон ажил гэж ингэж харж байгаа.

Боловсролын зээлийн сангийн тухайд Боловсролын хөгжлийн сан болгож, цаашдаа энэ Боловсролын зээлийн сан дээр үүссэн байгаа асуудлуудыг хөрөнгийн сангийн менежментээр Endowment сан болгон хөрөнгийн сангийн менежментийг хувийн хэвшлийн мэргэжлийн хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компаниар удирдуулах нь зүйтэй юм. Энэ зөв хэлбэр байх юм гэж харж байгаа. Мөн Хуримтлалын сан ганцхан ипотекийн зээл биш ипотека, эрүүл мэнд, боловсролын чиглэлээр тодорхой иргэдэд энэ боломжуудыг олгодог ийм сантай болсон. Энэ сангаас бид удахгүй анхны удаа боловсролын санд, боловсролын хөгжлийг дэмжих санд анхны хуримтлалуудыг хийх энэ ажлын тооцоо судалгаануудыг хийж байгаа. Хамгийн гол нь Боловсролын зээлийн сан, Хөгжлийн сан яг хүүхэд бүрд хүртээмжтэй, ил тод, Монгол Улсад эрэлттэй тэргүүлэх мэргэжлээр хүний нөөцөө бэлдэх хөшүүрэг болсон ийм шинэ тогтолцоо байх ёстой. Тэгээд шинэ нүүр царайгаар, шинэ бүтцээр, шинэ санхүүжилтийн схемээр, шинэ менежментээр ажиллах энэ ажлуудын концепцыг удахгүй мэргэжлийнхээ Байнгын хороон дээр танилцуулна гэж бодож байна.

Хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой асуудал манай өнөөдрийн хөдөлмөрийн зах зээл дээр үүссэн ур чадварын гайп /gap/ гэж ярьдаг, ур чадварын эрэлт нийлүүлэлт дээр маш том гажуудал гарсан байгаа. Энгийг өнгөрсөн хугацаанд би Хөдөлмөрийн сайдаар ажиллах ийм боломж надад гарлаа. Ингээд хөдөлмөрийн зах зээл дээр үүссэн энэ эрэлт нийлүүлэлт, ур чадварын эрэлт нийлүүлэлтийг яаж энэ боловсролынхоо салбартай уях вэ, хамгийн гол асуудал энэ үндэсний мэргэжлийн шаталсан бүтэцтэйгээ энэ боловсролынхоо системүүдийг яаж нэг систем болгож ажиллах вэ, энийгээ дундын энэ хөдөлмөрийн зах зээлийнхээ мониторинг хийдэг их өгөгдлийн платформуудыг яаж бий болгох вэ гэдэг энэ нэлээн том сорилт бий болж байна. Энэ хүрээнд Ерөнхий сайдын захирамжаар хоёр яамны хамтарсан, надаар ахлуулаад Аубакир сайд дэд дарга болоод, тэгээд ТНБД нар, яамдын голлох мэргэжилтнүүдийг оруулсан энэ ажлын хэсэг гарч, цаашдаа энэ хөдөлмөрийн зах зээл, мөн энэ YAMAT гэж ярьдаг, үндэсний ажил мэргэжлийн тодорхойлолтуудад үндэслэж Үндэсний мэргэжлийн шаталсан бүтцүүдээ хөдөлмөрийнхөө зах зээлтэй, боловсролынхоо салбартай уях ажлуудыг зохион байгуулахаар ингээд ажиллаж байна.

П.Ганзориг: Зулпхар гишүүн тодруулъя.

С.Зулпхар: Баярлалаа, бас нэг зүйл тодруулъя. Таныг өмнө нь энэ салбарыг хариуцаж байх үед таны нэг эхлүүлсэн ажил байгаа юм. Их сургуулиудын дэргэд Инновац, технологийн төв байгуулах, эхнээсээ байгуулагдсан, бид очиж ажилласан,

тодорхой үр дүнгүүд гарчихсан байна л даа. Тэгэхээр энийг цаашид яах бодлого барих вэ гэсэн нэг ийм асуулт байна?

2 дахь зүйл, энэ төр, хувийн хэвшлийн түншлэлээр энэ сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийг барих боломжийг хамтдаа судалъя гэж байна шүү дээ. Энэ барих-шилжүүлэх загвар байдаг, тийм ээ, жишээ нь энэ загвараар богино хугацаанд барих боломжийг бид ер нь эрэлхийлэх үү гэсэн ийм асуулт байгаа юм энэ бол?

3 дахь асуулт, та сая хэлсэн аутсорсинг, аутсорсинг энэ төрийн зарим үйлчилгээний албан дээр гаднаас нь аваад ашиглаад, тэгээд тэрийгээ үр дүнтэй зохион байгуулах нэг ийм хэлбэр л дээ. Энэ чиглэлээр та түрүүн төсвийн танилцуулга дээр хэлж байх шиг байна гүйцэтгэл дээр, яг энэ дээр яам ямар.../минут дуусав/

П.Ганзориг: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Дээд боловсролын түвшинд бид энэ өмнө нь эхлүүлсэн реформуудаа жаахан эрчимжүүлнэ. Чанартай цөөн их сургуультай, мэргэжил болон техникийн коллежийн чанартай ийм коллежуудын тогтолцоо руу шилжүүлнэ. Маш товчхоноор хэлэхэд өнөөдөр их дээд сургууль дээр 150 гаруй мянган оюутнууд байгаа, мэргэжлийн боловсрол дээр 40 мянга байгаа, энийгээ л энэ буруу харсан гурвалжныгаа л зөв харуулъя гэж бодож байгаа шүү дээ. Чанартай их дээд сургуулиуд, их сургуулиуд дээр 40 гаруй, 40-өөс 60 мянган оюутан суралцдаг, бусад нь мэргэжлийн болон техникийн коллеж дээр суралцах, цаашдаа сургалт, судалгаа, үйлдвэрлэлийн энэ Triple Helix гэж ярьдаг энэ тогтолцоог нэвтрүүлэх ийм зайлшгүй шаардлага байгаа. Энэ үүднээс манай их сургуулиуд дээр анхны энэ эндаумент сангууд байгуулагдсан. МУИС, Шинжлэх ухаан, технологийн их сургуулиуд дээр эндаумент сангууд байгуулагдсан. Ингээд их дээд сургуулиудын дундын удирдах зөвлөлүүдээ өнгөрсөн Засгийн газрын хурлаар байгуулсан. Энэ чиглэлээр нэлээн төрийн өмчийн их дээд сургуулиудынхаа засаглалыг сайжруулах чиглэлд нэлээн анхаарч.../минут дуусав/

П.Ганзориг: Гүйцэж хариулъя.

Л.Энх-Амгалан: Боловсролын салбарт дан ганц төсвийн хөрөнгөөр санхүүжүүлдэг энэ нөөц хязгаарлагдмал. Тийм учраас цаашдаа бид энэ бариад, ашиглаад, шилжүүлэх, ВОО гэх мэтчилэнгээр ингээд олон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрүүдийг гаргаж ирнэ. Бид Дэлхийн банктай 150 сая долларын хэлэлцээрт орж байна. Энэ Улаанбаатар хотод өндөр ачаалалтай байгаа 40-өөс 50 сургуулийг хувийн хэвшил нь бариад, хувийн хэвшлээсээ би 10-аас 15 жилийн хугацаанд санхүүгийн түрээсээр ашиглах энэ боломжуудыг хайж ажиллаж байгаа. Ингээд саяын chromebook-ийг бид Хөгжлийн банк, санхүүгийн түрээсийн хэлбэрээр хийхээр ингэж шинэ, яг манай боловсролын салбараас төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамгийн зөв хэлбэрүүдийг гаргах энэ чиглэл рүү бид эхний төсөл, арга хэмжээнүүдээ ингэж төлөвлөж ажиллаж байгаа нь хамгийн зөв хэлбэр байх болов уу гэж ингэж харж байна.

П.Ганзориг: Зулпхар гишүүн тодруулъя.

С.Зулпхар: Баярлалаа, их чухал диалогууд явчихлаа. Мэргэжлийн боловсрол дээр бидний хувьд нэг тийм сорилт байсан, тэр нь юу гэхээр зэрэг дадлагын баазын асуудал. Дадлагын бааз дээр энэ янз янзын хэлбэрээр, жишээ нь бид шинэ эрэлхийлэл байх ёстой гэж үзэж байсан, энэ тогтоол дээр ч гэсэн орсон юм байгаа юм. Үүнтэй уялдсан зохих үр дүнгүүд гарч байна гэсэн зүйл ярилаа, энийг та бидэнтэй хуваалцаач.

2 дахь асуудал, би санхүүгийн түрээсийг дахиж тодруулъя гэж байгаа юм. Сургалтын орчныг, жишээ нь богино хугацаанд бид орчин үеийн технологиор, техникээр, жишээ нь хангахын тулд энэ их чухал арга хэрэгсэл болчихлоо л гэж ойлгож байна л даа. 25 оны төсөвт оруулснаас хойш. Энийг цааш нь үргэлжлүүлэх үү? Үүнийг та Байнгын хорооны гишүүдэд ямар байдлаар энийг санал болгох вэ, эсхүл яаж зөвлөх вэ гэж байгаа юм. Бид харилцан бие биетэйгээ энэ бодлогын асуудлыг ярилцах ёстой шүү дээ. Энэ дээр та ямар байр суурьтай байна вэ?

П.Ганзориг: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Бид энэ дадлагын баазууд, дундын лабораториуд, дундын дэд бүтцүүдээ хуваах, share хийх энэ чиглэл рүү ер нь энэ төрийн болон хувийн коллеж, их сургуулиудынхаа хамтын ажиллагааг нэлээн сайжруулна. Бидэнд маш их том нөөц байгаа юм байна лээ, тэрийгээ ашиглаж чадахгүй байгаа. Тийм учраас энэ дээр нэлээн дундын ийм зохицуулалтууд зайлшгүй шаардлагатай байгаа гэж харж байгаа. Тийм ч учраас би нэлээн тэргүүлэх Монголын компаниуддаа энэ төрийн өмчит коллежуудынхаа менежментийг сайжруулах энэ мастер гэрээг хийж байгаа шүү дээ. Тэгээд энэ хүрээнд нэлээн ажлууд зохион байгуулагдах болов уу гэж бодож байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд энэ санхүүгийн түрээсийн хэлбэрээр эхний ээлжид ямар ч байсан бид компьютер, тоног төхөөрөмж, энэ ухаалаг самбараас авхуулаад түргэн элэгддэг, технологи нь хурдан хуучирдаг энэ тоног төхөөрөмжүүдийг бид санхүүгийн түрээсээр явах нь илүү төр талдаа ч, төсөв талдаа ч илүү үр өгөөжтэй, хамгийн зөв хэлбэр байх болов уу гэж ингэж харж байгаа.

П.Ганзориг: Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Зулпхар гишүүнээр тасаллаа. Сархадын Зулпхар гишүүн үг хэлье.

С.Зулпхар: Маш их баярлалаа. Бид өнөөдөр ингээд эрүүл мэндийн салбарын чиглэлээр тодорхой ажлуудыг сонсож байна, боловсролын салбараас тодорхой ажлуудыг сонсож байна. Засгийн газар урдаа тавьсан зорилтуудаа зохих түвшинд хэрэгжүүлэхийн тулд шуурхай ажиллаж, үр дүнгүүд гаргаж байгаагийн илэрхийлэл байна. Мэдээж сорилтууд байгаа, нийгмээс янз янзаар шүүмжилж байгаа нөхцөл байдлууд байгаа. Аль ч цаг үед, аль ч нийгэмд тодорхой жишээ нь сорилтууд байдаг, тэр сорилтуудыг давах чиглэлээр харин шуурхай ажиллаж байгаа нь иргэдэд мэдээлэл болох ёстой байх гэж бодож байна.

Би саналуудаа хэлье. Энэ англи хэлний жишээ нь сургалт 3 дугаар ангиас орох нь тэртээ тэргүй хуульчлагдсан зүйл. Бид дэлхийтэй ойртохын тулд ямар нэгэн гадаад хэлийг сайн сурсан байх ёстой бол энэ англи хэл гэдгийг хуульчилсан. Энэтэй холбоотой сургалтууд явж байна, гаднаас багш нар ирж сургалт орж байна. Энэ сайн хэлбэр. Дараагийн нэг хэлбэр байгаа. Бид хиймэл оюун ухаанаар англи хэлний сургалтыг явуулахыг чухалчилж байгаа шүү дээ. Энэ бэлэн платформууд

байгаа, энийг ашиглах ёстой. Би Монгол хүүхдүүд, Монгол залуучууд дор хаяж 2-оос 3 хэл мэддэг байх ёстой гэж боддог хүн. Тэгж байж бид дэлхийтэй ойртох, тэгж байж бид улс орныхоо хөгжилд хувь нэмэр оруулах ёстой учраас энийг чухалчилж байгаа, энэ дээр анхаараач гэж байгаа юм.

Сургуулийн хүртээмжтэй холбоотой сорилтууд гараад ирлээ. Энэ жишээ нь олон жил ашиглалтад ордоггүй, олон жил дамнуулаад төсвийг нь ингээд нэмээд яваад байдаг. Үүнтэй маш богино хугацаанд бид шаардлагатай шийдлүүдийг нь олоод, арга замыг нь олоод давах ёстой. Сая жишээ нь сайд хэлж байна шүү дээ, энд сүүлдээ тал талын жишээ нь хариуцлагагүй байдал байгаа бол энийг бид богино хугацаанд шийдье, тэр битгий хэл төр, хувийн хэвшлийн түншлэлээр цаашдаа сургуулиудыг нэг жилд нь бариад ашиглалтад оруулдаг, зардал нь нэмэгддэггүй ийм байдал руу орёе гэж байна. Энэ дээр бид зоригтой байх ёстой шүү гэж байгаа юм. Үүн дээр Байнгын хорооны гишүүд ч тэр, Их Хурлын гишүүд ч тэр бүрэн дэмжиж ажиллах ёстой. Бид 21 дүгээр зууны 26 онд байгаа бол тохирсон аргыг заавал ашиглах ёстой гэдэг үүднээс үүнийг би зориуд санал болгож байна.

Боловсролын зээлийн сан, зээлийн сан дээр бид хэлэлцэж байх үед ийм зүйл хэлсэн Энх-Амгалан сайдаа. Юу гэхээр зэрэг энэ зөвхөн гадаадад явж сурах бакалавр юм уу, магистр, докторын түвшний оюутнуудын асуудал биш. Бид гадаадаас багш нарыг авчраад энд байгаа их дээд сургуулиудын чадавхыг, жишээ нь дээшлүүлэх чиглэлээр энийг ашиглах ёстой. Энэ угаасаа сайн туршлага, дэлхийн улс орнуудад хэрэглэдэг. Бид 100 оюутан явахаас илүүтэйгээр 10 профессор авчрах нь хамаагүй бага зардалтай, их сургууль чадавхжих ёстой. Бид зөвхөн оюутнуудаа гадагшаа явуулах биш, өөрийнхөө их сургуулиудыг гаднын их сургуультай өрсөлдүүлэх ёстой, гаднын профессор ирж байж хөтөлбөр сайжирдаг, багш нарын чадвар сайжирдаг. Энэ дээр энэ сайн туршлагыг би бүр зориуд олон удаа ярьсан. Энийг би та бүхнийг энэ санг Хөгжлийн сан болгох үедээ онцгойлон анхаараач гэж байгаа юм. Бид сайн туршлагаа илэн далангүй ярьж, бие биетэйгээ шийдлийн төлөө байх ёстой, бидний хэн ч гэсэн, жишээ нь Монгол Улсын хөгжлийн төлөөлөл байгаа шүү дээ, энэ байгаа бол зарим сайн зүйлээ ингээд л ярих ёстой гэж байгаа юм.

Таны нэг хэлсэн зүйлийг би сайшааж байна. Хөдөлмөрийн зах зээл угаасаа эрэлт, нийлүүлэлт. Тэр эрэлт, нийлүүлэлтийг зөв тооцох, тэрэнд тохирсон бид зохицуулалт хийх ёстой. Энийг бид шинэ хуульд ч гэсэн бараг оруулъя гэж ярьж байгаа шүү дээ. Та сая хэлж байна, YAMAT-г бид шинээр тодорхойлно. Тэрнээс гадна хөдөлмөрийн зах зээл дээр ямар мэргэжлээр, ямар салбарт хэчнээн ажилтан шаардлагатай, тэрэнд тохирсон квот тогтооно л гэж байгаа юм. Угаасаа тэгэх ёстой, тэгж байж бид явах ёстой. Тэгэхгүй нөгөө сурчхаад ажилгүй байгаа хүүхэд чинь өрхийн эдийн засагт ч сайн биш, улс орны эдийн засгийн хөгжилд ч ямар ч нэмэргүй ийм байдал үүсчхээд байгаа юм. Өртгийг нь бид тооцох юм бол хэдэн арав, хэдэн зуун тэрбумаар тооцогдох ийм нөхцөл байдал үүсэж байгаа учраас энэ боловсролын эдийн засаг талаасаа, хөгжлийн эдийн засаг талаасаа маш чухал асуудал учраас үүн дээр таны анхаарч байгааг би сайшааж байна. Яг энэ дээр та манлайлал үзүүлээд ажиллаж чадна гэдэгт итгэлтэй байна. Та бүхэн бүгдээрээ энийг хагас жилийн хугацаанд ийм үр дүн гаргасан, дараагийн хагас жилээр буюу энэ оны төгсгөлд илүү үр дүн бид хамтдаа үзнэ гэдэгт.../минут дуусав/

П.Ганзориг: Рэгдэл гишүүнийг нэмье. Рэгдэл гишүүн үг хэлье. Та бүртгүүлээд орчихсон уу? Рэгдэл гишүүний микрофоныг нээе.

Д.Рэгдэл: Баярлалаа. Тэгээд энэ 2025 оны 05 дугаар тогтоол их олон заалттай, ер нь их ярьж байж л гаргасан тогтоол л доо. Тэгээд тогтоолын заалт бүрээр манай Боловсролын яам маш тодорхой ажил хийсэн юм байна, ер нь ахиц дэвшил илт харагдаж байна. Тэгээд хамгийн чухал юм бол 27 он гээд багш нарын цалин, ерөнхий боловсролын багш нарын цалин 3 сая 500 мянга орчим руу очих болов уу гэж бид хүлээж байгаа. Тэгээд тэр тал дээр нэлээн ажил ажиллагаа шаардах байх. Тэр хэмжээнд оччих юм бол ер нь багш нарын хүрэлцээ, манай хүрээлэнгүүдээс дунд сургуулийн багш больё гээд байгаа улсууд байгаа. Цалин нэмэгдээгүй.

Тэгээд “Чи 28 оноос энэ багшийн илүүдэл болчихвол яах юм” тэгж хэлж байж нэг жаахан тогтоох юм байх шиг байна. Ер нь цаашдаа бид энэ дээд боловсрол, шинжлэх ухааны салбарыг хамтад нь авч явмаар юм шиг байгаа юм. Ер нь дэлхийн жишиг тэр. Том улсууд яах вэ, Шинжлэх ухаан, технологийн яамтай, дунд зэрэг, томдоо орох улсууд үндсэндээ Дээд боловсрол, шинжлэх ухааны яамтай ингээд авч явдаг. Манайх 2 жилийн өмнө Засгийн газрын бүтцийг батлахдаа ер нь төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах нь зүйтэй учраас бодлогын төв яаманд шинжлэх ухааны салбараа аваачъя гээд ярьж, ярьж байгаад л 23 цаг 40 минут хуралдсан билүү яалаа, тэр орой чинь тэгээд Эдийн засаг, хөгжлийн яаман дээр шинжлэх ухаан маань очсон. Зөндөө асуудал үүсэж байгаа.

Хамгийн гол нь ерөөсөө Эдийн засаг, хөгжлийн яамны бодлогын шинжлэх ухааны үндсэнд нөлөөлж чадахгүй байна. Бүтцийн хувьд энэ шинжлэх ухааны газар нь Эдийн засаг, хөгжлийн яамны бусад газруудтайгаа интеграци болж ажиллаж чадахгүй байна. Тэгэхээр цаашдаа бид энэ 2027 оны төсөв хэлэлцэхдээ шинжлэх ухааны салбарыг Боловсролын яаман дээр нь буцааж аваачих, улмаар БШУЯ-аа дахиж байгуулах энэ тал руу их анхаарч ажиллах нь зөв юм байгаа юм. Шинжлэх ухааны салбар бол одоо 27 оны, 26 оны төгсгөлөөр шинэ байрандаа ороод ажиллах орчин сайжирна. Эдийн засаг, хөгжлийн яамнаас ярьж байгаа, баримталж байгаа бодлогоороо эрдэм шинжилгээний ажилчдын цалин 3 сая 500 мянга руугаа 27 онд очих шинжтэй байгаа. Тэгээд зөв бүтцэдээ орчих юм бол хүлээгдэх үр дүн, гарах үр нөлөө нь нэмэгдэнэ гэж ингэж тооцож байгаа юм. Ингээд Боловсролын яамны шинэ бүрэлдэхүүн, хуучин танилууддаа ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.

П.Ганзориг: Гишүүд үг хэлж дууслаа. Байнгын хорооны хурлаар өнөөдөр Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны 2025 оны 05 дугаар тогтоолын биелэлтийн мэдээллийг сонсож дууслаа. Тэгээд Их Хурлын гишүүдээс гарсан саналуудын Боловсролын яам, төлөөллүүд ажил хэрэг болгож ажиллахыг хүсье. Ялангуяа Зулпхар гишүүн маань өөрөө нэлээн тодорхой саналуудыг, асуултуудыг тавилаа.

20.13 цаг

Өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Тэгээд цаг заваа гаргаж, орой болтол сууж, мэдээллээ танилцуулсан нийт Боловсролын яамны төлөөлөл,

хуралдаанд суусан Их Хурлын гишүүддээ талархал илэрхийлье. Мөн Байнгын хорооныхоо ажлын албанд талархал илэрхийлье. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА